




United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



МЭДЭЭЛМИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН МЭДЭЭЛМИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ



БАГШ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



КЭРОЛИН УИЛСОН
ЭЛТОН ГРИЗА
РЭМОН ТЮЭЗОН
КУЭЙМ АКЪЕМПОНГ
ЧИ-КИМ ЧЭЮН



МЭДЭЭЛЛИЙН
ХЭРЭГСЛИЙН БОЛОН
МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ
БОЛОВСРОЛ

БАГШ НАРТ ЗОРИУЛСАН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

Сургалтын хөтөлбөр ба
мэдлэг чадварын ерөнхий хүрээ

ХОЁРДУГААР БҮЛЭГ:

Үндсэн болон
үндсэн бус сэдвүүд

Энэхүү гарын авлагыг НҮБ-ийн Боловсрол Соёл Шинжлэх Ухааны байгууллагын Бээжин дэх төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр монгол хэлнээ хөрвүүлэв.

7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France
Communication and Information Sector
www.unesco.org/webworld

© UNESCO 2011

Бүх эрх хамгаалагдсан болно.

ISBN 978-92-3-001115-4

Энэхүү хөтөлбөрийг хариуцсан мэргэжилтнүүдийн болон номонд орсон бүхий л материал нь аливаа улс орны бүрэн эрх, газар нутаг, хот, бүс нутаг болон тэдгээрийн засаг захиргаа, хилийн зааг хязгаартай холбоотой ЮНЕСКО-гийн байр суурийг илэрхийлээгүй болно. Номонд орсон баримт материалын сонголт болон танилцуулга, үзэл бодол зэрэг нь ЮНЕСКО-гийн байр суурь, бодлоготой холбоотой байх албагүй бөгөөд тэдгээрийн төлөө тус байгууллага хариуцлага хүлээхгүй.

Хянан тохиолдуулсан Элтон Гризл, Кэролайн Уилсон

Гэрэл зургийн эх сурвалж, оюуны өмчийн эрх
Нүүр хуудас (зүүнээс баруун, дээрээс доош):

1. © АйСтокфото (iStockphoto)
 2. СС Родриго Гэлиндес
 3. © АйСтокфото
 4. © 2008 Эдисон И. Уитни, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
 5. © 2005 Эднан Кабир, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
 6. © АйСтокфото
 7. © АйСтокфото
 8. © 2007 Ражал Тэкер, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
 9. © АйСтокфото
 10. © АйСтокфото о
 11. © АйСтокфото
 12. © 2005 Элэйн Б. Лэбрик /JHSPH, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
- 13 болон 43 дугаар нүүр (зүүнээс баруун, дээрээс доош):

1. СС Видео сайн дурын ажилтнууд (VV)
2. © 2009 Др. Юрвиш Жоши, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
3. © 2006 Хаф Ригби /ССР, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
4. СС Видео сайн дурын ажилтнууд (VV)
5. © 2008 Боб Мсэнги, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
6. © 2009 Фредерик Норуна, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
7. СС С Жей-Кей
8. © 1997 ССР, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
9. © 2007 Рэжал Такер, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв

10. © 2001 ССР, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
 11. © 2007 Эрүп Халдар, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
 12. © 2008 Эдсон И.Уитни, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
- 58-р нүүр: СС Родриго Гэлиндес
77-р нүүр: © Нэгдсэн Үндэсний Байгууллагын гэрэл зураг /Мартине Перрет
90-р нүүр: © 2008 Эдсон И.Уитни, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
100-р нүүр: © Европын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллага / Стефан Вайкслер /Австри улс
106-р нүүр: СС Горски
117-р нүүр: © 2003 Жастин Фаи, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
125-р нүүр: © 2006 Хаф Ригби/ССР, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
133-р нүүр: © 2006 Сара Фельдман, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
144-р нүүр: © 2007 Уилиам Онгэла, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
152-р нүүр: СС Видео сайн дурын ажилтнууд (VV)
157-р нүүр: © 2009 Доктор Юрвиш Жоши, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
170-р нүүр: СС Видео сайн дурын ажилтнууд (VV)

- р. 174: © 2007 Альфредо Л.Форт, гэрэл зургийг ашиглахыг найрсгаар зөвшөөрөв
р. 176: СС Пол Келлер Үсгийн хэвийг ЮНЕСКО-гоос ЮНЕСКО-гоос хэвлэн гаргав.
Эх хувийг Франц улсад хэвлэв. CLD 491.11

ЮНЕСКО-гийн дүрэм:

“...Боловсрол хүртэх бүх нийтийн бүрэн бөгөөд эрх тэгш эрхийг хүндэтгэн, бодит үнэний төлөө зогсолтгүй эрэл хайгуул хийж, мэдлэг, санаа бодлоо чөлөөтэй хуваалцсан, энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн улс үндэстэн бүр иргэдийнхээ мэдээллийн харилцаанааны бүхий л арга хэрэгслийг хөгжүүлж, тэдгээр хэрэгслийг харилцан ойлголцол, бусдын аж амьдралын талаар илүү үнэн бөгөөд төгс мэдлэгийг бүтээхэд зориулах талаар санал нэгтэй бөгөөд эрмэлзэл дүүрэн байна...”

ТАЛАРХАЛ

Номын зохиогчид энэхүү хөтөлбөрийг анхны санаанаас нь эхлээд бэлтгэж дуусах хүртэлх ажлын бүхий л шатанд удирдан чиглүүлж, голлох хувь нэмрийг оруулсан Вижэянанда Жаявэра болон Владимир Гэй нарт гүн талархал илэрхийлье. Зохиогчид мөн санал, зөвлөгөө өгсөн дараах хүмүүст талархаж байна:

ХАМТРАН АЖИЛЛАСАН

— Нягтлан шалгасан:

Ирмгарда Кэзинскайте-Баддеберг, Хөтөлбөрийн мэргэжилтэн, ЮНЕСКО, Парис
Эндрю Паддерпат, Захирал, Дэлхий Дахины Түнш, Хамтрагчид, Лондон, Их Британи улс
Фэксон Бэнда, Хөтөлбөрийн мэргэжилтэн, ЮНЕСКО, Парис
Боян Радуюков, Хэлтсийн дарга, Бүх төрлийн нэвтрэх болон хадгалан хамгаалах эрхийн хэлтэс, ЮНЕСКО, Парис
Индражит Банержи, Захирал, Мэдээллийн нийгмийн хэсэг, ЮНЕСКО, Парис
Ральф Катс, Ахлах судлаач, Сургууль Нийгмийн Баялгийн Сүлжээ, Шотландын Боловсролын Хэрэглээний Судалгааны Санаачилга (AERS)
Жако Ду Тойт, Мэдээлэл, мэдээллийн харилцааны зөвлөх, ЮНЕСКО Уиндхук
Мисако Ито, Мэдээлэл, мэдээллийн харилцааны зөвлөх, ЮНЕСКО Рабат
Абел Кэйн, Хөтөлбөрийн мэргэжилтэн, ЮНЕСКО Парис
Тоби Мендель, Гүйцэтгэх захирал, Хууль ба Ардчилал Төв

— Хувь нэмэр оруулсан бусад хүмүүс :

Юутта Скрол, Гүйцэтгэх захирал, Цахим Боломж Сан, Берлин, Герман улс

— Хөтөлбөрийг бэлтгэх олон улсын шинжээчдийн зөвлөлгөөн

Куэйм Акъемпонг, Орлогч захирал, Олон Улсын Боловсролын Төв, Сассексийн Их Сургууль, Брайтон, Их Британи
Эвелин Биворт, Гүйцэтгэх захирал, Боловсрол Мэдээллийн Харилцааны Шийдэл Төв, Парис, Франц улс (CLEMI),
Факсон Бэнда, ЮНЕСКО Хэвлэл Мэдээлэл Ардчилал хөтөлбөрийн удирдагч, Родсын Их Сургууль, Грахамстаун, Өмнөд Африк
Алберт К. Бёкхорст, Зочин профессор, Мэдээллийн шинжлэх ухааны тэнхим, Преториагийн Их Сургууль, Өмнөд Африк
С.К Чэюун, Сургагч багш, Боловсролын факультет, Хонг Конгийн Их Сургууль, Хятад улс
Нёл Чикюкю, Үндэсний мэргэжилтэн, ЮНЕСКО Мозамбик
Бандула П. Даяратнэ, Багш, Сургалтын хөтөлбөрийн мэргэжилтэн, Үндэсний Боловсролын Хүрээлэн, Шри Ланк улсын Коломбогийн Их Сургуулийн Мэдээллийн хэрэгслийн суурь боловсролын зочин багш
Кармила Флойд, Зохиолч, сэтгүүлч, сэтгүүлзүйн багш, Стокгольм, Швед улс
Дивина Фрау-Майгс, Дэд ерөнхийлөгч, Хэвлэл мэдээлэл, мэдээллийн харилцаа судлалын олон улсын нийгэмлэг (IAMCR), Парисын Их Сургууль, – Сорбонн, Франц улс
Мартин Хадлов, Захирал, Мэдээллийн Харилцаа ба Нийгмийн Өөрчлөлт Төв, Сэтгүүлзүй мэдээллийн харилцааны сургууль, Куинсландын Их Сургууль Брисбэйн, Австрали

Езус Лау, Захирал, USBI VER Номын сан, Веракрузана Их сургууль, Мексик

Мариа Эстер Манцебо, Боловсролын бодлогын профессор, Бүгд Найрамдах Их Сургууль, Монтевидео, Уругвай

Пенни Муур, Боловсролын судалгааны зөвлөх, Гүйцэтгэх захирал, Сургуулийн номын санчдын олон улсын холбоо, Уэлингтон, Шинэ Зеланд

Ренато Оперетти, Боловсролын Олон Улсын Товчоо, ЮНЕСКО Женев

Кэролайн Понтерфрак, Багшийн Боловсролын Хэлтсийн дарга, ЮНЕСКО Парис

Раша Омар, Захирал, Шинжлэх Ухааны Технологи Судлал, Палестины Сургалтын Хөтөлбөр Боловсруулах Төв, Боловсролын Яам, Рамалла, Палестийны газар нутаг

Жозе Перез Торнеро, Дэд Ерөнхийлөгч, Үзэгчдийн Эрх Ашгийн Европын Нийгэмлэг (EAVI), Ерөнхий нарийн бичгийн дарга, Хэвлэл Мэдээллийн Боловсролын Олон Улсын Нийгэмлэг (MENTOR), Барселоны Хараат Бус Их Сургууль, Испани

Мануэль Куинтеро Куинтеро, Ерөнхий захирал, Латин Америкийн Мэдээллийн Харилцааны Боловсролын Хүрээлэн, Мехико

Сэми Таи, Ерөнхийлөгч, Хэвлэл Мэдээллийн Боловсролын Олон Улсын Нийгэмлэг (MENTOR), Каир, Египт

Туссант Чичи, Абоми Калави Их Сургууль, Бенин

Иорди Торрент, Төслийн менежер, Хэвлэл мэдээллийн боловсрол, Иргэншлийн Холбоо, НҮБ

Рамон Р.Тюэзон, Дарга, Мэдээллийн харилцааны ажлын хороо, Дээд боловсролын хороо (CHED), Ерөнхийлөгч, Азийн Сэтгүүлзүй Мэдээлэл Харилцааны Хүрээлэн, Филиппин

Кэролайн Уилсон, Ерөнхийлөгч, Хэвлэл Мэдээллийн Боловсролын Нийгэмлэг (AML), Онтарио, Канад улс. Багш, Онтариогийн Боловсролын Судалгааны Хүрээлэн, Торонтогийн Их Сургууль, Канад улс

— Сургалтын хөтөлбөрийн анхны төслийг хэлэлцэх олон улсын шинжээчдийн багийн хоёрдугаар зөвлөлгөөн

Клемент Ламберт, Багш, Хэл шинжлэл /Суурь боловсрол, Боловсролын Хүрээлэн, Баруун Индийн Их Сургууль, Жамайк

Сьюзан Мёллер, Захирал, Хэвлэл Мэдээлэл, Олон Нийтийн Асуудлын Олон Улсын Төв (ICMPA), Зальцбург, Австри улс Роксана Мордухович, Үндэсний боловсролын яамны хэвлэл мэдээллийн хэлтсийн дарга, Буэнос Айрес, Аргентин

Юутта Скрол, Гүйцэтгэх захирал, Цахим Боломж Сан, Берлин, Герман улс

Пер Лундгрэн, Захирлуудын зөвлөлийн гишүүн, Хэвлэл Мэдээлэл Хүүхэд Залуучуудын Төлөө Олон Улсын Дээд Хэмжээний Уулзалт, Карлштад, Швед

Муна Бенслимэйн, багш, Мэдээллийн шинжлэх ухааны сургууль, Морокко

Ана Найду, Орлогч декан, Боловсролын факултет, Преториогийн Их Сургууль, Өмнөд Африк

Асим Абдул Саттар, Декан, Малдивын Дээд Боловсролын Коллеж, Малдив улс

Рамон Р.Тюэзон, Дарга, Мэдээллийн харилцааны ажлын хороо, Дээд боловсролын хороо (CHED), Ерөнхийлөгч, Азийн Сэтгүүлзүй Мэдээлэл Харилцааны Хүрээлэн, Филиппин

Кэролайн Уилсон, Ерөнхийлөгч, Хэвлэл Мэдээллийн Боловсролын Нийгэмлэг (AML), Онтарио, Канад улс. Багш, Онтариогийн Боловсролын Судалгааны Хүрээлэн, Торонтогийн Их Сургууль, Канад улс

С.К Чэюун, Сургагч багш, Боловсролын факультет, Хонг Конгийн Их Сургууль, Хятад улс

Куэйм Акъемпонг, Орлогч захирал, Олон Улсын Боловсролын Төв, Сассексийн Их Сургууль, Брайтон, Их Британи

Иорди Торрент, Төслийн менежер, Хэвлэл мэдээллийн боловсрол, Иргэншлийн Холбоо, НҮБ

Ренато Оперетти, Боловсролын Олон Улсын Товчоо, ЮНЕСКО Женев

— Өмнөд Африк, Латин Америк, Карибын тэнгисийн болон Өмнөд Азийн багш нарт зориулсан бүсийн цуврал сургалт

--- Өмнөд Африк

Финдили Марийн Нксумало, Боловсролын хэлтсийн дарга, Уилиам Питчер Коллеж, Свазиланд
Уэндице Сифунза, SNAT сонины редактор, Свазиландын Багш нарын Үндэсний Холбоо
Муза Хлопе, Математикийн сургалтын хөтөлбөрийн мэргэжилтэн, Өмнөд Африкийн Үндэсний Сургалтын Хөтөлбөрийн Төвийн мэдээлэл хариуцсан ажилтан
Мафата Паул Мафата, Лесотогийн Боловсролын Коллеж, Лесото
Мабатунг Мецинг, Үндэсний Сургалтын Хөтөлбөрийн Төв, Өмнөд Африк
Жон Нямбэ, Боловсролын Хөгжлийн Үндэсний Хөтөлбөр, Намиб улс
Герхард Нгаланги, Багш, Рундугийн Боловсролын Коллеж, Намиб улс
Аллен Чайда, Багш, Капривигийн Боловсролын Коллеж, Намиб улс
Тулонга Хенох, Багш, Онгведивагийн Боловсролын Коллеж, Намиб улс
Элизабет Браун, Багш, Намибын Их Сургууль, Намиб улс
Эндрю Стевенс, Багш, Родсын Их Сургууль, Өмнөд Африк
Пентекост Нкома, Багш, Тшаванын Технологийн Их Сургууль, Претория, Өмнөд Африк
Лес Мэйринг, Багш, Нельсон Мандела Метрополитан Их Сургууль, Порт Элизабет, Өмнөд Африк
Манди Юус, Багш, Баруун Хойд Их Сургууль, Өмнөд Африк
Герит, Столс, Преториягийн Их Сургууль, Өмнөд Африк
Ана Найдү, Орлогч декан, Боловсролын факультет, Преториягийн Их Сургууль, Өмнөд Африк
Мари Анне Хууд, Багш, Форт Хэрийн Их Сургууль, Ийст Лондон, Өмнөд Африк
Сиконзайл Ндлову, Хэвлэл мэдээллийн сургалтын менежер, Йоханнесбург, Өмнөд Африк
Марина Руудт, Багш, Технологийн Төв Их Сургууль, Блёмфонтэйн, Өмнөд Африк
Ван Хеерден, Багш, Баруун Кейпийн Их Сургууль, Өмнөд Африк
Марианне Хикс, Багш, Олон улс судлал, Монашийн Их Сургууль, Өмнөд Африк
Ина Фури, Зочин Профессор, Мэдээллийн Шинжлэх Ухааны тэнхим, Преториягийн Их Сургууль, Өмнөд Африк
Жохан ван Вик, Номын санч, Преториягийн Их Сургууль, Өмнөд Африк

-- Латин Америк болон Карибын тэнгисийн улс

Жосеф Мкензи, Ахлах багш, Моникийн Багшийн Коллеж, Жамаик
Лорэйн Жанетте Кэмпбэл, Боловсролын захирал, Эдна Мэнлигийн Дүрс & Жүжгийн Урлагийн Коллеж, Кингстон, Жамаик
Хирфа Моррисон, Коллежийн номын санч, Икселсиор Орон Нутгийн Коллеж, Кингстон, Жамаик
Зелин Женнингс Крэйг, Захирал, Боловсролын Сургууль, Баруун Индийн Их Сургууль, Мона, Жамаик
Соня Беннет-Сюнигам, Хичээлийн эрхлэгч, VTDI, HEART Trust/NTA, Кингстон, Жамаик
Дебора Францис, Ахлах багш, Ариун Жосефын Багш нар, Кингстон, Жамаик
Далиа Пальмер, Багш, Шортвуудын Багшийн коллеж, Кингстон, J Жамаик
Барбара Фостер, Зохицуулагч, Баруун Индийн Их Сургууль, Мона, Жамаик
Катерине Гибсон, Бизнес судлалын багш, Эрдисонын Багшийн Коллеж, Барбадос
Линда Розенбад, Багш сургагч, Багш бэлтгэх Advanced Teacher Trainer College, Leysweg, Suriname
Женифер Пальмер Кроффорд, Багшийн боловсрол, Кларенс Фитцтрой Брянт Коллеж, Гюэйдолук
Ройстон Эммануэль, Багш, Сир Артур Левис Комьюнити Коллеж, Сант Люсиа
Жакелин Моррис, Багш, Тринидад, Тобагогийн Их Сургууль
Лайонлель Дуглас, Дэд профессор, Тринидад, Тобагогийн Их Сургууль
Валентин Телемак, Мэдээллийн технологийн багш, Зүүн Хойд Бүрэн Дунд Сургууль, Уисли,

Доминика

Эрика Васкиз, Захирал, Суурь боловсролын хэлтэс, Коста Рикагийн Үндэсний Их Сургууль
Сильвия Жеймс Митчель, Багш, Т.А. Маришовын Мэдээлэл Харилцааны Коллеж, Гренада
Боб Харрис, Чөлөөт сэтгүүлч, ПиБиСи ТВ, Кингстон, Жамаик

Марлон Диксон, Зураглаач, ПиБиСи ТВ, Кингстон, Жамаик

Жиллиан Бернارد, Зөвлөх, ЮНЕСКО Кингстон, Жамаик

Элизабет Терри, Дарга, АйСиТи4Ди Жамаик. Захирал, Төсөл ба Түншлэл, Хат Траст /ЭнТиЭй

Исидро Фернандез-Абалли, Карибын тэнгисийн орнуудыг хариуцсан мэдээлэл харилцааны зөвлөх, ЮНЕСКО Кингстон, Жамаик

Эрика Уолкер, Мэдээлэл харилцааны үндэсний хөтөлбөрийн мэргэжилтэн, ЮНЕСКО Кингстон, Жамаик

Мелоди Пальмер, Хөтөлбөрийн менежер, сүлжээний зохицуулагч, АйСиТи4Ди Жамаик

-- Өмнөд Ази

Брэза Гопал Баумик, Нарийн бичгийн дарга, Үндэсний Сургалтын Хөтөлбөр, Гарын Авлагын Зөвлөл, Дака, Бангладеш

Рэйхана Таслим, Дэд профессор, Багшийн Коллеж, Дака, Бангладеш

Шамит Реза, Дэд профессор, Мэдээллийн харилцаа, сэтгүүлзүйн тэнхим, Дакагийн Их Сургууль, Бангладеш

Жигме Чоден, Мэдээлэл, харилцаа холбооны яам, Тимфу, Бутан

Еши Янг, Бодлого төлөвлөлтийн мэргэжилтэн, Мэдээлэл, харилцаа холбооны яам, Тимфу, Бутан

Мухамед Актар Сиддику, Дарга, Багшийн Боловсролын Үндэсний Зөвлөл, Шинэ Дели, Энэтхэг

Эрул Силван, Зочин профессор, Шинэ мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлзүй судлалын сургууль, IG-NOU, Шинэ Дели, Энэтхэг

Махалакши Жэярам, Азийн Сэтгүүлзүйн Коллеж, Ченай

Шухуда Ризван, Боловсролын хөгжлийн ажилтан, Тогтвортой боловсролын төв, Боловсролын яам, Мэйл, Малдив

Абдул Рашид Али, Декан, Урлагийн факультет, Малдивын Дээд боловсролын коллеж, Мэйл, Малдив

Има Нарян Шреста, Сургалт хариуцсан ажилтан, Боловсролын хөгжлийн үндэсний төв, Непал

Шрирам Ламисчэйн, Багшийн сургалтын хүрээлэн, Непал

Энжум Зиа, Дарга, Мэдээлэл харилцааны тэнхим, Лахор коллеж, Лахорын Эмэгтэйчүүдийн Их Сургууль, Пакистан

Антони ДиСильва, Нотре Дамын Боловсролын Хүрээлэн, Карачи, Паристан

Прадипа Ужитанг, Захирал, Номын сан, мэдээллийн шинжлэх ухааны үндэсний хүрээлэн, Коломбо, Шри Ланк

Премила Гамаж, Номын санч, Шри Ланкийн Бодлогын судалгааны хүрээлэн, Шри Ланк

АГУУЛГА

Өмнөх үг10

Нэгдүгээр бүлэг:

Сургалтын хөтөлбөр ба мэдлэг чадарын

ерөнхий хүрээ12

Хоёрдугаар бүлэг:

Үндсэн болон үндсэн бус сэдвүүд.....

Нэр томъёоны тайлбар

ӨМНӨХ ҮГ

Бидний амьдарч буй өнөөгийн нийгэмд аливаа сонголт болон түүнээс үүдэх үйлдэл, тухайлбал хүний үндсэн эрхээ эдлэх, хувь хүний хөгжлийн замаа тодорхойлох боломж нь бидний хүлээн авч буй мэдээллийн чанараас ихээхэн хамаарч байна. Мэдээлэл харилцааны технологийн улмаас мэдээллийн хэрэгсэл хурдацтай хөгжиж, иргэд асар их хэмжээний мэдээлэл болон мэдлэгийг хүртэж, өөр хоорондоо солилцож байна. Улмаар иргэдийн хувьд мэдээлэл хүртэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ саад хязгааргүй бүрэн эдлэх боломж дээшлэхийн сацуу мэдээллийн ач холбогдол, найдвартай байдлыг үнэлэх зайлшгүй шаардлага хэрэгцээ тулгарч буй юм. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг (МХМСБ) чухам энэ л утгаар нь харж ойлгох хэрэгтэй. Учир нь МХМСБ нь иргэний боловсролын үндэс суурийг бүрдүүлэгч чухал элемент бөгөөд харин энэхүү боловсролыг хөгжүүлэх хөдөлгөгч хүчин нь багш билээ.

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр нь гишүүн орнуудын хувьд Грюнвальдын тунхаг (1982), Александриагийн тунхаг (2005) болон ЮНЕСКО-гийн Парисын хөтөлбөрийг (2007) хэрэгжүүлэх үйлсийг үргэлжлүүлэхэд түшиг тулгуур болохуйц чухал баримт бичиг юм.

Энэхүү баримт бичиг нь хоёр шалтгааны улмаар шинэлэг юм. Нэгдүгээрт, уг баримт бичиг нь радио, телевиз, Интернет, сонин, ном, цахим архив болон номын сан өөр хоорондоо уусан нэгдэж буй өнөөгийн нөхцөлд тулгуурлан ирээдүйг харж, ингэснээр МХМСБ-д мэдээллийн хэрэгслийг цогцоор нь хамруулах анхны оролдлого болсон юм. Хоёрдугаарт, энэхүү хөтөлбөрийг багш нарт тусгайлан зориулж, багш бэлтгэх албан ёсны боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх зорилготойгоор боловсруулсан бөгөөд ингэснээр олон сая залуу хүнийг чадавхжуулах үйл явцын эхлэлийг тавьж буй юм. *МХМСБ-ын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг* бэлтгэх явцад аль болох цогц, системтэй арга барилыг ашиглахын тулд ЮНЕСКО-гоос бүхий л боломжоо ашиглалаа. Хөтөлбөрийг бэлтгэх үйл явц нь төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, хэвлэл мэдээлэл, мэдээлэл харилцаа, мэдээллийн технологи болон боловсролын салбарын холбогдох мэргэжилтнүүдээр батлуулах зэрэг олон үе шат дамжсан бөгөөд 2008 онд эхэлж, дараах үйл ажиллагааг өрнүүлсэн юм. Үүнд: олон улсын мэргэжилтний багийн уулзалт зөвлөлгөөн зохион байгуулж, хөтөлбөрийг бэлтгэх стратеги боловсруулах; МХМСБ-ын сургалтын хүрээнд дэлхий дахинаа ашиглаж буй нөөц боломжийг тогтоох; хөтөлбөрийн анхны төслийг бэлтгэх үүрэг бүхий шинжээчдийн дөрвөн багийг томилох; энэхүү төслийг болон туршилтын цуврал сургалтыг хэлэлцэх, олон улсын хоёрдугаар зөвлөлгөөн болон Өмнөд Африк, Латин Америк, Карибын тэнгисийн улс болон Өмнөд Азийн бүсийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах; хөтөлбөрийн хоёр дахь төслийг боловсруулж, хэл найруулга болон агуулгын хувьд хянан засварлах эцсийн шатны ажил багтав.

Энэхүү хөтөлбөр үндсэн хоёр бүлгээс бүрдэж буй юм. Нэгдүгээр бүлэгт МХМСБ-ын сургалтын хөтөлбөр болон мэдлэг чадварын ерөнхий хүрээг танилцуусан бөгөөд үүнд хөтөлбөрийн шаардлага хэрэгцээ, бүтэц болон үндсэн сэдвүүд багтаж буй юм. Уг бүлэг нь ЮНЕСКО-гоос бэлтгэсэн *Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг чадварын ерөнхий*

хүрээ (2008) хэмээх баримт бичгийг нөхөх зорилготой. Хоёрдугаар бүлэгт хөтөлбөрийн үндсэн болон үндсэн бус сэдвүүдийг нарийвчлан танилцуулсан. МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг Араб, Франц, Орос, Испани болон магад бусад хэлнээ хөрвүүлэхээр төлөвлөж байна.


МХМСБ-ын сургалтын энэхүү хөтөлбөрийг бэлтгэх явдал бол мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол бүхий нийгмийг дэлхий дахинаа төлөвшүүлж, олон улсын хамтын ажиллагааг дэмжих цогц стратегийн хэрэгжилтийн зөвхөн нэг хэсэг нь юм. Үүнээс гадна *МХМСБ-ын шалгуур үзүүлэлтийн ерөнхий хүрээг боловсруулах, МХМСБ-ын Их, дээд сургуулийн сүлжээг байгуулах, МХМСБ-ыг хөгжүүлэх үндэсний бодлого стратегийг тодорхойлох удирдамжийг бэлтгэх, мөн Нэгдсэн Үндэстний Иргэншлийн Холбоотой хамтран МХМСБ-ын олон улсын судалгаа мэдээллийн төвийг байгуулах* зэрэг ажлыг гүйцэтгэсэн болно. *МХМСБ-ын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг* дэлхий дахинаа сонирхож буйд ЮНЕСКО баяртай байна. Энэхүү сонирхол нь бидний санаачилгын хоёрдугаар шат буюу дэлхийн бүхий л бүс нутагт хөтөлбөрийг өөрийн орчин нөхцөлд тохируулж, туршилтын сургалтуудыг зохион байгуулах ажил болж хөгжинө гэдэгт гүнээ итгэж байна. Энэхүү үйл явцад бодит туслалцаа үзүүлж хамтран ажилласан олон олон түншлэгчдээ талархал илэрхийлье.

Енис Кэрклинс


Дэд захирал

Мэдээлэл харилцаа холбоо

ЮНЕСКО



НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ



УДИРТГАЛ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх чөлөөнд хорио саадгүйгээр өөрийн үзэл баримтлалтай байх эрх чөлөө, мөн үзэл санаа мэдээллийг хилийн зааг ялгаагүйгээр аливаа арга, хэрэгслээр хүлээн авах, эрж сурвалжлах эрх чөлөө багтана” гэсэн байдаг. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол нь энэхүү хүний үндсэн эрхийн ашиг шимийг бүрэн хүртэхэд шаардлагатай мэдлэг, чадвараар хангана.

Энэхүү эрхийг 1982 оны Грюнвальдын тунхаглал дахин баталгаажуулсан билээ. Уг тунхаглалд “мэдээллийн харилцаа” хэмээх үйл явцад иргэд шүүмжлэлтэйгээр хандан ухамсарлаж, уламжлалт болон шинэ мэдээллийн хэрэгслийг идэвхтэйгээр ашигладаг байхын тулд улс төрийн болон боловсролын холбогдох тогтолцоо шаардлагатай болохыг онцолсон юм. Улмаар 2005 оны Александриагийн тунхаглалаар хэвлэл мэдээллийн суурь боловсролыг насан туршид суралцах үйл явцын үндсэн хэсэг нь хэмээн тодотгосон аж. “Хүний амьдралд хувийн, нийгмийн, мэргэжлийн болон боловсролын зорилгодоо хүрэх чухал гишгүүр нь мэдээлэл болждог бөгөөд мэдээллийг үр дүнтэйгээр хайх, үнэлэн дүгнэх, ашиглах, бүтээх мэдлэг чадварыг мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол (МХМСБ) олгодог. Энэ нь өнөөгийн цахим ертөнц дэх хүний үндсэн эрх бөгөөд үндэстэн бүхэнд нийгмийн оролцоог дэмжин дэлгэрүүлэгч хүчин зүйл мөн” хэмээн энэхүү тунхаг бичигт заасан байдаг.

13

Мэдээллийн хэрэгсэл болон номын сан, архив, Интернет гэх мэт мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг бусад сувгуудыг, иргэдэд мэдлэгтэйгээр шийдвэр гаргахад нь тус дэм болох чухал хэрэгсэл хэмээн өргөнөөр хүлээн зөвшөөрдөг. Эдгээр нь мөн улс нийгэм бүрт өөрийнхөө тухай мэдэж авах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, хамтын мэдрэмжийг хөгжүүлэх хэрэгсэл болж өгдөг. Мэдээллийн бүх төрлийн суваг насан туршийн сурах үйл явцад голлох үүргийг гүйцэтгэх боломжтой учир иргэд мэдээллийн хэрэгслийн үүрэг, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар суурь мэдлэгтэй байх нь чухал. Хэвлэл мэдээллийн суурь боловсролын зорилго нь иргэдэд хэрэглэгчийн мэдлэг олгох явдал юм.

Хэвлэл мэдээллийн суурь боловсрол нь дараах зүйлсийн талаар чухал мэдлэг олгодог. Үүнд: (а) ардчилсан нийгэм дэх мэдээллийн хэрэгсэл, номын сан, архив болон мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг бусад газрын үүрэг, (б) эдгээр үүргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага ямар орчин нөхцөлд үр дүнтэйгээр гүйцэтгэх боломжтой байдаг тухай болон (в) тухайн мэдээллийн хэрэгсэл үүргээ хэрхэн гүйцэтгэж буйг агуулга, үйлчилгээгээр нь хэрхэн үнэлэх тухай. Эдгээрийг мэдэж авснаар хэрэглэгчид мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг утга учиртайгаар ашиглах чадвартай болох ёстой. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролоор олж авсан мэдлэг чадвар нь

иргэдийг шүүмжлэлт сэтгэлгээнд сургаж, ингэснээр мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагаас өндөр чанарын үйлчилгээ нэхэн шаардах чадвартай болгоно. Улмаар мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага өндөр түвшний үйлчилгээ үзүүлэхээс өөр аргагүй тийм орчныг бүрдүүлэхэд иргэд оролцож, тэрхүү орчныг бий болгохын төлөө хүчин чармайх болно.

Мэдээжийн хэрэг цаг үеийн мэдээлэл бэлтгэн түгээдэг мэдээллийн хэрэгслийг тэдгээрийн онцлогоос нь хамаарч энэхүү хөтөлбөрт онцгойлж, илүү дэлгэрэнгүй авч үзсэн байгаа. Эдгээр хэрэгсэл нь мэдээллийн урсгалын олон янзын өнгө төрхөөс бүрдсэн тогтолцоог төлөөлж байдаг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг долгионы хүртээмж болон үр нөлөөний цар хүрээг нь харгалзаж тодорхой хэмжээгээр тэнцвэржүүлэх үүднээс төрөөс зохицуулдаг бол хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл харьцангуй чөлөөтэй хөгжиж ирсэн. Гэхдээ олон нийтийн ашиг сонирхлын өмнө хүлээх хариуцлагыг бий болгох үүднээс хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болсон бөгөөд энэ нь төрийн хатуу хяналт, зохицуулалтаас зайлсхийх арга болдог.

Өөрийн зохицуулалтын энэхүү тогтолцоо нь ёс зүйн тодорхой зарчим, үнэт зүйлсэд тулгуурладаг. Тийм учраас мэдээллийн хэрэгслээс олон түмэн тодорхой зүйлсийг хүлээж байдаг бөгөөд энэхүү хүлээлтийг нь биелүүлээгүй тохиолдолд мэдээллийн хэрэгсэл бүх нийтийн шүүмжлэлд өртөх боломжтой. Мэдээллийн хэрэгслийн үүрэг, энэхүү үүргийг биелүүлэх орчин нөхцлийг болон хэрэглэгчдийн зүгээс мэдээллийг хэрхэн үнэлэх аргыг дээр дурьдсан өөрийн зохицуулалтын тогтолцоонд тулгуурлан тодорхойлж болох юм.

14

Суралцагсдын хэвлэл мэдээллийн суурь боловсролыг хөгжүүлэхийн тулд багш нар өөрсдөө мэдээллийн хэрэгслийн тухай болон мэдээллийн талаар мэдлэг боловсролтой болох шаардлагатай байна. Тиймээс эхний ээлжинд багш нарт анхаарал хандуулснаар мэдээллийн боловсрол бүхий багшаас суралцагчид болон магад бүхий л нийгэмд хүрч үр нөлөөг нь үржүүлэн дэлгэрүүлэх арга стратегийг санал болгож буй юм. Хэвлэл мэдээллийн суурь боловсролтой багш нар суралцагсдад сурах арга барилыг зааж өгөх, тэдний бие даан сурах болон насан туршдаа суралцах чадварыг хөгжүүлэхэд нь түшиг тулгуур болох юм. Оюутан сурагчдад мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол олгох үйл явцад багш нар юуны түрүүнд мэдээлэлтэй, ухамсартай иргэдийг бий болгон дэмжих үүргээ гүйцэтгэж, нөгөө талаар сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг багш төвтэй үйл явцаас шавь төвтэй үйл явцад шилжүүлэн өөрчлөх алхмыг хийх юм.

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролын сургалтын хөтөлбөрт уламжлалт заах арга барилыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг багтаавал багш нар энэхүү шинэ хөтөлбөрийг илүү сайн тусган авч хэрэгжүүлэх магадлалтай. Тиймээс боловсролын салбарт мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг нэвтрүүлэх замаар багшийн мэргэжлийн хөгжилд нөлөөлөхүйц өөрчлөлтийг дагуулах нь энэхүү хөтөлбөрийн нэг чухал зорилго юм.

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫГ МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛТОЙ ХАМТАТГАХ НЬ

ЮНЕСКО-гоос боловсруулсан Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролын сургалтын хөтөлбөр нь мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол, мэдээллийн боловсрол хэмээх хоёр чухал ухагдахууныг Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол хэмээх нэг ойлголтод нэгтгэж буйгаараа онцлог юм.

Эдгээр хоёр ухагдахуун нь тус тусдаа өөр санааг агуулах боловч нэгтгэсэн нэр томъёо нь мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол болон мэдээллийн суурь боловсролын аль алиныг багтаасан шинэ утга агуулгаар МХМСБ-ын зорилго, зорилтыг тодорхойлж буй юм¹.

Хүснэгт 1: Хэвлэл мэдээллийн суурь боловсролын үндсэн элемент болон үр дүн

Мэдээллийн суурь боловсрол

Мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, илэрхийлэх	Мэдээллийн байршил, эх сурвалжийг тогтоож, олж авах	Мэдээллийг үнэлэх	Мэдээллийг зохион байгуулах	Мэдээллийг ёс зүйтэйгээр ашиглах	Мэдээллийг хуваалцах, дамжуулах	Мэдээллийн технологийг мэдээлэл боловсруулахад ашиглах
---	---	-------------------	-----------------------------	----------------------------------	---------------------------------	--

15

Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол²

Ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүргийн тухай ойлголттой болох	Мэдээллийн хэрэгсэл үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай орчин нөхцлийн талаар ойлголттой болох	Мэдээллийн хэрэгслийн агуулгыг нийгэмд гүйцэтгэх үүрэгтэй нь харьцуулж, шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэх	Өөрийгөө илэрхийлэх, ардчилсан үйл явцад оролцох зорилгоор мэдээллийн хэрэгслийг ашиглах	Хэрэглэгчийн хувьд мэдээлэл бэлтгэхэд шаардлагатай мэдээллийн технологийг ашиглах болон бусад чадварыг тоймлон үнэлэх
--	--	---	--	---

Мэдээллийн суурь боловсрол нь нэг талаар мэдээлэл авах, мэдээллийг үнэлж, ёс зүйтэйгээр ашиглахын ач холбогдлыг онцолж буй юм. Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол нь нөгөө талаар мэдээллийн хэрэгслийн үүргийг ойлгож, тэдгээр үүрэг нь хэрхэн биелэгдэж буйг үнэлэх, үзэл бодлоо илэрхийлэхийн тулд мэдээллийн хэрэгслийг ухамсартайгаар ашиглах чадварыг онцгойлж буй болно. Багш нарт зориулсан МХМСБ-ын сургалтын хөтөлбөр, мэдлэг чадварын ерөнхий хүрээ нь эдгээр хоёр санааг хослуулан ашиглахыг санал болгож байна. Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол болон мэдээллийн суурь боловсролын тухай онолын олон янзын тодорхойлолтод судалгаанд суурилсан (мэдээлэл авах) чадвар болон

¹Ralph Catts & Jesus Lau, 2008-д тулгуурлав

²Энд мэдээллийн технологи ашиглах чадвар, цахим мэдлэг зэргийг зориудаар тодотгоогүй болно. Энэ нь мэдээллийн технологийн ач холбогдлыг бууруулж буй хэрэг биш бөгөөд харин ЮНЕСКО-гоос 2008 онд эрхлэн гаргасан “Багш нарт зориулсан мэдээллийн технологийн мэдлэг, чадвар, стандарт” -д дээрх сэдвийг хангалттай тусгасан учир энд дэлгэрэнгүйгээр авч үзсэнгүй.

мэдээллийн олон янзын хэрэгсэл, сувгийг утга учиртайгаар ашиглах чадварыг онцлон тодотгосон байдаг.

Өөр хоорондоо нэгдэн уусаж буй мэдээллийн суурь боловсрол болон мэдээллийн хэрэгслийн суурь боловсролыг судалж буй онолын хоёр үндсэн урсгал бий. Нэг нь мэдээллийн суурь боловсролыг өргөн утгаар нь судлагдахуун болгож, хэвлэл мэдээллийн суурь мэдлэг нь мэдээллийн боловсролд багтана гэж үздэг. Гэхдээ ЮНЕСКО-гоос томилогдсон олон улсын шинжээчдийн багаас мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага хоорондын ялгаа болон уялдаа холбоог тодорхойлж өгсөн билээ. Эдүгээ дэлхий дахинаа дараах нэр томъёог ашиглаж буйг анхаарч үзнэ үү:

- Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол
- Мэдээллийн суурь боловсрол
- Үг хэлэх, мэдээлэл хүртэх суурь боловсрол
- Номын сангийн суурь боловсрол
- Цаг үеийн мэдээллийн суурь боловсрол
- Компьютерийн суурь боловсрол
- Интернэтийн суурь боловсрол
- Цахим суурь боловсрол
- Киноны суурь боловсрол
- Тоглоомын суурь боловсрол
- Телевизийн суурь боловсрол, зар сурталчилгааны суурь боловсрол

16

Эдгээрийн хооронд мэдээжийн хэрэг тодорхой уялдаа холбоо бий (Хүснэгт 2). Энэхүү баримтад тэдгээрийг бүгдийг тайлбарласангүй. Гэхдээ заримыг нь ЮНЕСКО-гоос боловсруулсан МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн удиртгал хичээлд тусгасан болно. (Сэдэв 1) Гол нь багш нар хэвлэл мэдээллийн салбарын талаар суралцах явцад дээр дурдсан нэр томъёо, ухагдахуунтай учрах бөгөөд энэ үед тэд эдгээрийн талаар дор хаяж сонссон байх шаардлагатай. Эдгээр ухагдахууны нэлээд нь маргаантай байдгийн зэрэгцээ тухайн нэр томъёог ашиглаж буй хүрээний мэргэжлийн болон соёлын онцлогоос хамаарч янз бүрийн агуулгаар хэрэглэх нь түгээмэл. Дэлхийн олон байгууллага “Хэвлэл мэдээллийн боловсрол” хэмээх нэр томъёог ашиглаж буй бөгөөд ингэхдээ энэхүү ухагдахуунд “мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол” болон “мэдээллийн суурь боловсрол”-ыг хоёуланг нь хамаатуулж байна. ЮНЕСКО-гоос ашиглаж буй МХМСБ-ын ойлголт нь мэдээллийг дамжуулж буй хэрэгслийн нэгдэн нийлэх үйл явцыг харгалзаж, өөр өөрийн өнгө аяс бүхий утга агуулгыг уялдуулан нэгтгэж буй билээ.

Багш нарт зориулсан энэхүү МХМСБ-ын загвар хөтөлбөр нь өндөр хөгжилтэй болон хөгжиж буй улс оронд мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь мэдлэгтэй багш нарыг бий болгох зорилго бүхий боловсролын тогтолцоог хөгжүүлэхийг зорьж байна.

Түүнчлэн ЮНЕСКО –гоос энэхүү хөтөлбөрийг олноороо хэлэлцэж, хамтын хүчээр сайжруулан баяжуулж, бодит нөхцөл байдал, шаардлага хэрэгцээнд нийцсэн

баримт бичиг болгоосой хэмээн хүсэн хүлээж байна. Тийм ч учраас хөтөлбөрт зөвхөн зайлшгүй эзэмших шаардлагатай үндсэн мэдлэг, чадварт гол анхаарлаа хандуулсан бөгөөд хөтөлбөрт багтсан сэдвүүдийг онцын төвөггүйгээр тухайн оронд үйлчилж буй багш нарыг бэлтгэх хөтөлбөрт шингээх боломжтой байхаар төлөвлөсөн юм.



17

МХМСБ-ЫН АШИГ ТУС, ШААРДЛАГА ХЭРЭГЦЭЭ

Хүний эрхий түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх нь хорио саадгүй, хил хязгаарын зааг ялгаагүйгээр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл болон үзэл санааг хүлээн авч, дамжуулах эрхийг багтаана” хэмээн заасан бөгөөд МХМСБ нь энэхүү эрхээ эдлэх чадварыг хөгжүүлдэг.

МХМСБ-ын үндсэн ашиг тусыг дараах байдлаар тодорхойлж болно:

Сурах болон заах үйл явцад ирээдүйн иргэдийг бэлтгэхэд шаардлагатай дэвшилтэт мэдлэгээр багш нарыг хангана.

МХМСБ-ын сургалт нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад сувгийн ардчилсан нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар чухал ач холбогдол бүхий мэдлэг олгож, энэхүү үүргээ биелүүлэхийн тулд шаардлагатай орчин нөхцлийн талаар хангалттай ойлголттой болгохын зэрэгцээ мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн үйл ажиллагааг

үнэлэн дүгнэхэд шаардлагатай чадварыг хөгжүүлнэ.
Хэвлэл мэдээллийн суурь боловсрол бүхий нийгэм нь чөлөөт, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээлэл, нээлттэй мэдээллийн тогтолцоог дэмжин хөгжүүлнэ.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн ашиг тусыг хүртэхийн тулд дараах зүйлсийг ойлгож авах шаардлагатай:

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг мэдлэг, ур чадвар, хандлагын цогц бүрэлдэхүүнээр нь ойлгох нь чухал.

МХМСБ-ын хөтөлбөр нь суралцагсдыг мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг бие даан ухамсартайгаар ашиглах чадвартай болгох хэмжээнд багш нарыг хөгжүүлэх ёстой.

Иргэд мэдээллийн байршил, хэрэглээ болон үйлдвэрлэлийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай.

Эмэгтэй, эрэгтэй, эмзэг бүлгийнхэн, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүгд мэдээлэл, мэдлэг хүртэх тэгш эрхтэй байх ёстой.

МХМСБ-ыг соёл хоорондын харилцан ойлголцлыг хөхүүлэн дэмжих чухал хэрэгсэл хэмээн үзэх нь зүйтэй.

МХМСБ-ын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийн үндсэн сэдвүүд

18

МХМСБ-ын сургалтын хөтөлбөр, мэдлэг, чадварын ерөнхий хүрээг ойлгохын тулд энэхүү хөтөлбөрийг ашиглах тухайн орчин нөхцөлтэй нь холбож үзэх хэрэгтэй. Энэхүү хөтөлбөр нь мэдээллийн төрөл бүрийн сувгийн тухай болон тэдгээрийг янз бүрийн түвшинд хэрхэн ашиглах талаар мэдлэг олгохыг зөвлөж буй юм. Мэдлэг чадварын ерөнхий хүрээ нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд оюутан сургачид ямар мэдлэг, чадвартай болсон байхыг тодорхойлж өгнө.

Энэхүү багцад багтаасан МХМСБ-ын сургалтын хөтөлбөр нь дараах асуудлуудад анхаарал хандуулах замаар МХМСБ-ыг ойлгоход багш нарт тус дэм болохыг зорьж буй юм:

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаа, хэвийн ажиллаж, үүргээ гүйцэтгэхийн тулд шаардлагатай орчин нөхцөл.

Тэдгээр хэрэгслийг үйл ажиллагааных нь тухайн нөхцөл болон ерөнхий орчных нь хүрээнд хэрхэн шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэх.

Редакцийн хараат бус байдлын тухай үндсэн ойлголт. Сэтгүүлзүй бол нягтлан шалгах эрдэм болох тухай.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид хүний үндсэн эрхийг хамгаалж, суралцах үйл явцыг бодлоготойгоор дэмжин дэлгэрүүлэх боломжтойн талаар.

Залуу хүмүүс мэдээллийн хэрэгслээс тодорхой мэдээллийг хэрхэн яагаад

хүртэж буй, тэд авсан мэдээллээ яаж сонгож, үнэлэн дүгнэж буй тухай.

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн ёс зүй.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэлтэй холбоотой хувь хүний чадавх, эрх, үүрэг, хариуцлага.

Олон улсын хэм хэмжээ (Хүний эрхий түгээмэл тунхаглал), мэдээллийн эрх чөлөө, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх үндсэн хуулийн эрх, бусдын эрхийг хамгаалах үүднээс хэрэглэх зарим зохицуулалт (жишээлбэл үзэн ядалтыг сурталчлахыг хориглох болон нэр төр, хувийн нууцыг хамгаалахад шаардлагатай зохицуулалт).

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн хүлээх үүрэг (олон ургальч байдлын хэм хэмжээ).

Мэдээллийн эх сурвалж, мэдээллийг бүтээх болон хадгалах арга хэрэгсэл.

Мэдээллийн хэрэгцээг тодорхойлох, мэдээлэл хайх, олж авах үйл явц.

Мэдээллийн байршлыг тогтоож, олж авах арга хэрэгсэл.

Мэдээллийг хэрхэн ойлгож, зохион байгуулж, үнэлэн дүгнэх вэ. Үүнд мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэх арга орно.

Мэдээллийг янз бүрийн хэлбэрээр бэлтгэж, түгээх үйл явц.

Мэдээллийг ашиглаж болохуйц хэлбэрээр хадгалах, архивлах, дахин ашиглах, хуулбарлах, бусдад дамжуулах арга хэрэгсэл.

Хувийн, нийгмийн болон улс төрийн амьдралд асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах зорилгоор мэдээллийг ашиглах. Хэдийгээр энэхүү сэдэв нь туйлын чухал боловч ихэнхдээ МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн үндсэн асуудлаас хальсан нэмэлт сэдэв болдог.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХҮРЭЭ

ЮНЕСКО-гийн МХМСБ-ын шинжээчдийн багийн³ зөвлөмж болон хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан сургалтын модуль нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий гурван сэдвийг онцолж буй бөгөөд эдгээрийн нийлбэр нь МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг цогцлуулж буй юм. Үүнд:

Ардчилсан нийгэмд мэдээлэл, санал солилцох үйл явц, нийгмийн оролцоонд мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн гүйцэтгэх үүрэг.

Мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээлэл, тэдгээрийн эх сурвалжийг үнэлэн дүгнэх.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг ашиглах, мэдээлэл бэлтгэх.

³Энэхүү баримт бичгийг ЮНЕСКО-гийн МХМСБ-ын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр дээр ажилласан олон улсын шинжээчдийн багийн зөвлөмжид тулгуурлав.

Эдгээрийг ерөнхий боловсрол болон багшийн хөгжлийн зургаан үндсэн асуудалтай холбож өгсөн болно. (Хүснэгт 1).

МХМСБ-ын сургалтын хөтөлбөр нь заавал мөрдөх жор биш бөгөөд харин өөрийн орон, бүсийн болон олон улсын бодлого стратегид тохируулан ашиглахад тус дэм болох зорилготой юм. (МХМСБ-ын 2 дугаар бүлгийн удиртгал хэсгээс хөтөлбөрийг шинээр нэвтрүүлэх болон тохируулан ашиглах үйл явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авна уу).

Хөтөлбөрт багтаасан саналуудыг аль болох уян хатан байхаар боловсруулсан учир тухайн орон нутгийн боловсролын тогтолцоо, байгууллагын хэрэгцээ шаардлагад тохируулан ашиглах боломжтой. Гэхдээ багш нар МХМСБ-ын сургалтын хөтөлбөр дээр ажиллахдаа аль ч тохиолдолд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд онцлон заасан эрхүүдийг харгалзах ёстой хэмээн ЮНЕСКО үзэж байна. Өөрийн нөхцөл, шаардлага хэрэгцээнд тохируулж ямар ч хэлбэрээр ашиглалаа гэсэн МХМСБ-ын сургалтын хөтөлбөр нь дээрх баримт бичигт заасан эрх, эрх чөлөөг иргэний боловсролын чухал хэсэг болгохын чухлыг багш нарт ойлгуулахад туслах болно.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөр нь хэвлэмэл болон сонсох, үзэх зориулалт бүхий мэдээллийн хэрэгсэл, тухайлбал сонин, ном, радио, телевиз, цахим мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад бүх байгууллагад хамааралтай. Тийм ч учраас МХМСБ-ын хичээл заах багшийг бэлтгэхдээ дэвшилтэт технологи хөгжсөн орчин нөхцөлд ажилладаг багш нараас гадна мэдээллийн технологийн хэрэглээ хязгаарлагдмал орны багш нарыг ч хамруулах нь зүйтэй.

Хүснэгт 1: МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн ерөнхий бүтэц

Хөтөлбөрийн түвшин			
Хөтөлбөрийн үндсэн сэдэв	Ардчилсан хэлэлцүүлэгт шаардлагатай мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн тухай мэдлэг	Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг үнэлэх	Мэдээлэл бэлтгэх болон хэрэглэх дадлага
Бодлого, хэтийн зорилго	Мэдээлэл болон мэдээллийн хэрэгслийн талаар мэдлэг бүхий багшийг бэлтгэх.	Мэдээлэл болон мэдээллийн хэрэгслийн талаар мэдлэг бүхий оюутан сурагчдыг бэлтгэх.	Мэдээлэл болон мэдээллийн хэрэгслийн тухай мэдлэг бүхий нийгмийг төлөвшүүлэх.
Сургалтын хөтөлбөр ба үнэлгээ	Мэдээллийн хэрэгсэл, номын сан, архив болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага, тэдгээрийн үүрэг, үүргээ биелүүлэхэд шаардлагатай орчин нөхцөл.	Мэдээллийн агуулга, эх сурвалжийг үнэлэн дүгнэхэд шаардлагатай шалгуур, хэм хэмжээний тухай ойлголт.	Мэдээллийн хэрэгсэл хэрхэн ажиллаж, мэдээллийг хэрхэн бүтээдэг, мэдээллийг үйлдвэрлэх үйл явцын нийгэм, соёлын орчин, хэрэглэгчдийн хэрэглээ, зорилго.

<p>Заах арга</p> <p>Мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл</p> <p>Зохион байгуулах, удирдан зохицуулах</p> <p>Багшийн хөгжил, мэргэжлийн ахиц дэвшил</p>	<p>Сургалтын танхим дахь үйл явцад мэдээлэл, мэдээллийн хэрэгслийг нэвтрүүлэх.</p>	<p>Мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн үйлчилгээний агуулгыг асуудал шийдвэрлэх зорилгоор үнэлэн дүгнэх.</p>	<p>Хэрэглэгчийн зүгээс заах, суралцах зорилгоор мэдээлэл бэлтгэж, ашиглах.</p>
	<p>Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл: сонин, сэтгүүл. Мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага: номын сан, архив, музей, ном, сэтгүүл г.м.</p>	<p>Өргөн нэвтрүүлгийн байгууллага: радио, телевиз</p>	<p>Мэдээллийн шинэ хэрэгсэл: Интернет, нийгмийн сүлжээ, мэдээлэл түгээх бусад хэрэгсэл (компьютер, гар утас гэх мэт).</p>
	<p>Танхимыг хэрхэн зохион байгуулах тухай мэдлэг.</p>	<p>Хэвлэл мэдээллийн суурь мэдлэгэд тулгуурласан хамтын ажиллагаа.</p>	<p>Хэвлэл мэдээллийн суурь мэдлэгийг насан туршийн суралцах үйл явцад нэвтрүүлэх.</p>
	<p>МХМСБ-ыг иргэний боловсрол, мэргэжлийн хүрээнд болон засаглалд хэрхэн ашиглах тухай мэдлэг.</p>	<p>Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн нөөцийг үнэлэн дүгнэх, зохион байгуулах замаар мэргэжлийн сурах үйл явцад ашиглах.</p>	<p>Манлайлагч, үлгэр жишээ иргэн. Багш, оюутны хөгжилд зориулж МХМСБ-ыг сурталчлан таниулах үйл явцыг манлайлах.</p>

Бодлого, алсын зорилго

МХМСБ-ыг боловсролын тогтолцооны бүхий л шатанд тууштай, үе шаттайгаар нэвтрүүлэхэд үндэсний хэмжээний бодлого чухал үүрэгтэй. Боловсролын салбарын үндэсний бодлого стратеги, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээлэл хүртэх эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх хууль болон олон улсын бусад баримт бичиг, тэдгээр нь хэвлэл мэдээллийн суурь боловсролын бодлоготой хэрхэн уялдаж буйн талаар ойлголттой болох нь МХМСБ-ыг өөрийн орчинд нэвтрүүлэх гэж буй багш нарын юун түрүүнд хийх ёстой ажлын нэг юм. МХМСБ-ын нэгдсэн бодлого байхгүй бол багш нар үүнийг сурталчлан таниулахад ямар үүрэг хариуцлага хүлээж болох талаар эргэцүүлэх нь зүйтэй. Хэрэв байдаг бол тэрхүү бодлого нь цаг үеийн шаардлага хэрэгцээ, олон улсын хэм хэмжээ, шилдэг туршлагыг хэрхэн харгалзаж, хангадаг вэ? Одоо үйлчилж буй бодлогыг хэрхэн шинэчлэн сайжруулж болох вэ гэх зэргийг хэлэлцэх нь зүйтэй. Тийм учраас МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд хэвлэл, мэдээллийн суурь боловсролын бодлого, алсын зорилго, тэдгээр нь ерөнхий боловсрол болон багшийн сургалтад хэрхэн нөлөөлж буйн тухай хэлэлцэх явдал голлох үүрэгтэй байдаг. Энэхүү хэлэлцүүлэг нь бодлого, алсын зорилгыг задлан шинжлэх үйл явцад хөтлөх учиртай бөгөөд нэн ялангуяа тэрхүү бодлого нь хэвлэл мэдээллийн суурь боловсрол бүхий багш, оюутан сурагчийг бэлтгэхтэй хэрхэн уялдаж буйг шинжихэд онцгой чухал ач холбогдолтой. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн суурь боловсрол бүхий нийгмийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд багш нарын гүйцэтгэх үүрэгт анхаарлаа хандуулах нь чухал юм.

22

Ардчилсан хэлэлцүүлэг болон нийгмийн оролцоонд шаардагдах мэдээллийн хэрэгсэл болоод мэдээллийн тухай мэдлэг

Энэхүү өргөн хүрээний сэдвийн зорилго нь мэдээллийн хэрэгсэл, номын сан, архив болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагыг үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэх, соёл хоорондын харилцан солилцоог хөхүүлэн дэмжих, олон ургальч бөгөөд хүлээцтэй байх, багш, оюутан сурагч болон иргэний чадварыг хөгжүүлж, сайн засаглал, ардчилсан хэлэлцүүлгийг дэмжихэд мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл ямар үүрэгтэй байдаг талаар шүүмжлэлт хандлага, мэдлэгийг бий болгох явдал юм.

Энэхүү уялдаа холбоог 3 дугаар зураг дээр харуулсан болно. Уг сэдэв нь мэдээлэл болон мэдээллийн хэрэгслийн ач холбогдол, гүйцэтгэх үүргийн талаарх өөр хоорондоо хамаарал бүхий, зарим талаараа давхардаж буй олон янзын асуудлыг хамруулж буй юм. Үүнд:

Иргэд хоорондоо мэдээлэл солилцох хэрэгсэл буюу суваг;

Мэдээлэл, санаа бодлыг түгээх;

Засгийн эрх баригч, тэдний эрхэнд буй хүмүүс болон хувийн хэвшлийнхний мэдээллийн тэнцвэргүй байдлыг арилгах;

Нийгмийн янз бүрийн этгээд хоорондын мэдээлэлд суурилсан мэтгэлцээнийг хэрэгжүүлж, зөрчилдөөнийг ардчилсан арга хэрэгслээр шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

Нийгмийн тухай мэдлэг хуримтлуулж, хамтын мэдрэмжийг бий болгох хэрэгсэл болох нь;

Соёлын илэрхийллийн суваг, үндэстэн дотор болон үндэстэн хоорондын ойлголцлыг дэмжих хэрэгсэл болох нь;

Засгийн эрх барих бүхий л хэлбэрийн хоточ нохой нь байж, олон нийтийн дунд ил тод байдлыг сурталчлан дэмжих, эрх баригчдын авилгал, хэрэг зөрчлийг илрүүлэх;

Эдийн засгийн үр ашигтай байдлыг дэмжих хэрэгсэл болж ажиллах нь;

Ардчилсан үйл явц, чөлөөт, шударга сонгуулийг дэмжих нь;

Бие даасан нийгмийн субъектийн хувьд олон нийтийн өмгөөлөгч нь байхын зэрэгцээ олон эшт байдлыг хүндэтгэх (жишээлбэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл);

Нийгмийн хамтын ой санамж байх нь (жишээлбэл номын сангууд);

Соёлын өвийг хадгалан хамгаалах;

Мэдээлэлд хүрэх үүд хаалга нь байх;

Олон нийтэд нээлттэй байх замаар цахим технологиос үүдэлтэй нийгмийн ялгааг багасгах;

Номын сангуудыг мэдээллийн агентлаг, суралцах үйл явцыг дэмжих төв нь хэмээн үзэх явдлыг дэмжин дэлгэрүүлэх;

Номын сан бүрт мэдээллийн нөөцийн бүхий л хэлбэрийг ашиглахыг дэмжин сурталчлах;

Мэргэжлийн номын сангуудаар дамжуулан башлах, сурах, сурахад суралцах үйл явцыг дэмжих

Номын сангийн хэрэглэгчийг гэгээрүүлэх.

(ЮНЕСКО-гоос 2008 онд боловсруулсан Хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурлав.)

Сайн засаглалын үндсэн тулгуур багана болох ил тод байдал, хариуцлага, иргэний оролцоо зэргийг нээлттэй мэдээлэл болон чөлөөт мэдээллийн хэрэгсэлгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм. Эдгээр нь амьд, эрч хүчтэй иргэний нийгмийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд үүнд дараах зүйлс хамаарна:

Нийгмийн янз бүрийн хэсэг бүлэгт ойлгомжтой, тэдэнд ач холбогдол бүхий

мэдээлэл, мэдлэгийг дамжуулах;

Ардчилал, сайн засаглалын үнэт зүйлсэд үнэнч байх хандлага, үйл явцыг хөхүүлэн дэмжих.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөр нь мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн тухай суурь боловсролыг сургалтын танхимд нэвтрүүлэхийн тулд шаардлагатай мэдлэг чадварыг хөгжүүлэх арга, агуулгаар багш нарыг хангана. Ингэхдээ оюутан сурагчдын санал бодол, дуу хоолойг үнэлж, жендерийн мэдрэмжтэй заах арга барилыг санал болгож буй юм. Өөрийгөө илэрхийлэх, дуу хоолойгоо бусдад хүргэж, олон талын ойлголт, хандлагыг бий болгохын тулд мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэлтэй хэрхэн харьцах тухай асуудал энд голлох үүрэг гүйцэтгэнэ. Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага нь мэргэжлийн сурах үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлж өгдөг. Зарим улс оронд эдгээрийг нээлттэй болон зайны сургалтад (НЗС), мөн багш нарын мэргэжлийн шат ахиулах сургалтад (МШАС) ашигладаг.

Мэдээллийн төрөл бүрийн хэрэгсэл болон мэдээллийн нөөцийг мэргэжлийн хүрээнд хэрхэн ашиглаж, багш нарын мэргэжлийн мэдээлэл солилцоог хэрхэн дэмжиж болох талаар энэхүү хөтөлбөрт тусгасан байгаа. Янз бүрийн нийгмийн орчин, газар зүйн хүрээнд ажиллаж, амьдарч буй багш нар мэргэжлийн хувьд мэдлэг, мэдээллээ хэрхэн дээшлүүлдэг талаар туршлага хуваалцах нь чухал юм.

24

ЗУРАГ 3: МХМСБ ардчилал, сайн засаглалд гүйцэтгэх үүрэг



МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙГ ҮНЭЛЭХ

Асуудлыг шийдвэрлэх чадвар болон шүүмжлэлт сэтгэлгээ нь сургуулийн бүхий л хичээл болон өдөр тутмын амьдралд суралцах үйл явцын амин сүнс нь байх ёстой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд нийгэмд болон амьдралд тулгамдаж буй янз бүрийн асуудалтай холбоотой, төрөл бүрийн эх сурвалжаас гаралтай мэдээллийн агуулгыг шүүмжлэлтэйгээр үнэлж цэгнэх дадлага хийж болох юм. Ингэснээр мэдээллийн эх сурвалжийг нягталж, мэдээллийн хэрэгсэл, номын сан, архив болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагын үйлчилгээ болон мэдээллийг нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлагатай нь харьцуулан үнэлэх багш нарын чадавхыг сайжруулах бололцоотой бөгөөд чухам ийм зорилгыг хөтөлбөрийн энэ хэсэгт дэвшүүлж байна. Түүнчлэн мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байууллага гүйцэтгэх ёстой үүргээсээ хазайх буюу биелүүлэхгүй байх тохиолдолд хэрхэх тухай мэдлэгийг багш нарт олгох нь энэхүү багц сэдвийн бас нэгэн зорилго юм. Багш нар мэдээллийн хэрэгсэл хэрхэн ажиллаж, мэдээллийг хэрхэн үйлдвэрлэдэг тухай мэдлэгтэй болохын зэрэгцээ тэдний түгээж буй мэдээллийг хэрхэн үнэлж болох, мэдээллийг янз бүрийн зорилгоор хэрхэн ашиглаж болох тухай мэдлэгтэй болох ёстой юм. Мөн мэдээллийн төрөл бүрийн хэрэгслээр асуудал, юмс, үзэгдийг хэрхэн дүрсэлж буй, орон нутгийн болон олон улсын мэдээллийн хэрэгслээр олон эшт байдлыг хэрхэн харгалзаж буйг олж харах чадвартай болох ёстой. Үүний зэрэгцээ оюутан сурагчид янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээллээ хэрхэн ойлгож, тайлбарлаж буйг үнэлэх чадвартай болох юм.

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭХ БОЛОН ХЭРЭГЛЭХ ДАДЛАГА

МХМСБ-ын сургалтын хөтөлбөр нь багш нарыг мэдээллийн сувгуудтай харьцах, мэдээлэл солилцох болон үзэл бодол, байр сууриа илэрхийлэх чадвартай болгоно. Үүнд олон улсын стандарт, соёлын олон эшт байдлын хэм хэмжээнд тулгуурласан хэвлэл мэдээллийн ёс зүй, мэдээллийн ёс зүйн тухай мэдлэг багтана. Багц хичээлийн үр дүнд багш нар МХМСБ-ын сургалтын материал, хэрэгслийг тухайн хичээлийн зорилго, оюутны сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сонгож, тохируулан ашиглах буюу шинээр боловсруулах чадвартай болсон байна. Үүний зэрэгцээ багш нар суралцагсдад мэдээллийн хэрэгслийг сурах зорилгоор ашиглаж сурахад нь туслах чадвартай болох юм. Үүнд ялангуяа мэдээлэл олж авах болон мэдээллийг бүтээхэд дэмжлэг үзүүлэх багш нарын чадавх хамаарна.

Мэдээллийг хэрхэн бэлтгэх болон хэрэглэх тухай багц хичээлд суралцагсдын эрэн сурвалжлах, шүүмжлэлтэйгээр сэтгэх чадварыг дэмжих зорилго бүхий шавь төвтэй сургалтын арга барилыг ашиглах юм. 21 дүгээр зуунд мэдлэг олж авах чухал арга бол хийнгээ суралцах арга мөн. Мэдээллийн дадлага хичээл нь сурагчдад текст болон дүрс бэлтгэх буюу оролцооны аргаар хийнгээ суралцах боломжийг бүрдүүлэх ёстой юм. Ингэхийн тулд энэхүү үйл явцад багш нар идэвхтэй үүргийг гүйцэтгэх ёстой. Учир нь уламжлалт болон шинэ мэдээллийн хэрэгслийн аль алинд нь хэрэглэгчдийн бэлтгэсэн мэдээлэлд ихээхэн анхаарал хандуулж буй билээ. Нийгмийн сүлжээний янз бүрийн сувгаар бусад хэрэглэгчтэй харьцах боломжтой байдаг нь залуу хүмүүс Интернэтийг ашиглаж буйн хамгийн чухал шалтгаан болсоор байна. Хөгжиж буй улс оронд ч энэ нь хамааралтай: Африк болон Хойд Азид иргэд гар утсаа ашиглан мэдээлэл авч, бусдад дамжуулан, өөрсдийн амьдралд хамаарал бүхий нийгмийн болон улс төрийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх нь улам бүр түгээмэл болж байна. Тиймээс хүүхэд залуучуудын хамгийн түгээмэл ашиглаж буй энэхүү чадварыг багш нар нэн тэргүүнд эзэмшиж, заах үйл явцад ашиглах нь зүйн хэрэг билээ.

26

Багш нар хичээл заах зорилгоор мэдээлэл бэлтгэх болон ашиглах чадвартай болохын хэрээр тэд мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг сургуулийн хөтөлбөрийн хүрээнд сурталчлан таниулахад манлайлах үүргийг гүйцэтгэх хэмжээнд хөгжих юм. Тэд МХМСБ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж, холбогдох хичээлээр мэргэшихийн хэрээр МХМСБ-ыг сургуульдаа болон нийгэмд түгээх тэргүүн эгнээний иргэд болох юм.

БАГШИЙН ҮНДСЭН МЭДЛЭГ ЧАДВАР

Хүснэгт 2-т сургалтын хөтөлбөрийн өргөн хүрээний зорилго, тэдгээртэй холбоотой багшийн ур чадварыг толилуулж байна. Эдгээр нь МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн хичээл тус бүр дээр багш нарын эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг багцаалсан болно. Холбогдох сэдвийн хүрээнд багш нар ур чадвараа хэрхэн хөгжүүлсэн байхыг төлөвлөн тооцоолох замаар хөтөлбөрөөс хүлээж болох үр дүнг харуулахыг зорьлоо.

Хүснэгт 2: ЮНЕСКО-гийн МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн зорилго ба багш нарын ур чадвар

Хөтөлбөрийн сэдэв	Хөтөлбөрийн зорилго	Багшийн чадвар
Бодлого ба хэтийн зорилго	МХМСБ-ыг хөгжүүлэхэд шаардлагатай бодлого, хэтийн зорилгын талаар багш нарын ойлголт, мэдлэгийг сайжруулах.	Багш нар МХМСБ-ыг хөгжүүлэхийн тулд ямар бодлого шаардлагатай, боловсрол олгох үйл явцад (болон нийгэмд) бодлогыг хэрхэн хэрэгжүүлж болохыг ойлгож авна. МХМСБ нь амьдрах ур ухаан болон иргэний боловсролын хүрээнд хувь хүний хөгжлийг хэрхэн дэмждэг талаар мэдлэгтэй болно.
Хөтөлбөр ба үнэлгээ	МХМСБ-ын нөөц боломж, тэдгээрийн ач холбогдлыг онцлон тодотгох.	Багш нар мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн тухай мэдлэг боловсролыг сургуулийн хөтөлбөрт хэрхэн ашиглаж болох талаар мэдлэгтэй болно. Тэд мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг харгалзаж хэвлэл мэдээллийн агуулга болон эх сурвалжийг шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэх чадвартай болно. Үүний тулд мэдээллийн олон эх сурвалжаас өргөн хүрээний материал сонгож авч чаддаг болно. Багш нар мөн оюутан сурагчдын МХМСБ-ын тухай ойлголтыг үнэлэх чадвараа хөгжүүлнэ.
Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол	Мэдээллийн бүхий л төрлийн хэрэгсэл болон номын сан, архив, Интернэт гэх мэт мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн тухай багш нарын мэдлэгийг сайжруулах.	Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэх бусад хэлбэрийн хэрэгсэл өнөөгийн дүр төрхөө хэрхэн олж хөгжсөнийг багш нар мэддэг болно. Тэд янз бүрийн зорилгоор хэвлэмэл болон цахим мэдээллийн хэрэгсэл, ер нь байгаа бүхий л технологийг ашиглах чадвараа хөгжүүлнэ. Багш нар мэдээллийн төрөл бүрийн хэрэгсэл болон мэдээллийн нөөц боломжийг шүүмжлэлт сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх чадвараа хөгжүүлэх зорилгоор ашиглаж, үүнийгээ оюутан сурагчдад дамжуулан түгээж чаддаг болно.

Зохион байгуулах, удирдан зохицуулах	Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн нөөц боломжийг заах болон сурах үйл явцын салшгүй хэсэг болгож үр дүнтэйгээр зохион байгуулахын тулд анги танхимыг хэрхэн зохицуулах багш нарын мэдлэг, чадварыг хөгжүүлэх.	Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол бүхий багш нар анги танхимын зохион байгуулалтыг ойлгодог байх ёстой. Тэд янз бүрийн мэдээллийн хэрэгсэл, сувгийг үр дүнтэйгээр ашиглахад тохиромжтой орчин нөхцлийг бүрдүүлэх чадвартай болно. Ингэхдээ сургалтын танхимд олон эшт байдлыг хүндэтгэсэн уур амьсгал бүрдүүлж, нийгмийн гарал, хүйсээр үл ялгаварлах хандлагыг төлөвшүүлж чаддаг болно.
Заах арга	Багш нарын заах аргыг сайжруулах буюу мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн суурь боловсрол олгоход шаардлагатай заах аргын шинэчлэлд нөлөөлөх.	Мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн суурь боловсрол бүхий багш нар МХМСБ-ын холбогдох хичээлийг заахад шаардлагатай сургах ухааны ур чадварыг эзэмшсэн байх ёстой. Тэд МХМСБ олгохдоо сайн засаглал, хөгжил, соёлын ойлголцлын үүднээс ажиллана. Тэд оюутан сурагчдын мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн харьцаж, ямар хариу үйлдэл үзүүлж буйн талаар мэдлэгтэй болох бөгөөд энэ нь сурагчдын мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн тухай сурах үйл явцыг дэмжих эхний алхам байх ёстой. Үүний зэрэгцээ багш нар МХМСБ-д хамааралтай үндсэн онолууд болон бүтэц, судлах аргын талаар мэдлэгтэй болж, ингэснээр эдгээрийг оюутнуудад сонирхолтой, утга холбогдолтойгоор заах туршлага хуримтлуулна.
Багшийн мэргэжлийн хөгжил	Мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн нөөц боломжийг багш нар мэргэжлийн болон хувь хүний хувьд идэвхтэй ашигладаг болгоход багшийн боловсролын байгууллагын анхаарлыг хандуулж, сургалтыг үүнд төвлөрүүлэх.	Багш нар хэрэгцээтэй мэдээллээ олж авч мэргэжлийн хувьд өсөж хөгжихийн тулд мэдээллийн хэрэгсэл, холбогдох технологийг үр дүнтэйгээр ашиглах чадвартай болсон байна.

Энэхүү хөтөлбөрт есөн үндсэн сэдэв буюу заавал үзэх хичээлийн хувилбар, хоёр үндсэн бус сэдэв, МХМСБ-ын хөтөлбөрийг баяжуулах зорилго бүхий гурван сэдэв буюу хичээл багтаалаа. Сэдвийн агуулга, үйл ажиллагааны ерөнхий явцыг багш нар болон багш бэлдэх байгууллагууд өөрийн орны нөхцөлд тохируулан өөрчилж болно. МХМСБ-ын хөтөлбөрт багтсан сэдэв, нэгжүүдтэй уялдаа бүхий мэдлэг чадварын дараах жагсаалт нь хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд багш нарын эзэмших мэдлэг, чадварыг толилуулж байна.

МХМСБ-ын чадвар 1: АРДЧИЛАЛД МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ОЙЛГОЖ МЭДЭХ

Дараах сэдвийг үзэх явцад дээрх чадварыг хөгжүүлнэ:

Сэдэв 1, Иргэний үүрэг оролцоо, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө, мэдээлэл солилцох ардчилсан үйл явц буюу ардчилсан хэлэлцүүлэг, насан туршийн сурах үйл явц; Сэдэв 2, Сэтгүүлзүй, мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн ёс зүйн удиртгал ; Сэдэв 9, Мэдээллийн харилцаа, МХМСБ ба сурах үйл явц.

МХМСБ-ын багш мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл түгээгч бусад сувгийн үйл ажиллагааны талаар ойлголттой болж, иргэний оролцоо, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх ач холбогдлыг нь үнэлэх чадвартай болно.

Энэхүү чадварыг хөгжүүлснээр багш дараах зүйлсийг түвэггүй гүйцэтгэдэг болно:

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл түгээгч бусад сувгийн нийгэмд үйлчлэх үүргийг тодорхойлж, үнэлж дүгнэх.

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан хүний үндсэн эрх гэх зэрэг гол гол түлхүүр ойлголтуудыг мэддэг байх.

Мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн суурь боловсрол, иргэний оролцоо болон ардчиллын уялдаа холбоог тайлбарлаж, томъёолох.

Олон ургальч мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл түгээгч сувгуудыг соёлын ойлголцол, солилцооны индэр болохынх нь хувьд тайлбарлан томъёолж, ач холбогдлыг нь тодорхойлох.

Редакцийн хараат бус байдлыг тайлбарлах.

Сэтгүүлзүй олон нийтэд үйлчлэх үүрэгтэйн хувьд нятглан шалгах эрдэм болохыг нь тайлбарлах.

Мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн ёс зүйг томъёолон тодорхойлох, ёс зүйн зөрчлийг олж таних чадвартай байх.

МХМСБ-ын чадвар 2: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН АГУУЛГА, ХЭРЭГЛЭЭГ ОЙЛГОХ

Энэхүү чадварыг дараах хичээл хөгжүүлнэ:

Сэдэв 2, Сэтгүүлзүй, мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн ёс зүйн удиртгал; Сэдэв 3, Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэлд нийгмийн янз бүрийн төлөөллийг дүрслэх нь; Сэдэв 4, Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн хэл; Сэдэв 10, Хэрэглэгчид; Сэдэв 5, Сурталчилгаа.

МХМСБ-ын багш мэдээллийн хэрэгслийг хүмүүс хувийн болон олон нийтийн амьдралд хэрхэн ашигладаг, иргэд болон мэдээллийн агуулгын хооронд ямар харилцаа үүсдэг, өөр бусад ямар зорилгоор мэдээллийн хэрэгслийг ашиглаж болох талаар мэдлэгтэй болсон байна.

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд багш дараах зүйлсийг чаддаг болсон байна:

Мэдээллийн агуулгыг түүний далд утга санаа болон үнэт зүйлстэй харьцуулж, уялдаа холбоог гаргаж тайлбарлах.

Мэдээллийн хэрэгслээр хэвшмэл ойлголт, хандлагыг хэрхэн түгээж буйг тодорхой аргаар задлан шинжилж чаддаг байх (жишээлбэл хэсэг бүлэг хүний ашиг сонирхолд үйлчилж, бусдынх нь эрхийг хохироож буй хэвшмэл ойлголт буюу төсөөллийг олж таних; дүрст мэдээллийн хэрэгслээр хэвшмэл ойлголтыг түгээхэд зонхилон ашигладаг арга техникийг олж таних).

Сурталчилгаанд түгээмэл ашигладаг олон улсын стандарт, хэм хэмжээг зөрчиж буй арга хэрэгслийг олж тогтоох, задлан шинжлэх, шүүмжлэх.

Мэдээллийн агуулгад нийгмийн янз бүрийн төлөөллийг бүрэн дүүрэн, хагас дутуу, эсвэл бодит байдлаас зөрүүтэйгээр дүрсэлж буй эсэхийг олж тогтоох, тайлбарлах.

Олон нийтийн статус бүхий өргөн нэвтрүүлгийн байгууллагын шинж чанар, шалгуур үзүүлэлт, ач холбогдлыг ойлгож, тайлбарлах.

30

МХМСБ-ын чадвар 3 : МЭДЭЭЛЛИЙГ ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙГААР ХҮРТЭХ

Хөтөлбөрт багтсан дараах хичээлүүд энэхүү чадварыг хөгжүүлнэ:

Сэдэв 1, Иргэний үүрэг оролцоо, Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө, мэдээлэл солилцох ардчилсан үйл явц, насан туршийн суралцах үйл явц; Сэдэв 7, Интернэтийн боломж, бэрхшээл; Сэдэв 8, Мэдээллийн боловсрол, номын сан ашиглах чадвар.

МХМСБ-ын багш тодорхой зорилгод шаардлагатай мэдээллийн төрлийг тодорхойлж, үр ашигтай, үр дүнтэй байдлаар тухайн мэдээллийг олж авах чадвартай болно.

Энэхүү чадварын үр дүнд багш дараах зүйлсийг гүйцэтгэж чаддаг болно:

Судалгаа хийх, мэдээлэл олж авахын тулд үр ашигтай бөгөөд үр дүнтэй аргыг сонгох.

Шаардлагатай мэдээллийг олж авах түлхүүр үг, холбогдох нэр томъёог тогтоож тодорхойлох.

Боломжит мэдээллийн эх сурвалжийн төрөл, хэлбэрийг тогтоох.

Мэдээллийг сонгох болон шийдвэр гаргахад шаардлагатай шалгууруудыг тодорхойлох.

МХМСБ-ын чадвар 4: МЭДЭЭЛЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖИЙГ ШҮҮМЖЛЭЛТЭЙГЭЭР ҮНЭЛЭХ

Энэхүү чадварыг дараах хичээлүүд хөгжүүлнэ:

Сэдэв 3, Мэдээллийн хэрэгслээр нийгмийн янз бүрийн төлөөллийг дүрслэх нь; Сэдэв 5, Сурталчилгаа; Сэдэв 7, Интернэтийн боломж, бэрхшээл; Сэдэв 8, Мэдээллийн суурь боловсрол, номын сан ашиглах чадвар; Сэдэв 9, Мэдээллийн харилцаа, МХМСБ ба сурах үйл явц.

МХМСБ-ын багш мэдээлэл, түүний эх сурвалжийг шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэж, сонгосон мэдээлэлдээ тулгуурлан асуудлыг шийдвэрлэх, задлан шинжлэх чадвартай болсон байна.

31

Энэхүү чадварт дараах зүйлс багтана:

Янз бүрийн эх сурвалжаас олж авсан мэдээллийг харьцуулан шинжих замаар тухайн мэдээллийн найдвартай байдал, хүчин төгөлдөр, нягт нямбай бөгөөд тодорхой эсэх, цаг хугацааны ач холбогдол, өрөөсгөл эсэхийг тогтоох.

Төрөл бүрийн шалгуур ашиглан (жишээлбэл тодорхой эсэх, нягт нямбай, өрөөсгөл буюу нэг талыг барьсан эсэх, баримт сэлт нь найдвартай буюу хүчин төгөлдөр эсэх) мэдээллийн хэрэгслийг үнэлэн дүгнэх (жишээлбэл цахим хуудас, баримтат кино, сурталчилгаа, мэдээллийн хөтөлбөр гэх мэт).

Хувийн бодол, хэвшмэл ойлголтод суурилсан өрөөсгөл хандлага, хууран мэхлэх, мушгин гуйвуулах явдлыг таньж ялгах.

Тухайн мэдээллийг бэлтгэхэд нөлөөлсөн соёлын, нийгмийн болон бусад орчин нөхцлийг таньж мэдэх, мэдээллийг ойлгоход орчин нөхцөл хэрхэн нөлөөлдгийг ойлгож мэдсэн байх.

Мэдээллийн технологийн олон төрлийг ойлгож, үзэл бодлын харилцан хамаарлыг судлан шинжлэх.

Шинэ мэдлэгийг урьдынхтай нь харьцуулж, нэмэлт мэдээллийн үнэ цэнэ, зөрчил ялгаа гэх мэт мэдээллийн бусад шинжийг тодорхойлох.

Мэдээллийн эх сурвалжийг нягтлан шалгах замаар мэдээллийн үнэн зөв,

нягт нямбай байдлыг тодорхойлох, мэдээлэл цуглуулах төрөл бүрийн хэрэгсэл, арга барилын сул тал, зааг хязгаарыг олж харах, аливаа дүгнэлтийн үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

Мэдээллийн агуулгыг тайлбарлах янз бүрийн арга техникийг ашиглах (жишээлбэл дүгнэлт гаргах, ерөнхийлөх, үзсэн мэдээллээ шинжих, үзэл бодол, байр сууриа бататгахын тулд тухайн мэдээллийн хэрэгслээр гаргасан дүрсийг ашиглах, өрөөсгөл буюу нэг талыг барьсан мэдээллийг тогтоохын тулд мэдээллийн хэрэгслийг задлан шинжилж, далд агуулгыг ил болгох).

МХМСБ-ын чадвар 5: ШИНЭ БОЛОН УЛАМЖЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ

Хөтөлбөрт багтсан дараах хичээлээр энэхүү чадварыг хөгжүүлнэ:

Сэдэв 6, Шинэ болон уламжлалт мэдээллийн хэрэгсэл; Сэдэв 7, Интернэтийн боломж, бэрхшээл; Сэдэв 3, 5-р хэсэг Компьютерийн тусламжтайгаар дуу дүрс засварлах; Сэдэв 4, 4-р хэсэг, Дүрсний өнцөг, зураг авалтаар утга агуулгыг бий болгох, дамжуулах.

МХМСБ-ын багш цахим технологи, мэдээллийн харилцааны хэрэгсэл болон сүлжээг мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргахад хэрхэн ашиглахыг мэддэг болж, ач холбогдлыг нь ойлгоно.

32

Энэхүү чадварт дараах зүйлс багтана:

Цахим технологийн үндсэн ойлголттой байх, мэдээллийн харилцааны төрөл бүрийн хэрэгсэл болон сүлжээг ойлгодог, тэдгээрийг янз бүрий орчин нөхцөлд, янз бүрийн зорилгоор ашиглаж чаддаг байх.

Төрөл бүрий мэдээллийн хэрэгслийг ашиглан (жишээлбэл уламжлалт хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл, цахим болон электрон мэдээллийн хэрэгсэл гэх мэтийг) үзэл бодол, байр сууриа тухайн хэрэгсэлд тохирох хэлбэрээр илэрхийлэх.

Цахим хайлт хийх анхны мэдэгдэхүүнтэй байх.

Залуу хүмүүс болон өсвөр үеийнхэн Интернэтийг ямар зорилгоор ашиглаж буйг мэддэг байх.

МХМСБ-ын чадвар 6: МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГЫН НИЙГЭМ, СОЁЛЫН ОРЧИН НӨХЦЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Энэхүү чадварыг дараах хичээлээр хөгжүүлнэ:

Сэдэв 1, Иргэний үүрэг оролцоо, Үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө. Мэдээлэл солилцох ардчилсан үйл явц, насан туршийн суралцах үйл

явц; Сэдэв 2, Сэтгүүлзүйн болон мэдээллийн ёс зүйн удиртгал; Сэдэв 3, Нийгмийн янз бүрийн төлөөллийг мэдээллийн хэрэгслээр дүрслэх нь; Сэдэв 11, Мэдээллийн хэрэгсэл даяаршсан орчин нөхцөлд.

МХМСБ-ын багш мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээллийг нийгэм, соёлын тодорхой орчин нөхцөлд бэлтгэдэг гэдгийг ойлгож, мэддэг болсон байна.

Энэхүү чадварт дараах зүйлс багтана:

Мэдээллийн төрөл зүйлд хамааралтай мэргэжлийн дүрэм журам, хэлбэр загварыг тодорхой зорилго, үр дүнд хүрэхийн тулд хэрхэн гуйвуулан ашиглаж болохыг задлан шинжилж, тайлбарлах.

Олон ургальч хандлагад суурилсан мэдээллийн бичвэр бэлтгэх.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл түгээгч бусад сувгийг соёлын харилцан ойлголцлыг дэмжих индэр болохынх нь хувьд таньж, тодорхойлох.

Ардчилсан нийгмийн иргэний үүрэг оролцоо, соёлын олон эшт байдлыг дэмжих үүднээс орон нутгийн мэдээллийн хэрэгслээр хүлээн авч, дамжуулж буй мэдээллийн агуулгыг шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэх.

Дүрсийг засварласнаар мэдээллийн агуулга, санааг хэрхэн өөрчилж болохыг ойлгож мэдэх (жишээлбэл тодорхой өнцгийг зориудаар харуулахгүй байх, өнцөг, дүрсийг нэмж, хасах, сэдэв, санааг зориудаар тодотгох гэх мэт).

33

МХМСБ-ын чадвар 7: МХМСБ-ЫГ ОЮУТАН СУРАГЧДАД ТАНИУЛАН ОЙЛГУУЛАХ, ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Энэхүү чадварыг дараах хичээлээр хөгжүүлнэ:

Сэдэв 1, Иргэний үүрэг оролцоо, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө, мэдээлэл солилцох ардчилсан үйл явц ба насан туршийн сурах үйл явц; Сэдэв 9, Мэдээллийн харилцаа, МХМСБ ба сурах үйл явц; Сурах үйл явцад мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг ашиглах нь, ардчилсан хэлэлцүүлэг.

МХМСБ-ын багш МХМСБ-ын сургалтын явцад олж авсан мэдлэг, чадвараа ашиглан оюутан сурагчдын дунд МХМСБ-ыг таниулан сурталчилж, шаардлагатай өөрчлөлтийг сургуулийн орчин эхлүүлэн зохион байгуулах чадамжтай болно.

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд багш дараах зүйлсийг чаддаг болно:

Суралцагсад өөр өөрсдийн амьдралд мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн бүтээгдэхүүнийг хэрхэн ойлгож, ашиглаж буйг мэддэг болох.

Суралцагсдын мэдээллийн хэрэгслийн тухай мэдлэг, мэдээлэл ашиглах чадварыг дээшлүүлэх зорилгоор төрөл бүрийн заах арга, үйл ажиллагааг мэдэж, ашиглах.

Шаардлагатай мэдээллийг олж авахын тулд мэдээлэл хайх хамгийн тохиромжтой арга хэрэгслийг (жишээлбэл мэдээлэл хайх системүүдийг) хэрхэн ашиглах талаар оюутан суралцагсдад зааварчлах.

Сурах үйл явцад мэдээлэл болон түүний эх сурвалжид шүүмжлэлтэй хандаж, дүгнэн шинжлэх тухай заавар зөвөлгөө өгөх.

Оюутан сурагчдын дунд мэдээлэл олж авах идэвхтэй үйл ажиллагаа, нээлттэй харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж хөгжүүлэхийн тулд харилцааны шууд болон шууд бус арга болон мэдээллийн хэрэгслийн тухай мэдлэгээ ашигладаг байх.

Шүүмжлэлтэйгээр унших, үзэх, сонсох аргыг оюутан сурагчдын дунд хөгжүүлэхийн тулд үнэлгээний албан ба албан бус аргыг мэдэж, ашигладаг байх.

Мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн суурь боловсролын арга хэрэгслийг ашиглах замаар оролцоонд суурилсан заах аргын орчинг бүрдүүлэх.

Уламжлалт ба шинэ мэдээллийн хэрэгслийн технологийг ашиглан сургуулийн болон сургуулийн бус орчинд суралцах үйл явцын уялдаа холбоог хөгжүүлэх, үүнийг ялангуяа сургуулиас уйдсан оюутан сурагчдын идэвх сонирхлыг дээшлүүлэхэд ашиглах.

Мэдээллийн технологийг сургалтын танхимд ашиглах замаар оюутан сурагчдад өөрсдөд нь хүртээмжтэй мэдээллийн технологийг нээн илрүүлж, суралцах үйл явцдаа ашиглаж сурахад нь дэмжлэг үзүүлэх.

Мэдээллийн хэрэгслийг болон мэдээллийн суурь боловсролыг оюутан сурагчдын сурах үйл явцын оролцоог дээшлүүлэхэд ашиглах.

Мэдээллийн хэрэгсэл болон номын санг судалгаа хийх, сурах үйл явцад ашиглах сурагчдын чадварыг хөгжүүлэхэд шинээр олж авсан мэдлэгээ ашиглах.

Суралцагсдын мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг үнэлэн дүгнэх чадварыг хөгжүүлж, мэдээллийн ёс зүйг ойлгож мэддэг болгоход багш шинээр олж авсан мэдлэгээ ашигладаг байх.

МХМСБ-ыг заах болон сурах үйл явцад ашиглах заах арга барил

МХМСБ-ын хөтөлбөрт багтаасан хичээлийн хувилбаруудад ашиглах заах арга барилыг доор танилцуулж байна:

1. Асуудлыг судлах арга барил

Асуудлыг судлах арга барил нь шавь төвтэй сургалтын арга бөгөөд орчин цагийн мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролтой холбоотой төрөл бүрийн асуудалд анхааралыг хандуулахад чиглэгддэг. Үүнд судалгаа хийнгээ суралцах, асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах зэрэг үйл явцын бүрэлдэхүүн хэсгүүд багтдаг бөгөөд суралцагсад асуудлыг тодорхойлох, тухайн асуудалд хамаарал бүхий хандлага, үзэл бодлыг олж тогтоох, асуудлын цаана буй баримт, зарчмуудыг тодорхойлох, баримт нотолгоог олж, системчилж, задлан шинжлэх, асуудлыг тайлбарлан шийдвэрлэх, үйлдэл хийх, үр дагаврыг судлах зэрэг судалгааны алхмуудыг гүйцэтгэх замаар шинэ мэдлэг олж авдаг. Энэхүү арга нь суралцагсад тухайн асуудлыг гүнзгийрүүлэн судлах боломж өгдөг учир МХМСБ-ыг заахад тохиромжтой арга юм. Энэхүү аргыг тухайлбал мэдээллийн хэрэгслээр хүйсээр, эсвэл арьс өнгөөр ялгаварлан дүрслэх явдлыг задлан шинжлэх, анхан шатны эх материал болон хоёрдагч эх сурвалжийн материалд тулгуурлан хувийн нууцыг мэдээллийн хэрэгсэлд хэрхэн хөндөж буйг шинжлэх, мөн этнографик судалгаагаар цахим мэдээллийн хэрэгсэлд үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах үйл явц хэрхэн явагдаж буйг судлах зэргээр ашиглаж болох юм.

35

2. Асуудалд суурилсан сурах үйл явц (АССҮЯ)

Энэ нь олон янзын салбар шинжлэх ухааны уялдаа холбоог ойлгох суурь мэдлэг, чадварыг дээшлүүлж, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх арга ухааныг хөгжүүлдэг арга юм. Энэхүү аргыг анх Канадын Онтариогийн МакМастер Их Сургуульд ашигласан аж. Уг арга нь өндөр зохион байгуулалттай, сурах хамтын үйл явцад түшиглэдэг бөгөөд суралцагсад бодит амьдралын асуудал, бэрхшээлтэй нүүр тулж, гүнзгийрүүлэн судлах замаар хувь хүний болон бүлгийн мэдлэгээ хөгжүүлдэг юм. Сурах зорилго, судалгааны асуулт, арга барил, үр дүнг тодорхойлж үйл явцыг зохион байгуулах ажлыг эхнээс нь дуустал суралцагсад өөрсдөө хийнэ. Энэхүү аргыг тухайлбал тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн, өндөр үр дүнтэй нийгмийн маркетингийн ажлыг зохион байгуулах байдлаар ашиглаж болно.

3. Эрдэм шинжилгээний судалгаа

Эрдэм шинжилгээний судалгаанд судлаачид бодит ертөнцийг судалж, цуглуулсан баримтдаа түшиглэн тодорхой тайлбарыг санал болгох үйл явц хамаарна. Судалгааны үйл явцыг багц алхам буюу судалгааны үечлэлээр хялбаршуулан илэрхийлэх нь түгээмэл. Жишээлбэл ажиглалт хийх, судалгааны асуулт боловсруулах, судлагдсан байдлыг буюу тухайн цаг үеийг хүртэл мэдэж буй зүйлийг тоймлох, судалгааг төлөвлөх, туршилтын явцад олж авсан шинэ баримтыг өмнөх мэдлэгтэй харьцуулах, мэдээллийг цуглуулж, задлан шинжилж, тайлбарлах арга хэрэгслийг ашиглах, тайлбар санал болгох, үр дүнг түгээх зэрэг үйл явц багтана. Энэхүү аргыг МХМСБ-ын сургалтад ч ашиглах боломжтой. Жишээлбэл мэдээллийн хэрэгсэл дэх хүчирхийллийн үр нөлөөг судлах, цахим мэдээллийн хэрэгслээр бий болж буй бэсрэг нийгмийг судлах гэх мэт.

4. Кейс судалгаа

36

Кейс судалгааны арга гэж тодорхой цорын ганц тохиолдол, үйл явдлыг гүнзгийрүүлэн судлахыг хэлнэ. Энэ аргыг Харвардын Бизнесийн Сургуульд тогтмол өргөнөөр ашигладаг бөгөөд оюутнууд нь онолын мэдлэгээ амьдралын бодит тохиолдолд хэрхэн ашиглаж болохыг турших зорилгоор ийм судалгааг байнга хийдэг аж. Үүнийг МХМСБ-ын хичээлд ашиглах бүрэн боломжтой. Учир нь суралцагсад өдөр бүр мэдээллийн хэрэгсэл, бусад сувгаар түгээж буй олон төрлийн мэдээ, мессежтэй нүүр тулж байдаг. Кейс судалгааны арга нь үйл явдал, тохиолдлыг тодорхой өнцгөөс харах, мэдээлэл цуглуулах, олж авсан мэдээллээ задлан шинжлэх, үр дүнг тайлагнах цогц арга барилд сургадаг бөгөөд эцсийн дүнд суралцагсдын мэдээлэл олж авах, мэдээллийг судлах чадвар хөгждөг. Суралцагсад тодорхой үйл явдал, нөхцөл байдал, яагаад тийнхүү тохиолдсоныг илүү нухацтайгаар ойлгох чадвартай болдог. Кейс судалгааны арга нь мөн таамаг дэвшүүлэх, таамаг турших аргыг багтаадаг. Энэхүү аргыг жишээлбэл нэрд гарсан кино, олноор борлогдсон ном, олон хэрэглэгчийн таашаалд нийцсэн мэдээллийн хэрэгслийн тодорхой бүтээгдэхүүний маркетингийг судлах зэргээр ашиглаж болно.

5. Хамтаар суралцах үйл явц

Хамтаар суралцах үйл явц нь оюутан сурагчдыг хэсэг бүлгээр нэгэн зорилгын төлөө ажиллуулах сурганы арга ухаан. Хамтаар суралцах үйл явцад хосоор ажиллах энгийн үйл явцаас эхлээд төсөл дээр ажиллангаа суралцах, оюутнууд багшийн удирдамж дор нэг нэгнээсээ асуух, харилцан бие биедээ заах зэрэг олон

янзын арга багтах бөгөөд эдгээр нь бүгд онолын мэдлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцааны чадвар, сургуульд болон өөртөө илүү эерэгээр хандах хандлагыг сайжруулахын зэрэгцээ онолын олон ишт байдлыг сургалтын танхимд хэрхэн ашиглах анхны мэдэгдэхүүнтэй болгоход чиглэгддэг. Энэхүү арга нь бусадтай санаагаа хуваалцаж, бусдаас суралцах шаардлагыг бий болгодог тул мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн суурь боловсролын хичээлд ашиглахад нэн тохиромжтой юм. Хамтаар суралцах үйл явцыг жишээлбэл Википедиа-гийн цахим хуудаст хамтран ажиллах байдлаар ашиглаж болох юм.

6. Агуулгыг задлан шинжлэх буюу текстийн анализ

Суралцагсад мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээллийн төрөл зүйл, тэдгээрийн дүрэм, зарчмыг тодорхойлох замаар текстийн анализ хийж сурна. Хэл шинжлэлийн энэ арга нь суралцагсад холбогдох онолын үндсэн ойлголттой болоход туслах зорилготой. Тийм учраас суралцагсад хэл найруулгын олон аргаар тодорхой зорилтот бүлгийн анхаарлыг татахуйц мэдээллийн хэлбэрийг хэрхэн бүтээдгийг мэдэж авах ёстой. Бичвэрийг задлан шинжлэх аргын тусламжтайгаар суралцагсад мэдээллийн хэрэгслээр түгээж буй ямар ч мэдээллээс “техник”, “бэлэгдлийн” болон “ерөнхий” агуулгыг олж тогтоох чадвартай болно. Онолын хувьд бус, тухайн бодит орчин нөхцөлтэй нь уялдуулан ашиглах нь зүйтэй. Бичвэрийн анализыг жишээбэл дараах байдлаар ашиглаж болно: суралцагсад мэдээллийн хэрэгслээс өөрийн сонирхсон текстийг сонгож ирэхийг даалгана. Энэ нь цаг үеийн мэдээ, YouTube-ээс авсан видео бичлэг, эсвэл цахим мэдээллийн хэрэгслээс авсан өөр бичлэг байж болно. Суралцагсдыг бүлгээр ажиллуулж, өөрсдийнх нь сонгосон текст болон дүрсний зорилго, зорилтот бүлэг, зохиогч, тухайн текстийг бэлтгэхэд ашигласан арга техник болон орчин нөхцлийг задлан шинжлүүлж хэлэлцүүлнэ.

37

7. Контекст буюу орчин нөхцлийн задлан шинжилгээ

Суралцагсад мэдээллийн салбарт хамаарал бүхий байгууллага, технологи, зарим үндсэн онолтой холбогдуулан орчин нөхцлийн шинжилгээг хэрхэн хийх талаар анхны мэдлэг олгоно. Жишээлбэл: тухайн улсад ашиглаж буй кино, телевиз, видео тоглоомын ангиллын талаар сурч мэдэхэд нь туслах, мэдээллийн хэрэгслийн эзэмшил харъяалал болон төвлөрөл, ардчилал, үг хэлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж болохыг ойлгоход нь туслах гэх мэт.

8. Хөрвүүлэг

Энэ заах аргыг янз бүрийн хэлбэрээр, мэдээллийн төрөл бүрийн хэрэгсэлд тулгуурлан ашиглаж болно. Суралцагсад сургууль дээр болсон үйл явдлын талаар сонины мэдээ бичсэн байвал түүнийгээ онлайн радиод зориулан хөрвүүлж болох юм. Эсвэл хүүхдийн киноны хэсгийг үзээд бүлгээр ажиллаж, үзсэн хэсгийнхээ кино зохиолыг зураг авалтын төлөвлөгөө болгон бэлтгэх бөгөөд үүнд план зураг, өнцөг, кадр солиход ашигласан шилжилтийн элемент зэргийг багтаана. Эсвэл ямар нэгэн үлгэр, домгийг кино болгох төлөвлөгөө зохиож, зураг авалтын зураг төлөвлөгөөг гаргана. Эсвэл хэн нэгний тухай баримтат кино хийхээр төлөвлөж, бэлэн байгаа дүрс, зургийг цуглуулж, тэдгээрийнхээ тусламжтайгаар бэсрэг кино хийж болно.

9. Дүрд тоглох

Дүрд тоглох арга нь мэдээллийн хэрэгслийн болон суурь боловсролын хичээлд байнга ашигладаг аргуудын нэг. Багш нар мэдээллийн хэрэгслийн тухай сурах үйл явцыг суралцагсад бодитоор үзүүлэх зорилгоор дүрд тоглоно. Жишээлбэл багш дунд сургуулийн танхимыг бүтээж, оюутнууд дунд сургуулийн сурагч болж болно. Болж өнгөрсөн үйл явцыг суралцагсадтай хэлэлцэнэ. Мөн суралцагсад залуучуудад зориулсан телевизийн баримтат кино хийх багийн дүрд “тоглож” болох юм. Эсвэл мэдээллийн суурь боловсролын багшаас цахим мэдээллийн хэрэгслийн сэтгүүлч ярилцлага авах, мөн их сургуулийн элсэлтийн сурталчилгааны баг тухайн сургуулийн оюутнуудаас сурталчилгааны нэвтрүүлэгт зориулж оюутны амьдралын талаар ярилцлага авах жүжиглэлт хийж болно.

38

10. Үйлдвэрлэл

Энэхүү заах ухаан нь 21 дүгээр зуунд шинэ мэдлэг олж авах чухал аргын нэг болох хийнгээ суралцах зарчимд тулгуурладаг. Мэдээллийн хэрэгсэлтэй харьцах болон үйлдвэрлэх дадлага хичээл нь суралцагсад туршилт хийх, өөрсдөө оролдож, бүтээх боломж олгох бөгөөд мэдээллийн хэрэгсэлд зориулж дүрс, дуу, бичвэр зэргийг бэлтгэхдээ бүтээлч сэтгэлгээнд болон өөрийн дуу хоолой, бодол санааг илэрхийлэхэд суралцдаг. Үйлдвэрлэлийн дадлага хичээлээр оюутнууд жишээлбэл iMovie, Moviemaker зэрэг нээлттэй програм ашиглаж байгаль орчин гэх мэт сонирхож буй сэдвийнхээ талаар нэг минутын хугацаанд тодорхой өгүүлэмж бүхий санааг видео дүрсээр илэрхийлэх дасгал хийж болох юм.

Хавсралт: Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролын холбогдолтой зарим материал

Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол: Багш, оюутан, эцэг эх, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага

Энэхүү товхимолыг ЮНЕСКО-гоос Араб, Англи болон Франц хэлээр эрхлэн гаргасан юм. Уг бүтээл нь тодорхой хэмжээгээр ЮНЕСКО-гоос санаачилж, Европын Хорооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн МЕНТОР төслийн үр дүнд бий болсон бөгөөд МХМСБ-ын цогц гарын авлага боловсруулах анхны оролдлого байсан юм. МХМСБ-ын энэ удаагийн хөтөлбөр нь МЕНТОР төслийн гарын авлагыг багш нарын боловсролд зориулж баяжуулан шинэчилсэн хувилбар юм.

39

Товхимолд дараах асуудлуудыг хөндсөн болно: Мэдээллийн хэрэгслийн боловсрол олгох сургалтад юу багтах вэ? Ийм боловсрол олгох сургалтыг хэн хариуцах ёстой вэ? Хүчин төгөлдөр мөрдөж буй сургалтын хөтөлбөрт мэдээллийн хэрэгслийн тухай хичээлүүдийг хэрхэн шингээх вэ? Сургуулиас гадна гэр бүл ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээх үү? Мэргэжлийн хүмүүсийг оролцуулах шаардлагатай юу, хэрэв тийм бол тэднийг хэрхэн оролцуулах вэ? Мэдээллийн хэрэгслийн давуу болон сул талтай зөв харьцахын тулд олон нийт ямар бодлого баримтлах вэ?

Товхимолд сургалтын загварчилсан хөтөлбөр, багш нарт зориулсан гарын авлага, суралцагчийн гарын авлага, эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага, мэргэжлийн хүмүүстэй харьцах ёс зүйн гарын авлага болон Интернэтийн суурь боловсролын гарын авлага багтдаг.

Гарын авлагыг дараах холбоосоор орж үзэж болно: <http://unesdoc.unesco.org/images/0014/001492/149278e.pdf>

2. ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлт:

Эдгээр нь олон хэлнээ хөрвүүлсэн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур үзүүлэлт. Эдгээр үзүүлэлт нь мэдээллийн хэрэгсэлд олон нийтийн өмнө хүлээх үүргээ гүйцэд биелүүлэхийн тулд ямар орчин нөхцөл шаардлагатайг илэрхийлнэ. Шалгуур үзүүлэлтэд өөр хоорондоо уялдаа холбоо бүхий дараах таван нөхцөл багтана: зохицуулалтын тогтолцоо, мэдээллийн хэрэгслийн олон ургальч, олон эшт байдал; мэдээллийн хэрэгсэл ардчилсан хэлэлцүүлэг өрнүүлэх индэр болох нь; мэргэжлийн чадавхжуулах үйл ажиллагаа, дэд бүтцийн нөөц. Дараах холбоосоор орж үзнэ үү:

<http://unesdoc.unesco.org/images/0016/001631/163102e.pdf>

3. Мэдээллийн хэрэгслийн суурь боловсролын олон улсын уулзалт – Грюнвальдаас хойшхи ололт амжилт, бэрхшээл, шинэ чиг хандлага. Үнэлгээний шинэчилсэн шалгуур үзүүлэлт шаардлагатай юу?

40

Олон улсын уулзалт зөвлөлгөөнийг Парис хотноо (2007 оны 6 дугаар сард) ЮНЕСКО-гийн Францын Үндэсний Комиссоос Францын Боловсролын Яам болон Европын Хорооны дэмжлэгтэйгээр ЮНЕСКО-той хамтран зохион байгуулсан юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор орж авч болно: http://www.diplomatie.gouv.fr/fr/IMG/pdf/Synthesis_en.pdf

4. Мэдээллийн хэрэгслийн суурь боловсролоор иргэний эрх мэдлийг дээшлүүлэхүй

Энэхүү номыг НОРДИКОМ, Олон улсын мэдээлэл судалгааны төв болон Гётеборгийн Их сургуулиас ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр эрхлэн гаргасан. Номыг ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр 2007 оны гуравдугаар сард Риад хотноо зохион байгуулсан “Мэдээллийн хэрэгслийн суурь боловсролын олон улсын анхдугаар зөвлөгөөн” болон 2007 онд Парис хотноо болсон “Мэдээллийн хэрэгслийн суурь боловсролын олон улсын уулзалт – Грюнвальдаас хойшхи ололт амжилт, бэрхшээл, шинэ чиг хандлага. Үнэлгээний шинэчилсэн шалгуур үзүүлэлт шаардлагатай юу?” олон улсын уулзалтад тулгуурлан бэлтгэсэн юм. Бид ардчилал, хөгжлийн тухай ярихдаа мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол бүхий иргэдгүйгээр ардчиллыг хөгжүүлэх боломжгүйг мартдаг. Иргэдийн мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь

боловсролыг дээшлүүлэх нь тэднийг хүчирхэгжүүлэх чухал нөхцөл болж өгдөг. Ингэснээр иргэдийн шүүмжлэлт сэтгэглээ, үзэл бодлоо илэрхийлэх чадвар дээшилж, тэд хөгжил дэвшил, нийгмийн өөрчлөлт, өдөр тутмын амьдралын талаарх шийдвэрийг өөрсдөө гаргах эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн харилцааг ашиглах чадвартай болдог.

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол иргэн бүрт хэрэгтэй. Ялангуяа залуу үеийнхэн мэдээллийн хэрэгслийг иргэн хүний хувьд сурах үйл явц, хувь хүний хөгжилд болон соёлын илэрхийллийн арга хэрэгсэл болгон ашиглаж сурах нь онцгой чухал ач холбогдолтой юм. Гэхдээ иймэрхүү асуудлыг ярих болгонд Барууны хэвлэл мэдээллийн соёлыг жишиг болгон авч хэлэлцэх нь дэндүү түгээмэл байдаг. Тиймээс Барууны бус соёл, үзэл санаа, сэтгэлгээнд илүү нээлттэйгээр хандаж эхлэх нь чухал байна. Бүгдийн оролцоо бүхий нийгэм, орчныг бий болгох бидний нийтлэг сонирхолд олон эшт соёл уламжлалын чиг хандлагыг харгалзах нь чухал шаардлагатайгаар зогсохгүй бидний амьдралыг илүү баялаг болгох юм.

Дараах холбоосыг үзнэ үү: http://www.nordicom.gu.se/clearinghouse.php?portal=publ&main=info_publ2.php&ex=258&me=3

5. Мэдээллийн суурь боловсролын удиртгал: Товч тойм

Энэхүү товхимолд ЮНЕСКО-ийн Бүх нийтийн мэдээллийн хөтөлбөрөөс (БНМХ) мэдээллийн хэрэгслийн суурь боловсролыг энгийн хялбар байдлаар тодорхойлж өгсөн байдаг. Товхимолыг төрийн албан хаагч, олон улсын засгийн газар хоорондын агентлагийн ажилтан, мэдээллийн салбарын мэргэжилтэн, багш, ашгийн болон ашгийн бус байгууллагын хүний нөөцийн менежер гэх зэрэг олон янзын хүнд зориулан бэлтгэсэн байна. Товхимолоос ишлэвэл:

“Та амьдралынхаа туршид мэдээллийг хэрхэн, хаанаас, хэнээс, хэзээ хайж, олж, авах чадвар, хандлага, хэвшлийг хэдийчинээ хурдан эзэмшинэ, төдийчинээ мэдээллийн өндөр боловсролтой болно. Энэхүү боловсролд багтах чадвар, хандлага, хэвшлийг ашиглаж дадсанаар та хувийн болон гэр бүлийн эрүүл энх, сайн сайхан байдлаа дээшлүүлэх, боловсролын, ажил мэргэжлийн, нийгмийн болон бусад асуудалтай холбоотойгоор илүү даацтай, цаг үеэ олсон шийдвэр гаргах чадвартай болно.”

Дараах холбоосоор орж үнэ үү: <http://unesdoc.unesco.org/images/0015/001570/157020e.pdf>

6. Мэдээллийн суурь боловсролын шалгуур үзүүлэлт

Энэхүү бүтээлд мэдээллийн суурь боловсролыг хэмжихэд шаардлагатай онолын үндсэн хүрээг тодорхойлж өгсөн байдаг. Үүнд мэдээллийн суурь боловсролын тодорхойлолт багтах бөгөөд энэхүү тодорхойлолт нь мэдээллийн тухай мэдлэгийг насанд хүрэгчийн мэдэж, чадах ёстой зүйлстэй уялдуулж өгсөн бөгөөд, тухайлбал амьдралын бүхий л хүрээнд шаардагдах мэдээллийн технологийг ашиглах чадвар зэргийг багтаасан байдаг. 2005 оны Александриагийн тунхаг бичигт тулгуурлан мэдээллийн суурь боловсролыг дараах байдлаар тодорхойлсон байна:

Мэдээллийн суурь боловсролд

- мэдээллийн шаардлага хэрэгцээг таньж мэдэх;
- мэдээллийн байршлыг тогтоож, чанарыг нь үнэлэх;
- мэдээллийг хадгалах, авах;
- мэдээллийг үр ашигтай, ёс зүйтэйгээр ашиглах болон
- мэдээллээс мэдлэг бий болгох, бусадтай хуваалцах чадвар багтана.

Мэдээллийн суурь боловсролын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь ололт амжилтаа тогтоож, ирээдүйд хэрэгжүүлэх бодлого данхаарлаа төвлөрүүлэхэд тустай учир тэдгээр шалгуурыг тодорхойлох нь олон улсын болон үндэсний хэмжээнд нэн тэргүүний зорилт байх ёстой юм. Мэдээллийн суурь боловсрол нь өвчлөл болон ажилгүйдэлтэй тэмцэх зэрэг Мянганы хөгжлийн зорилтуудын нэлээдийг нь хэрэгжүүлэх үндэс суурь нь болж өгдөг. Мэдээллийн суурь боловсролын шалгуур үзүүлэлтүүд нь улс оронд хэрэгжүүлж буй холбогдох бодлогын үр дүнг тодорхойлоход тустайгаас гадна, иргэдийн нийгмийн амьдралд оролцох чадавхыг хэмжих боломжийг бүрдүүлдэг.

Дараах холбоосоос үзнэ үү: <http://unesdoc.unesco.org/images/0015/001587/158723e.pdf>

7. Мэдээллийн технологи ашиглах багшийн чадавхын стандарт

Улс орны боловсролын салбарт мэдээллийн технологийг хөгжүүлэх хэм хэмжээг тогтооход туслах зорилгоор ЮНЕСКО-гоос ЦИСКО (Cisco), Интел (Intel) болон Майкрософттой (Microsoft), мөн Технологийг Боловсролд Олон Улсын Нийгэмлэг (International Society for Technology in Education) болон Виржиниягийн Политехник Хүрээлэн болон Улсын Их Сургуультай (Virginia Tech) хамтран “Мэдээллийн технологи ашиглах багшийн чадавхын стандарт” төслийг хэрэгжүүлсэн юм.

Төслийн зорилго нь багш нарын мэдээллийн технологитой харьцах чадварыг дээшлүүлэхэд удирдамж зөвөлгөө өгөх, улмаар оюутнуудын боловсрол, чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх явдал байв.

Энэхүү багц бүтээлд дараах гурван товхимол багтана:

Төслийн шаардлага хэрэгцээ, бүтэц, арга барилыг багтаасан бодлогын тайлбар бичиг;

Чадавхын стандартын бүтэц. Үүнд багшийн эзэмшвэл зохих багц чадварыг тодорхойлох бодлогын сонголтууд багтсан.

Хэрэгжүүлэх удирдамж. Үүнд багшийн эзэмшвэл зохих чадвар тус бүрийг хөгжүүлэх дэлгэрэнгүй хуваарь багтсан болно.

Дараах холбоосыг үзнэ үү: <http://unesdoc.unesco.org/images/0015/001562/156207e.pdf>

<http://unesdoc.unesco.org/images/0015/001562/156209E.pdf>

<http://unesdoc.unesco.org/images/0015/001562/156210E.pdf>



ХОЁРДУГААР БҮЛЭГ



ҮНДСЭН БА ҮНДСЭН БУС СЭДВҮҮД



УДИРТГАЛ: ЭНЭХҮҮ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ

МХМСБ-ын хөтөлбөрийн зорилтот хэрэглэгчид
МХМСБ-ын үндсэн агуулга, онцлог шинж
МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг өөрийн орчин нөхцөлд
тохируулах үйл явц: Зөвлөмж
Нэвтрүүлэн хэрэгжүүлэх бодлого

ҮНДСЭН ХИЧЭЭЛ

СЭДЭВ 1: ИРГЭНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦОО, ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ ЧӨЛӨӨ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АРДЧИЛСАН ҮЙЛ ЯВЦ, НАСАН ТУРШИЙН СУРАХ ҮЙЛ ЯВЦ

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ: УДИРТГАЛ

2-Р ХЭСЭГ:

МХМСБ ба ИРГЭНИЙ ОРОЛЦОО

3-р хэсэг:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН НОМЫН САН, АРХИВ, ИНТЕРНЭТ ГЭХ МЭТ МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БУСАД СУВАГТАЙ ХАРЬЦАХ НЬ

4-Р ХЭСЭГ:

МХМСБ, ЗААХ БОЛОН СУРАХ ҮЙЛ ЯВЦ

СЭДЭВ 2: СЭТГҮҮЛЗҮЙ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

1-Р ХЭСЭГ:

СЭТГҮҮЛЗҮЙ БА НИЙГЭМ

2-Р ХЭСЭГ:

ЭРХ ЧӨЛӨӨ, ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГА

3-Р ХЭСЭГ:

МЭДЭЭ ГЭЖ ЮУ ВЭ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4-Р ХЭСЭГ:

МЭДЭЭГ БЭЛТГЭХ ҮЙЛ ЯВЦ.

4W 1H –ээс гадна юуг мэдэх хэрэгтэй вэ

СЭДЭВ 3: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ ДЭХ ДҮРСЛЭЛ

1-Р ХЭСЭГ :
СЭТГҮҮЛЗҮЙ БА ДҮРСНИЙ ХҮЧ

2-Р ХЭСЭГ:
ОЛОН УРГАЛЫЧ БАЙДАЛ, НИЙГМИЙН ЯНЗ БҮРИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ЭРХ ТЭГШ ТУСГАХТАЙ ХОЛБООТОЙ МЭРГЭЖЛИЙН ЗАРЧИМ

3-Р ХЭСЭГ:
ТЕЛЕВИЗ, КИНО, НОМ ХЭВЛЭЛ

4-Р ХЭСЭГ:
НИЙГМИЙН ТӨЛӨӨЛӨЛ БА ВИДЕО ХӨГЖИМ

СЭДЭВ 4: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХЭЛ

1-Р ХЭСЭГ:
МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БИЧВЭРИЙГ УНШИХУЙ

2-Р ХЭСЭГ:
МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БА МЭДЭЭЛЛИЙН УТГА САНАА:
СОНИН ХЭВЛЭЛ, РАДИО ТЕЛЕВИЗИЙН МЭДЭЭ

3-Р ХЭСЭГ: КИНОНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛ, ӨГҮҮЛЭМЖ

46

СЭДЭВ 5: СУРТАЛЧИЛГАА

1-Р ХЭСЭГ:
СУРТАЛЧИЛГАА, ОРЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

2-Р ХЭСЭГ:
ОЛОН НИЙТЭД ҮЙЛЧЛЭХ ЗАР МЭДЭЭ

3-р хэсэг:
СУРТАЛЧИЛГАА: БҮТЭЭЛЧ ҮЙЛ ЯВЦ

4-р хэсэг:
СУРТАЛЧИЛГАА БА УЛС ТӨРИЙН ТАЛБАР

СЭДЭВ 6: ШИНЭ БА УЛАМЖЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

1-р хэсэг:
УЛАМЖЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭС ШИНЭ ТЕХНОЛОГИД

2-р хэсэг:
МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙН НИЙГМИЙН ХЭРЭГЛЭЭ –
ОЛОН ТҮМНИЙ БОЛОН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА

3-р хэсэг:
СУРГАЛТЫН ТАНХИМД ЦАХИМ ТОГЛООМ ЗЭРЭГ ИНТЕРАКТИВ
ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОМЖИЙГ АШИГЛАХ НЬ

СЭДЭВ 7: ИНТЕРНЭТИЙН БОЛОМЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

1-Р ХЭСЭГ:

ЦАХИМ ЕРТӨНЦ ДЭХ ЗАЛУУ ҮЕ

2-Р ХЭСЭГ:

ЦАХИМ ЕРТӨНЦӨД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ БА ЭРСДЭЛ

СЭДЭВ 8: МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ, НОМЫН САН АШИГЛАХ ЧАДВАР

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ОНОЛ, ХЭРЭГЛЭЭ

2-Р ХЭСЭГ:

СУРАХ ОРЧИН БА МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ

3-Р ХЭСЭГ :

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ

СЭДЭВ 9: МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА, МХМСБ БА СУРАХ ҮЙЛ ЯВЦ

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА, ЗААХ БОЛОН СУРАХ ҮЙЛ ЯВЦ

2-Р ХЭСЭГ:

СУРАХ ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ ОНОЛ БА МХМСБ

3-Р ХЭСЭГ:

СУРГУУЛИЙН ОРЧИНД МХМСБ-Д ЭЭЛТЭЙ ОРЧИН БИЙ БОЛГОХ ӨӨРЧЛӨЛТИЙГ УДИРДАХ НЬ ҮНДСЭН БУС СЭДЭВ

СЭДЭВ 10: ХЭРЭГЛЭГЧИД

СЭДЭВ 11: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, ТЕХНОЛОГИ БА ДАЯАРШСАН ТОСГОН

1-Р ХЭСЭГ:

ӨНӨӨГИЙН ДАЯАРШСАН ТОСГОН ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ЭЗЭМШЛИЙН АСУУДАЛ

2-Р ХЭСЭГ:

ДАЯАРШСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН НИЙГЭМ, СОЁЛ, УЛС ТӨРИЙН ОРЧИН

3-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН АРИЛЖААНЫ ЧИГ ХАНДЛАГА

4-Р ХЭСЭГ:

АЛЬТЕРНАТИВ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ӨСӨЛТ

СЭДЭВ 3, 5-Р ХЭСЭГ: КОМПЬЮТЕРИЙН ТУСЛАМЖТАЙГААР ДҮРС
ЗАСВАРЛАХ НЬ

СЭДЭВ 4, 4-Р ХЭСЭГ: УТГА АГУУЛГА БҮТЭЭХ ЗОРИЛГООР ДҮРС,
ЗУРАГ АВАЛТЫН ӨНЦГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

СЭДЭВ 5, 5-Р ХЭСЭГ: УЛС ҮНДЭСТЭН ХООРОНДЫН ЗАР
СУРТАЛЧИЛГАА БА СУПЕР БРЭНД НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

УДИРТГАЛ:ЭНЭХҮҮХӨТӨЛБӨРИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол нь (МХМСБ) мэдээллийн хэрэгсэл, мөн номын сан, архив, Интернэт гэх мэт мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагын нийгэмд болон бидний хувийн амьдралд гүйцэтгэх үүрэгт анхаарал хандуулдаг. Цаашилбал хувь хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, бусдад дамжуулах эрхийг дэмжин дэлгэрүүлдэг. Мөн мэдээллийн хэрэгслийг мэдээлэл үйлдвэрлэх, дамжуулах үйл явц болон зорилтот хэрэглэгчдийнх нь үүднээс үнэлэн дүгнэхийг чухалчилдаг.

Мэдээлэл, мэдлэгт суурилсан нийгэмд

МХМСБ нь иргэдийн нийгмийн оролцоо, амь амьдралд чухал үүрэгтэй байдаг.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл нь ардчилсан үйл явцад голлох үүрэг гүйцэтгэдэг.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл түгээгч бусад сувгууд хандлага, үзэл бодлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хэрэглэгчийн бүтээсэн агуулга, цахим ертөнцийн хэрэглээ болон иргэний сэтгүүлзүйн үүрэг нэмэгдсээр байна.

49

Энд толилуулж буй сургалтын хөтөлбөр нь “Мэдээллийн хэрэгслийн” болон “мэдээллийн” суурь боловсролыг хамтатгаснаар суурь боловсролын тухай ойлголтыг бодит амьдралын нөхцөл, шаардлага хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх болно. Энэхүү хөтөлбөр нь өнөө үед суурь боловсролын тодорхойлолтод хэвлэмэл, дэлгэцийн болон электрон мэдээллийн тогтолцоог багтаан өргөтгөх шаардлагатайг хүлээн зөвшөөрч буй юм. Хөтөлбөрт түүнчлэн МХМСБ нь номын сан, архив, музей гэх мэтийг мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг чухал суваг хэмээн үзэж, багтаасан болно.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн зорилтот бүлэг

Хөтөлбөрийн үндсэн зорилтот бүлэг нь багш нар юм. Үүнд анхан болон дунд шатны боловсролын ажиллаж буй болон бэлтгэгдэж буй багш нар хамаарна. Энэхүү хөтөлбөрийг багш бэлтгэж, давтан сургадаг байгууллагуудад тусгайлан зориулсан болно. Гэлээ ч гэсэн уг хөтөлбөрийг тухайн улс орон, байгууллагын нөхцөлд тохируулан хэрэглэнэ хэмээн үзэж бэлтгэсэн учир МХМСБ-д ямар нэгэн хэмжээгээр хамаарах бусад сургууль, сургалтын байгууллага энэхүү хөтөлбөрийг ашиглах бүрэн боломжтой. Уг хөтөлбөр мөн төрийн бус байгууллага, төрийн ажилтан, яамд болон бусад байгууллагад ч хамааралтай байж болох юм.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн үндсэн агуулга, онцлог шинж

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол нь урьд өмнө салангид байсан салбар ухааныг хамтатгахыг зорьж буй юм.

МХМСБ нь мэдээллийн хэрэгсэл, номын сан, архив болон мэдээллийн бусад сувгийн үүрэг, үйл ажиллагаа, мэдээлэл болон утга санааг түгээх үйл явц, ашиглах боломж, агуулгыг шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэх арга хэрэгслийн тухай ойлголт, мэдлэгт анхаарал хандуулдаг. Тиймээс МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг цогц бөгөөд бүхнийг багтаасан байдлаар, гэхдээ өөрчлөн тохируулах боломжтойгоор боловсруулсан болно. Хөтөлбөрийн дэлгэрэнгүй хувилбарт (орч.) сэдэв тус бүртэй холбоотой дараах хэсгүүд багтсан болно:

Ерөнхий нөхцөл байдал, шаардлага хэрэгцээ

Үндсэн асуудлууд

Хичээлийн зорилго

Заах арга, үйл ажиллагааны жишээ

Үнэлгээ хийх зөвлөмж

Ашиглах материал.

50

Хичээлийн зорилго гэсэн хэсэгт сэдэв тус бүрийн үндсэн зорилгыг тодорхойлж өгсөн. Эдгээрт мөн тухайн сэдвийг үзэж дууссаны дараа багш нар ямар мэдлэг, чадварыг эзэмшсэн байх ёстойг заасан байгаа. Хөтөлбөрийг өөрчилж, өөрийн нөхцөл шаардлагад тохируулах үед эдгээрийг МХМСБ-ын сургалтын хөтөлбөр, мэдлэг чадварын ерөнхий хүрээнд нийцүүлэн зохицуулах нь зүйтэй.

Ерөнхий нөхцөл байдал, шаардлага хэрэгцээ хэмээх бүлэгт тухайн сэдвийн үндсэн агуулга, холбогдох нөхцөл байдлыг тайлбарласан. Эдгээр тайлбар нь бүрэн дүүрэн биш бөгөөд зөвхөн байж болох чиг хандлага, байр суурийг тоймлон танилцуулж буй бөгөөд багш үүнийг үргэлжлүүлэн судалж болох юм.

Заах арга, үйл ажиллагаа гэсэн бүлгийн хувьд ч мөн адил. Энэхүү хэсэгт мөн л байж болох олон арга боломжийн заримыг танилцуулсан болно. Тиймээс энд багтсан арга хэрэгслийг зөвхөн жишээ гэж үзэх нь зүйтэй. Багш нар үүнийг өөрийн орон, байгууллагын соёлын орчин, шаардлага хэрэгцээ, нөхцөл байдалд тохируулж, баяжуулан ашиглах боломжтой. Багш нарын оролдлогыг дэмжих үүднээс ЮНЕСКО-гоос МХМСБ-той хамаарал бүхий сургалтын үйл ажиллагааны мэдээллийн санг үүсгэн байгуулахыг дэмжиж ажиллах болно.

Үнэлгээ хийх зааварчилгаа буюу зөвлөмж хэсэгт тодорхой болон ерөнхий үнэлгээг хэрхэн хийх саналуудыг дэвшүүлсэн болно. Эдгээр нь үнэлгээний боломжуудыг онцлон тодотгох зорилготой бөгөөд сурах үйл ажиллагааны үнэлгээ, сурсан зүйлийн үнэлгээ, мөн үнэлгээ хийж сурах үйл явцыг багтааж буй юм.

Зарим сэдвийн төгсгөлд **ашиглах материалын** зөвлөмжийг багтаасан байгаа. Багш нарт магад өөрийн нөөц материал байж болох юм, тийм тохиолдолд тэдгээрийг нэмж ашиглах боломж нээлттэй байх болно.

МХМСБ-ЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ӨӨРИЙН ОРЧИН НӨХЦӨЛД ТОХИРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ: ЗӨВЛӨМЖ

Ямар ч сургалтын хөтөлбөрийн баримт бичгийг өөрийн нөхцөлд тохируулж хэрэгжүүлэхээс өмнө боловсролын байгууллагын зорилго, хэрэгжиж буй хөтөлбөр, шинэ хөтөлбөр нэвтрүүлэх цаг хугацааны боломж гэх зэрэг багш бэлтгэдэг аль ч байгууллагад байдаг бодит нөхцлийг харгалзан үзэх нь зүйтэй. Энэхүү сургалтын хөтөлбөрийг багш болон боловсролын байгууллагын шаардлага хэрэгцээнд нийцүүлэхэд дэм болох үүднээс дараах зөвлөмжийг санал болгож байна.

Гол гол оролцогчдыг тодорхойлж, ажлын хэсэг буюу комисс байгуулах.

Ажлын эхэн үед МХМСБ-ын сургалтын хөтөлбөр болон эзэмшвэл зохих мэдлэг чадварыг ерөнхий хүрээг нарийвчлан судалж хэлэлцэх нь чухал. Ингэснээр хөтөлбөрийн аль хэсэг нь тухайн байгууллагын нэн тэргүүний шаардлага хэрэгцээнд нийцэж буйг тогтоох боломжтой юм.

Тухайн оронд багш бэлтгэж буй байгууллагын сургалтын одооны хөтөлбөрийг дүгнэн хэлэлцэж, МХМСБ-ын хөтөлбөрийн сэдэв, хэсгүүд давхардаж буй эсэхийг тогтоох нь зүйтэй. Ингэснээр агуулгын давхцлаас зайлсхийх, нөгөө талаар одоогийн хөтөлбөрт дутагдаж буй зүйлсийг тогтоож, МХМСБ-ын сургалтын хөтөлбөрөөр нөхөж баяжуулах боломжийг илүү тод олж харах юм.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замаа байгууллага тус бүр өөрсдөө, байгаа нөөц боломж, цаг хугацаагаа тооцож тодорхойлох нь зүйтэй. Ингэхдээ дараах асуудлыг бодолцвол тустай: МХМСБ-ыг хэрхэн заавал зохих вэ? Үүнийг байгаа хөтөлбөрт хэрхэн нэгтгэж нэвтрүүлэх вэ? Манай байгууллагад МХМСБ-ын туршлагатай боловсон хүчин бий юу? Үгүй бол хаанаас олж авах вэ? Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын материал олдох уу? Үгүй бол, хаанаас олох вэ? Бидэнд дутагдаж буй зүйлс буюу одоогийн шаардлага хэрэгцээ нь хөтөлбөрийг өөрийн нөхцөлд тохируулах үйл явцад хэрхэн нөлөөлөх вэ?

МХМСБ-ын сургалтын энэхүү хөтөлбөрийг өөрийн нөхцөлд тохируулан бэлтгэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл дээрх зүйлсийг хэлэлцсэний үндсэн дээр өөрийн байгууллагад тохирох хөтөлбөрийн хувилбарыг боловсруулах шаардлага тулгарч болзошгүй юм. ЮНЕСКО-гийн Нээлттэй Боловсролын Мэдээллийн Сан (www.unesco.org/webworld/en/oer) нь хөтөлбөрийг өөрийн нөхцөлд тохируулах үйл явцад тус болно. Нээлттэй Боловсролын Мэдээллийн сан гэдэг нь оюуны өмчийн зөвшөөрөл бүхий, нээлттэй ашиглах боломжтой сургалтын материалуудын цуглуулга юм. (Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү хэсгийн төгсгөлд үзнэ үү).

Өөрийн нөхцөлд тохирсон хөтөлбөрийн хувилбарыг боловсруулсны дараа туршилт хийж үзэх нь чухал. Туршилтын явцыг ажиглаж, үр дүнгийг нь хэлэлцэх

хэрэгтэй.

Туршилтын үр дүнгийн хэлэлцүүлэгт үндэслэн сургалтын хөтөлбөрт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд зориулсан зөвлөмжийн хамт хийнэ.

Энэ үед хөтөлбөрийг байгууллагын хэмжээнд сонгосон стратегийн дагуу хэрэгжүүлэхэд бэлэн болно (доор үзнэ үү).

Явцын дунд баримтжуулалт, ажиглалт, үнэлгээг нягт нямбай гүйцэтгэх нь зүйтэй. Шаардлагатай бол тодорхой тохиолдол, хичээлийн нарийвчилсан судалгаа, баримт материалыг бүртгэн баримтжуулж, сайн жишээ болгон бусадтай хуваалцаж болох юм.

НЭВТРҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг байгаа хөтөлбөртэйгээ нэгтгэн нэвтрүүлэхэд дараах арга замыг бодолцож үзэхийг санал болгож байна:

52

Бие даасан курс хичээл: МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг кредитын үнэлгээ бүхий бие даасан курс хичээл байдлаар хэрэгжүүлж болох юм. Энэ нь бүх багшийн заавал үзэх, эсвэл сонгож үзэх хичээл байж болно. Ажиллаж буй багш нарын хувьд хөтөлбөрийг мэргэжил дээшлүүлэх курс байдлаар хэрэгжүүлж, сертификат олгож болох юм.

Байгууллага дээр хэрэгжүүлэх: Нэгээс хоёр долоо хоногийн хугацаанд эрчимтэй сургалт зохион байгуулж, багш нарт 2 – 3 сарын хугацаанд биелүүлж дуусгах даалгавар өгч болно. Энэхүү сургалт нь мөн л кредит үнэлгээтэй байж болох юм.

Хэсэгчлэн нэвтрүүлэх: МХМСБ-ын янз бүрийн хэсгийг одоо хэрэгжиж буй хичээлүүдтэй нэгтгэн хэрэгжүүлж болох юм. Жишээлбэл боловсролын технологи, суурь боловсрол, нийгмийн ухааны зарим хичээлийг МХМСБ-ын хичээлээр баяжуулж болох юм. Энэ нь магад МХМСБ-ын хөтөлбөрийг нэвтрүүлэх хамгийн цогц арга болов уу. Энэхүү нэгтгэн нэвтрүүлэх үйл явцыг үр дүнтэй зохион байгуулахын тулд төлөвлөгөөг маш нарийн чанд боловсруулж, одоо хэрэгжиж буй хөтөлбөрийн ерөнхий зорилго, үр дүнг нарийн бодолцох шаардлагатай.

Онлайн сургалт: Сургалтыг сурч байгаа болон ажиллаж байгаа багш нарын аль алинд нь зориулан онлайн хэлбэрээр зохион байгуулж болно. Ингэснээр сургалтыг тухайн улсын болон хилийн чанадын бусад байгууллага, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах боломж нээгдэнэ. Онлайн сургалтыг зохион байгуулахын тулд багш бэлтгэдэг сургууль заавал өөрийн онлайн сургалтыг шинээр нээх албагүй, харин ийм хэлбэрийн сургалт зохион байгуулах нөөц болон туршлагатай өөр байгууллагатай хамтарч болох юм. Сургалтыг дүүргэгсдэд зэрэг, сертификат, эсвэл диплом олгож болно.

Удаан хугацаанд бол дээр дурдсан арга замаас хоёр болон түүнээс дээш хэлбэрийг хослуулан ашиглах боломжийг судалж үзэж болох юм. Мэдээж хэрэг хөтөлбөрийг өөрийн нөхцөлд тохируулан өөрчилж, нэгтгэн нэвтрүүлэх арга зам нь байгууллага болгонд өөр байх бөгөөд энэ нь бэлэн байдлын түвшин, шаардлагатай нөөц боломж, боловсон хүчин байгаа эсэх, хөтөлбөрийг хэр зэрэг өргөн далайцтай нэвтрүүлэх бодлого барьж буй зэрэг олон зүйлээс хамаарна.

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг ЮНЕСКО-гийн Нээлттэй Боловсролын Мэдээллийн Санд түшиглэн өөрийн нөхцөлд тохируулан боловсруулах нь

ЮНЕСКО-гийн Нээлттэй Боловсролын Мэдээллийн Сан нь (НБМС) (www.unesco.org/webworld/en/oer) ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан ном товхимолыг албан ёсны зөвшөөрөлтэйгээр ашиглах боломж олгох шинэлэг санаачилга юм. Энэхүү санд жишээлбэл Криэтив Коммонсын* оюуны өмчийн эрхийн зөвшөөрөлтэйгээр нийтэлсэн сургалтын материалууд багтдаг бөгөөд эдгээрийг үнэ төлбөргүйгээр чөлөөтэй авч ашиглах боломжтой.

ЮНЕСКО-гийн НБМС-д түшиглэн дэлхийн аль ч орны багш, боловсролын мэргэжилтэн, суралцагчид МХМСБ-ын сургалтын хөтөлбөр болон бусад материалыг чөлөөтэй хуулж авч, өөрчилж, бусадтай хуваалцах боломжтой.

Багш бэлтгэдэг байгууллагууд өөр өөрсдийн онцлогт тохируулан боловсруулсан МХМСБ-ын сургалтын хөтөлбөрөө НБМС-д байршуулснаар ийм хөтөлбөр боловсруулахаар ажиллаж буй, эсвэл өөрийн хөтөлбөрийг ижил төстэй бусад байгууллагынхтай харьцуулахыг хүсэж буй багш, мэргэжилтнүүдэд хосгүй боломж олгож буй юм. Тэд энэхүү сангаас маш хялбар бөгөөд хууль ёсны аргаар өөрт хэрэгтэй агуулгыг хуулж авч, өөрийн нутаг, байгууллагын онцлогт тохируулан ашиглах боломжтой. НБМС нь ижил төстэй байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжин дэлгэрүүлж буйгаас гадна тэдгээр байгууллагын хувьд МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг илүү боловсронгуй болгох чиглэлээр ЮНЕСКО-той нягт хамтран ажиллах үндэс суурийг тавьж өгч буй юм.

*Криэтив Коммонсын (Creative Commons) Оюуны өмчийн эрх нь оюуны өмчийн эрх олгох уламжлалт үйл ажиллагаатай төстэй боловч зохиогчдод оюуны өмчийн хэлбэрийг сонгох зөвшөөрөл олгодог бөгөөд зохиогч нь хэрэглэгчид ямар эрх олгохоо өөрөө шийддэг байна. (<http://creativecommons.org>)

2011 оны сүүлээр нээгдсэн уг сан нь цаашдаа өөрийн хөтөлбөр, холбогдох материалыг санд байршуулах, материал авч ашиглах хүсэлтэй байгууллагуудтай хамтран ажиллаж, тэднийг чадавхжуулахад дэмжлэг

ҮНДСЭН
СЭДВҮҮД

СЭДЭВ 1:

ИРГЭНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦОО, ҮГ
ХЭЛЭХ, ҮЗЭЛБОДЛООИЛЭРХИЙЛЭХ,
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ ЧӨЛӨӨ,
МЭДЭЭЛЭЛСОЛИЛЦОХАРДЧИЛСАН
ҮЙЛ ЯВЦ, НАСАН ТУРШИЙН СУРАХ
ҮЙЛ ЯВЦ

55

“Боловсролын эрхэм зорилгыг тодорхойлох боломжтой байсан бол, түүний үндсэн зорилго бол суралцагсдыг олон нийтийн, нутаг орны болон эдийн засгийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход бэлтгэх явдал хэмээн хэлж болох юм.”

Нью Лондон Групп

Мэдээллийн хэрэгслийн¹ болон мэдээллийн технологийн хурдацтай өсөлт, мөн мэдээлэл болон мэдээллийн харилцааны өөр хоорондоо уусан нэгдэх үйл явц нь МХМСБ-ыг амин чухал болгож байна. МХМСБ нь мэдээллийн технологийг боловсрол олгох үйл явцад идэвхтэй ашиглаж, мэдлэг болон мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх урьдчилсан нөхцөл болоод байна.

Өнөөгийн бидний амьдарч буй нийгэм нь мэдээлэл, мэдлэгт суурилж байна. Хаа сайгүй оршин буй мэдээллийн хэрэгсэл, бидний хувийн, эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн амьдралын салшгүй хэсэг болоод буй мэдээллийн технологийн бүхий л төрлөөс зайлсхийн зугтах боломж бидэнд үгүй. Тиймээс мэдээлэл, мэдлэгэд суурилсан нийгмийн амьралд үр дүнтэйгээр оролцож, амьдралын бүхий л үе шатанд амжилт үзүүлэхийн тулд шинэ төрлийн мэдлэг, чадвар, хандлага шаардлагатай болоод байна. Чухам энэ л шалтгаанаар мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг заах болон эзэмшихийн ач холбогдол улам бүр нэмэгдэж байна.

Мэдээллийн Технологийн Холбооноос гаргасан Дэлхийн мэдээллийн харилцаа, мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн 2009 оны статистик мэдээллээс үзэхэд дэлхийн хэмжээнд 1.3 тэрбум буюу дэлхийн 4.9 хүнийг төлөөлж буй 1.7 тэрбум өрхийн гуравны дөрөв нь гэртээ телевизтэй, бүх өрхийн гуравны нэг нь буюу 0.6 тэрбум өрх (1.9 тэрбум хүн) компьютертэй бөгөөд 2009 ны сүүл гэхэд 4.6 тэрбум хүн үүрэн телефоны хэрэглэгч байхаар тооцож байжээ. Үүн дээр 2.5 тэрбум радио хүлээн авагч нэмэгдэнэ. Дэлхийн Сонины Холбооны мэдээллээр, 2007 онд сонин худалдан авч уншдаг хүмүүсийн тоо 1.4 тэрбумыг давж байсан байна. ЮНЕСКО-гийн Статистикийн Хүрээлэнгээс дэлхийн хэмжээнд жил бүр 1 сая орчим шинэ ном хэвлэгддэг гэсэн тооцоог гаргасан байдаг.

Энэ бүгдээс харахад, бид өөрсдийнхөө болон улс орон, соёл иргэншил, биднийг хүрээлж буй ертөнцийн талаар юуг мэдэж авах вэ гэдэг нь телевиз, радио, сонин, гар утас, Интернет, ном, номын сан, сурталчилгааны самбар, видео тоглоом зэргээс ихээхэн хэмжээгээр хамаарч байна. Мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл түгээгч бусад суваг нь ардчилал, сайн засаглалд голлох үүргийг гүйцэтгэдэг. Мэдээллийн хэрэгсэл ардчиллыг дэмжих үүрэгтэй л юм бол иргэд мэдээллийн хэрэгслийг яаж шүүмжлэлтэйгээр ашиглах, хүлээн авч буй мэдээлэл нь харьцуулан жиших, егөөдөх зэрэг олон аргаар ямар утга санааг дамжуулж буйг хэрхэн ойлгож тайлбарлахыг мэддэг байх ёстой. Тэд иргэн хүний хувьд тодорхой мэдлэг, чадвар, хандлагад тулгуурлан мэдээллийн хэрэгсэлтэй харьцаж, мэдээллийн хэрэгсэл, номын сан,

архив болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн нөөц боломжийг үр бүтээлтэйгээр ашиглаж чаддаг байх ёстой. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол нь 21 дүгээр зуунд шаардлагатай багц чадварыг олгоно.

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол хэмээх нэр томъёог бичиг үсэгт тайлагдах тухай ойлголтыг шинэчлэн тодорхойлсонтой адилтган ойлгож болох юм. Өнөөдөр уншиж, бичиж, тоо бодож сурах нь хангалтгүй болоод байна. Тоо, үсэг мэдэхийн чухлыг үгүйсгэж болохгүй нь тодорхой. Гэхдээ мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг заавал эзэмшүүлнэ гэдэг бол залуу хүмүүс мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн үүрэг, үйл ажиллагааг ойлгож, хувийн, нийгмийн, ажил мэргэжлийн болон сурч боловсрох зорилгоо биелүүлэхийн тулд мэдээлэл хайх, үнэлэн дүгнэх, ашиглах, бүтээх чадварыг бүрэн дүүрэн ашигладаг болгоно гэсэн үг. Тэд мөн үзэл бодлоо илэрхийлэх, бие даан сурах, бүтээх, өндөр мэдлэгтэй иргэн бөгөөд мэргэжилтэн байж, нийгмийн амьдрал, ардчилсан үйл явцад идэвхтэй оролцохын тулд шүүмжлэлт сэтгэлгээний үндсэн чадварыг эзэмшсэн байх ёстой. (Мэдээллийн Суурь Боловсролын Үндэсний Форумын тайлангаас, 2005 он).

Сургалтын хөтөлбөрийн энэхүү сэдвийг шүүмжлэлт сэтгэлгээ, үзэл бодлоо илэрхийлэх болон оролцоо хэмээн гурван үндсэн баганад тулгуурлав. Сэдвийн хүрээнд МХМСБ-ыг шинжлэх ухааны олон салбар ухаантай уялдаатай гэж үзэж, дараах асуудлыг судлах болно:

Мэдээлэл гэж юу вэ? Мэдээллийн хэрэгсэл гэж юу вэ? Яагаад эдгээрийн тухай заах ёстой вэ? Эдгээр нь яагаад чухал вэ?

Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол гэж юу вэ?

Мэдээллийн суурь боловсрол гэж юу вэ?

Ягаад мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол гэж нэрлэх болсон бэ?

Сэдвийн хүрээнд МХМСБ-ыг шинжлэх ухааны салбар ухаан гэхээсээ илүү сурах болон заах үйл явц талаас нь танилцуулах юм. Тийм учраас багш нарт энэ салбарын үндсэн асуудал, онолын урсгалуудыг танилцуулах бөгөөд тэдгээр асуудал, онолыг хөтөлбөрт багтаасан бусад сэдвийн хүрээнд илүү дэлгэрэнгүй авч үзэх болно. Ингэхдээ багш нарт тодорхой сэдэв, асуудлын **тухай** заахын оронд мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролоор **дамжуулан** мэдлэг чадвар эзэмшүүлэхийн ялгааг ойлгуулна. Багш нарын зорилго бол өөрсдөө мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролтой болж, МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийг анхан болон дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт шингээх мэдлэг, чадвартай болох явдал юм.

1 дүгээр сэдэв нь дараах хэсгээс бүрдэнэ:

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ: УДИРТГАЛ

- Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг тодорхойлох
- Мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн ач холбогдлыг судлах?
- Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол эзэмшсэний үр дүнд ямар мэдлэг чадвартай болохыг тодорхойлох?

2-Р ХЭСЭГ:

МХМСБ ба ИРГЭНИЙ ОРОЛЦОО

- Мэдээллийн хэрэгсэл болон номын сан, архив, Интернет гэх мэт мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн үүрэг
- Иргэд мэдээллийн хэрэгсэл болон номын сан, архив, Интернет гэх мэт мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад суваг, байгууллагаас юу хүлээх вэ
- МХМСБ нь ардчилал, сайн засаглалд ямар ач холбогдолтой вэ
- Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хэрэгсэл дэх редакцийн хараат бус байдал, мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн олон ургальч байдал.

3-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН НОМЫН САН, АРХИВ, ИНТЕРНЭТ ГЭХ МЭТ МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БУСАД СУВАГТАЙ ХАРЬЦАХ НЬ

- Мэдээллийн хэрэгсэл утга агуулгыг хэрхэн түгээн дамжуулдаг вэ?
- Дүрслэл: мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгууд мэдээлэл, хүн, соёл, дүр төрх, газар нутаг зэргийг хэрхэн дүрсэлдэг вэ?
- Хэрэглэгч, иргэдийн үүрэг
- Хэрэглэгч өөрийн бэлтгэсэн агуулгаар дамжуулан мэдээллийн хэрэгсэлтэй харьцах нь

4-Р ХЭСЭГ:

МХМСБ, ЗААХ БОЛОН СУРАХ ҮЙЛ ЯВЦ

- МХМСБ-ын заах арга барил
- МХМСБ-ын тухай болон МХМСБ-оор дамжуулан заахын ялгаа



СЭДЭВ 2:

СЭТГҮҮЛЗҮЙ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

60

“Сэтгүүлзүйн утга учир нь хараат бус мэдээлэлд тулгуурлан иргэдэд үнэнийг хэлэх явдалд оршдог.”

Жак Фуллер, “Мэдээг сурвалжлан бичих нь”

Мэдээлэл харилцааны шинэ технологийн хөгжил дэвшлийн ачаар уламжлалт мэдээллийн хэрэгслийн (радио, телевиз, сонины) тархац нэмэгдэж, мэдээлэл урьд өмнөхөөс илүү хүртээмжтэй болсон билээ. Мэдээллийн энэ эрин зуунд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарынхан шинэ болон уламжлалт мэдээллийн хэрэгслээр дамжуулан бидний өөрийн нүдээр харж, өөрийн чихээр сонсох боломжгүй мэдээллийг ойртуулан сонсгож, харуулахаас гадна нийгмийн амьдралд оролцох боломжоор хангаж, ардчиллыг илүү нээлттэй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Энэхүү сэдвийн хүрээнд шинэ ба уламжлалт мэдээллийн хэрэгслийн бидний хувийн амьдралд болон ардчилсан нийгэмд гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг танилцуулах бөгөөд үүнд жишээлбэл ардчилсан нийгмийн иргэний эрх чөлөөг бататгах, иргэний хариуцлага, үүрэг оролцоог дээшлүүлэх, ил тод, хариуцлагатай

байдлыг сайжруулах зэрэг үүрэг орно. Мөн мэдээллийн хэрэгслийн бусад үүрэг, тухайлбал нийгмийн үйл явцыг ердөө л толь мэт тусгахаас илүү мэдээллийг тодорхой бодлогын үүднээс сонгох, нягтлан шалгаж, тэнцвэржүүлэх хоточ нохойн үүрэг, олон нийтийн хэлэлцүүлгийн индэр байх, иргэний оролцоог дэмжих зэрэг үүргийн талаар ярилцана.

Сэдвийг үзсэнээр багш нар мэдээллийн эрх чөлөө, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар болон сэтгүүлзүйн нягт нямбай байдал, хариуцлага, ил тод байдлын тухай мэдлэгтэй болно.

Мэдээллийн шинэ технологийн ачаар иргэдээс ирүүлсэн гэрчийн мэдээлэл гэх мэт хэрэглэгчийн бэлтгэсэн мэдээллийн ач холбогдол өндөрсөж байна. Энэхүү үзэгдэл нь үзэл бодол, байр суурийн олон эшт байдлыг хангаж буй боловч нөгөө талаар мэдээллийн улам бүр олширч буй эх сурвалжид шүүмжлэлтэй хандах чадварыг илүү ихээр шаардаж байна. Тиймээс багш нар мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролтой болохын хэрээр өдөр тутам хүлээн авч буй мэдээллийг задлан шинжилж, үнэлж дүгнэх чадвартай болоод зогсохгүй нягт нямбай, шударга сэтгүүлзүйг нэхэн шаардах, чөлөөт, ардчилсан, олон ургальч мэдээллийн хэрэгслийг дэмжин сурталчлах иргэний үүргээ биелүүлэхэд дадлагажина.

1-р ХЭСЭГ:

СЭТГҮҮЛЗҮЙ БА НИЙГЭМ

- Үг хэлэх эрх чөлөө, чөлөөт хэвлэл мэдээллийн тухай ойлголт, бодит байдлын хувьсал
- Сэтгүүлзүйн нийгэмд болон ардчиллыг бүтээн байгуулахад гүйцэтгэх үүрэг (жишээлбэл эрх чөлөө, иргэний үүрэг хариуцлага, ил тод байдал гэх мэт)
- 21 дүгээр зууны сэтгүүлчийн улс орондоо болон дэлхий дахинд гүйцэтгэх үүрэг, хариуцлага (төвийг сахих, мэдээллийг тодорхой шалгуураар сонгох, хоточ нохой, иргэдийг дэмжигч гэх мэт)
- Олон нийтийн эрх ашигт үйлчлэх сэтгүүлзүй. Редакцийн хараат бус байдал ба эзэмшигч, хөрөнгө оруулагчийн нөлөөлөл
- Мэдээллийн ёс зүйн үүрэг, ач холбогдол

2-р хэсэг:

ЭРХ ЧӨЛӨӨ, ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГА

- Хэвлэлийн эрх чөлөө, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн ёс зүй

- Хэвлэл мэдээллийн байгууллага дахь ёс зүйн болон мэргэжлийн зарчим, олон улсын хэмжээнд хүчин төгөлдөр үнэт зүйлс: сэтгүүлч, мэдээллийн ажилтанд зориулсан удирдамж
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл явцад баримтлах ёс зүйн зарчим (ёс зүйн хороо, омбудсман, хараат бус хэвлэлийн консул, гомдол шийдвэрлэх хороо гэх мэт.)
- Хэвлэлийн эрх чөлөөний өмгөөлөгч, мэдээллийн хэрэгслийн ажиглагчид
- Иргэний үүрэг хариуцлага: Иргэн, сэтгүүлчийг холбох нь
- Иргэний сэтгүүлзүй

3-Р ХЭСЭГ:

МЭДЭЭ ГЭЖ ЮУ ВЭ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Мэдээний шалгуур, үнэ цэнэ
- Мэдээг үнэлэх, мэдээ бэлтгэх үйл явцад харгалзах зүйлс

4-Р ХЭСЭГ:

МЭДЭЭГ БЭЛТГЭХ ҮЙЛ ЯВЦ. 4W 1H –ээс гадна юуг мэдэх хэрэгтэй вэ

- Мэдээ олох, өгүүлэх санааг тодорхойлох, мэдээ бэлтгэх үйл явц
- Сэтгүүлзүйн амин сүнс нь нягтлан шалгах ухаан мөн



СЭДЭВ 3:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ ДЭХ ДҮРСЛЭЛ

“Биднийг хэрхэн харж буй байдал нь бидэнд хэрхэн хандах хандлагыг төрүүлдэг: бид бусдад хэрхэн хандах нь тэднийг хэрхэн харж буйгаас хамаарна; тийнхүү харах өнцөг нь бидний төсөөллөөс үүдэлтэй”

63

Ричард Даяр, Дүрсний асуудал

Мэдээллийн хэрэгслээр бусдыг янз бүрээр төлөөлүүлэн дүрсэлж болдог. Бид дүрслэлээр дүүрэн нийгэмд амьдарч байгаа бөгөөд телевиз, кино, цаг үеийн мэдээ, номноос өдөр бүр бидний амьдралд орж ирдэг дүрслэлээр хүрээлүүлж байна.

Сурвалжлагч, зохиолч, видео зураглаач, хэвлэн нийтлэлч, кино зохиолчид бүгд дүрс, дуу, үгсийн тусламжтайгаар үйл явдал, асуудлын тухай мэдээллийг бидэнд хүргэдэг. Тэд мэдээллээ бэлтгэхдээ ихэнх тохиолдолд цаг хугацаа, зай талбай, хүн хүч, хөрөнгө мөнгөний нөөц болон бусад хязгаарлалттай тулгардаг. Тийм учраас өгүүлэх гэж буй зүйлээс хамаараад үйл явдал, асуудлыг танилцуулахдаа арьсны өнгө, хүйс, нас, нийгмийн гарал зэрэг нийтлэг шинж чанарыг ашиглан тодорхой төлөөллийг дүрслэх шаардлага гарах нь олонтаа тохиолддог. Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй хүмүүс болж буй бүх үйл явдал, бүх хүний

тухай бүх мэдээллийг дамжуулж чадахгүйгээс хойш олон нийтэд түгээх агуулгыг тодорхой шалгуурын дагуу сонгохоос өөр аргагүй байдаг. Тийнхүү сонгох үйл явц нь хувийн үзэл бодлоос хамаарч, ингэснээр асуудлыг хэт хялбаршуулах, эсвэл тухайн хүний төсөөлөл, урьдчилсан дүгнэлтэд суурилсан мэдээлэл бэлтгэж, хэн нэгний тухай бодит үнэнд нийцэхгүй өрөөсгөл бөгөөд хэт явцуу мэдээлэл цацах нь цөөн бус тохиолддог. Үүнийг мэдээллийн зохиогч, эсвэл сэтгүүлч зориудаар, эсвэл санамсаргүйгээр хийж болно. Зарим үед мэдээллийг хүлээн авч буй үзэгч, сонсогч, уншигч өөрөө өрөөсгөл байдлаар ойлгох явдал ч гардаг. Харин мэдээллийн хэрэгсэл аль нэг талд өрөөсгөлөөр үйлчлэх, зөрчил үүсгэх, ялгаварлан гадуурхах үйлдэл хийвэл нийгмийн бусад этгээдийн нэгэн адил хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ мэдээллийн хэрэгсэл олон түмний хэлэлцүүлэг өрнүүлж, санаа бодлыг төлөвшүүлэх үүрэг бүхий индэрийн хувьд нийгэмд явагдаж буй маргаан, болж буй үйл явдлын тухай мэдээллийг аль нэг нам, хүчний нөлөө, хяналтгүйгээр дамжуулах боломжтой байх нь маш чухал юм.

Нөгөө талаар мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад суваг нь нийгмийн тодорхой орчин нөхцөлд ажилладаг учир тухайн орчин нөхцлөөс хамаарч байдгийг ойлгож, хүлээн зөвшөөрөх ёстой. Мэдээллийн хэрэгсэлд нийгэм нөлөөлж, нийгэмд мэдээллийн хэрэгсэл нөлөөлж байдаг. Тиймээс бид мэдээллийн хэрэгслийг ойлгохын тулд тухайн улс орны мэдээллийн хэрэгсэлд нөлөөлж буй тодорхой орчин нөхцлийг гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй.

64

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг эзэмших явцад бид мэдээллийн хэрэгслээр түгээж буй дүрслэл буюу мэдээллийн агуулгыг дангаар нь судлах бус, нийгмийн орчин нөхцөлтэй нь хамт шинжих ёстой боловч тэдгээр орчин нөхцлийг бид зарим үед үл анзаардаг. Мэдээллийн хэрэгсэл нийгмийг чиглүүлж, асуудалд анхаарлыг хандуулах, шаардлага тавих чадалтай хэдий ч нөгөө талаар мэдээллийн хэрэгслийн агуулга бол нийгмийн тусгал бөгөөд бидний хүсч, шаардаж, хүлээн зөвшөөрч буй зүйлийг л бидэнд өгч байдаг гэдгийг санах хэрэгтэй.

Дэлхийн олон оронд хэвлэл мэдээллийн салбарынхан өөрийн санаачилгаар олон ургальч байх зарчмыг тунхагласан байдаг бөгөөд өөрөөр хэлбэл агуулгын хувьд бүх хүнд хүртээмжтэй бөгөөд олон ургальч байх үүргийг сайн дураар хүлээдэг. Мөн хэвлэл мэдээллийн олон байгууллага хүчирхийллийг сурталчилсан, арьсны өнгө, гарал угсаа, нас, хүйс, оюун ухаан, биеийн чадвар, гэрлэлтийн байдал зэргээр ялгаварлан гадуурхсан агуулга түгээхийг хорих ёс зүйн зарчмыг дагаж мөрддөг.

Энэхүү сэдвийн хүрээнд суралцагсад дараах асуултад хариулт эрэлхийлэх болно: Мэдээллийн хэрэгслээр түгээж буй буруу буюу өрөөсгөл дүрслэл хэнд ашигтай, хэнийг хохироож байна вэ? Эдгээр дүрслэл нь бидний өөрсдийгөө болон бусдыг харах хандлагад хэрхэн нөлөөлж байна вэ? Эдгээр нь бидний биеэрээ буюу мэдэрч, хуримтлуулсан туршлагаас гадуур болж буй зүйлсийн талаарх мэдлэгт хэрхэн нөлөөлж байна вэ?

1-Р ХЭСЭГ:

СЭТГҮҮЛЗҮЙ БА ДҮРСНИЙ ХҮЧ

- Кейс судалгаа: сэтгүүлзүйн мэдээ
- Дүрсний хүч
- Гамшгийн дүрслэл
- Хүйсийн дүрслэл

2-Р ХЭСЭГ:

ОЛОН УРГАЛЫЧ БАЙДАЛ, НИЙГМИЙН ЯНЗ БҮРИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ЭРХ ТЭГШ ТУСГАХТАЙ ХОЛБООТОЙ МЭРГЭЖЛИЙН ЗАРЧИМ

- Мэдээллийн хэрэгслийн зарчим ба ёсзүй
- Мэргэжлийн зарчмыг төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэлд ашиглах нь
- Дүрэм зарчим, зохицуулалтыг үнэлэн дүгнэх

3-Р ХЭСЭГ:

ТЕЛЕВИЗ, КИНО, НОМ ХЭВЛЭЛ

- Уран сайхны кино – амжилтын нууц
- Кинон дахь дүрслэл
- Ном зохиолын дүрслэл
- Холливуд, нутгийн түүх, өгүүллүүд

4-Р ХЭСЭГ:

НИЙГМИЙН ТӨЛӨӨЛӨЛ БА ВИДЕО ХӨГЖИМ

- Видео хөгжмийг задлан шинжлэхүй
- Дүрслэл
- Хөгжим ба нийгмийн өөрчлөлт
- Дүрсний төлөвлөлт



СЭДЭВ 4:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХЭЛ НАЙРУУЛГА

66

“Хэл бол буруу ойлголцлын эх сурвалж”

Антони де Сэинт Экзюпери (1900 – 44)

‘Мэдээллийн суваг өөрөө мэдээ’ хэмээх энэхүү алдартай хэллэгийг Маршал МакЛукаан 1964 онд бичсэн билээ. Мэдээллийн хэрэгсэл нь мэдээ, мэдээллийг хэрхэн хүлээж авахад нөлөө үзүүлдэг нь үнэн боловч хэрэглэгчийн өөрийнх нь хуримтлуулсан туршлага ч мөн мэдээллийг хэрхэн ойлгоход нөлөөтэй байдаг. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролтой болох эхний чухал алхам бол мэдээлэл, бодол санаа, утга агуулгыг мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйчилгээ үзүүлэгч бусад суваг хэрхэн дамжуулдагийг ойлгож авах явдал юм. Мэдээллийн хэрэгсэл бүр өөрийн онцлогт тохирсон хэл найруулгыг ашиглаж, утга агуулгыг өвөрмөц байдлаар түгээдэг. Энд “хэл” гэж мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн салбарт ажиллагсад тодорхой санаа, мэдээлэл, мэдлэгийг дамжуулахын тулд сонгон авч хэрэглэж буй техник болон бэлэгдлийн шинжтэй тэмдэг, дүрс, хэм хэмжээг хэлж байна. Техник тэмдэгт дуу, зураг авалтын өнцөг, зураг авалтын төрөл, гэрэл зэрэг орно. Үүнд тухайлбал уран сайхны кинонд түгээмэл ашигладаг, аюулыг анхааруулах хөгжим, эсвэл эрх мэдэл, сүр хүчийн мэдрэмж төрүүлэх зорилгоор өндрөөс авсан зураг авалт зэргийг дурьдаж болох юм. Бэлэгдлийн тэмдэгт хэл, дүрүүдийн хувцаслалт болон үйлдэл, хялбар ойлгогдохуйц график дүрс зэрэг орно. Жишээ нь романтик уур амьсгал төрүүлэхийн тулд улаан сарнай, эсвэл уур хилэнг харуулахын тулд атгасан гар харуулдаг. Мэдээллийн хэрэгслийн хэлэнд мөн тодорхой нэг үг, хэллэг, дүрсийг олон дахин ашиглах явдал түгээмэл бөгөөд үүнийг аман болон дүрсний хэл гэдэг. Мэдээллийн хэрэгслийн хэлийг судлах явцад дараах гурван үндсэн асуудалд анхаарал

хандуулах нь чухал: Мэдээллийн хэрэгслийн хэлийг хэрэглэгч хэрхэн хүлээн авч ойлгож байна вэ? Мэдээллийн салбарынхны түгээмэл ашигладаг ямар үндсэн тэмдэг, бэлэгдэл, хэм хэмжээ байдаг вэ? Нэгэн ижил мэдээллийг өөр өөр хүмүүс өөр утга агуулгаар хүлээн авах боломжтой юу?

Сэдвийн зорилго нь багш нарыг мэдээллийн хэрэгслийн янз бүрийн хэл, найруулгын талаар мэдлэгтэй болгосноор мэдээлэл болон утга санааг хэрхэн дамжуулдагийг ойлгох, мөн мэдээллийн хэрэгслээр дамжин ирж буй бодол санаа, утга агуулгыг шинжин тайлбарлах замаар тухайн мэдээллийн хэрэгслийн ашигласан хэлний төрөл зүйлийг тодорхойлох чадвартай болгох явдал юм.

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГЫГ УНШИХУЙ

- Мэдээллийн бичвэрт ашигласан тэмдэг, хэм хэмжээг задлан шинжлэхүй
- Утга агуулгыг задлан шинжлэх – бэлэгдэл болон дүрсээр өгүүлэхүй
- Мэдээллийн хэрэгслийн хэлийг задлан шинжлэх – гэрэл зураг, видео эвлүүлэг

2-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БА МЭДЭЭЛЛИЙН УТГА САНАА: СОНИН ХЭВЛЭЛ, РАДИО ТЕЛЕВИЗИЙН МЭДЭЭ

- Сэтгүүлзүйн мэдээлэлд ашигладаг хэллэг, тэмдэг, хэм хэмжээг задлан шинжлэх
- Сэтгүүлзүйн мэдээнд хэлний хэрэгслийг ашиглах нь
- Мэдээллийн хэрэгслийн хэл ба утга санаа: мэдээ, мэдээллийг задлан шинжиж, үнэлэх

3-Р ХЭСЭГ:

КИНОНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛ, ӨГҮҮЛЭМЖ

- Киноны төрөл зүйл
- Кинонд ашигладаг техник болон бэлэгдлийн тэмдэг
- Кино зохиолын зураг авалтын төлөвлөлт



СЭДЭВ 5: СУРТАЛЧИЛГАА

68

Тодорхой санаа, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор хэвлэмэл болон электрон мэдээллийн хэрэгслийн цаг, зай талбайг төлбөртэйгээр ашиглахыг сурталчилгаанд хамруулна.

Ерөнхийдөө хоёр төрлийн сурталчилгаа байдаг. Үүнд арилжааны сурталчилгаа болон нийгэмд үйлчлэх зар мэдээ буюу нийгмийн маркетинг орно. Арилжааны сурталчилгаа нь ихэнхдээ хувь хүн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсвэл аж ахуйн нэгжийг сурталчилж борлуулалтыг нь өсгөх зорилготой байдаг. (Жишээлбэл хувцас, ундаа үйлдвэрлэгч компанийг, эсвэл шинээр гарсан киног сурталчлах зорилго бүхий дүрстэй болон хэвлэмэл сурталчилгааг дурьдаж болно). Харин нийгэмд үйлчлэх зар мэдээ нь бүх нийтийн эрх ашигт үйлчлэх мэдээлэл байдаг. (Жишээлбэл эрүүл мэнд, аюулгүй байдал, бүх нийтийн боловсролд хамааралтай мэдээлэл гэх мэт.) Энэ хоёр төрлийн сурталчилгаа нь уламжлалт болон шинэ мэдээллийн хэрэгслийн орлогын гол эх үүсвэрийг бүрдүүлдэг. Уламжлалт болон шинэ мэдээллийн хэрэгслийн аль аль нь олж авсан орлогоо үйл ажиллагааны зардалд болон шинэ агуулга үйлдвэрлэхэд (жишээлбэл телевизийн нэвтрүүлэг, цахим хуудсанд байршуулах материал, сэтгүүлийн өгүүлэл, радио нэвтрүүлэг бэлтгэх гэх мэтэд) зарцуулдаг. Орлогын энэхүү эх үүсвэргүйгээр ардчиллын тулгуур болж буй хувийн арилжааны мэдээллийн хэрэгслийн ихэнх нь дампуурахад хүрнэ. Тиймээс мэдээллийн хэрэгсэл зар сурталчилгааны орлого олохын тулд сурталчилгаанд мөнгө төлж буй болон төлөх боломжтой байгууллага, хүмүүсийн сонирхол хэрэгцээнд нийцэх боломжийг санал болгох нь чухал. Ингэхийн тулд аль болох олон хүний сонирхолд нийцсэн агуулга бэлтгэж, олон хүний анхаарлыг өөртөө татах гэж хичээх нь түгээмэл байдаг. Сурталчилгаа ямар нэг хэлбэрээр дэлхийн бөмбөрцгийн өнцөг булан бүрт хүрч байдаг. Аж ахуйн нэгж, байгууллага,

иргэд болон засгийн газар сурталчилгааг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчилж, итгэл үнэмшил, үнэт зүйлсийг түгээж байдаг. Сурталчилгаагаар дамжин цацагдаж буй мэдээлэл нь шийдвэр гаргагч олон түмэнд амин чухал ач холбогдолтой. Тийм учраас багш нар үр дүнтэй сурталчилгааг бүтээхийн тулд юу шаардлагатай байдгийг мэддэг байхын зэрэгцээ сурталчилгааг мэдээллийн эх сурвалжийнх нь хувьд үнэлэн дүгнэх чадвартай байх хэрэгтэй. Нөгөө талаар багш нар сурталчилгааны талаар өөрийн санал, шүүмжлэлийг холбогдох байгууллага, ажилтанд хүргэх ямар арга боломж байдгийг мэдэж авах нь чухал.

Сурталчилгаа мэдээллийн хэрэгсэлд мөн сөрөг нөлөөтэй байж болно. Зар сурталчилгааны мөнгө төлдөг байгууллагууд мэдээллийн хэрэгслийг дарамталсны улмаас сэтгүүлчид зөрчилтэй асуудлыг хөндөхөөс зайлсхийх болдог. Нөгөө талаар зар сурталчилгааны орлогоо нэмэгдүүлэхийн тулд мэдээллийн хэрэгсэл нийгмийн тодорхой хэсэгт сонирхолтой боловч бүх нийтийн ашиг сонирхолд төдийлөн ач холбогдолгүй нэвтрүүлэгт гол анхаарлаа хандуулах нь түгээмэл. Мэдээллийн байгууллага дахь редакцийн болон бизнесийн хэлтсүүдийн хооронд маш тодорхой зааг байхгүй бол тухайн байгууллагын бизнесийн ашиг сонирхол нь нэвтрүүлэг, мэдээний агуулгад нөлөөлж, далд хэлбэрээр сурталчилгаа явуулах нь түгээмэл болдог. Мэдээллийн технологийн асар хурдацатай хөгжлийн улмаас сурталчилгааны боломж улам бүр нэмэгдсээр байгаа учир олон түмний итгэл үнэмшлийг хадгалах үүднээс сурталчилгааны тодорхой зарчим, хэм хэмжээ үйлчилж байдаг. Эдгээр зарчмыг зар сурталчилгааны байгууллагууд гаргаж, үндэсний хэмжээнд дагаж мөрддөг бөгөөд сурталчилгааг нягт нямбай, бодитой, шударга байлгахад чиглэгддэг. Олон оронд сурталчилгааны зөвлөл болон хэрэглэгчдийн ашиг сонирхолыг хамгаалах нийгэмлэг ажилладаг бөгөөд иргэд сурталчилгаатай холбоотой санал бодлоо тэдэнд хандан илэрхийлдэг.

Өнөөгийн нийгэмд сурталчилгааны уламжлалт үүрэг өөрчлөгдөж, улам бүр тэлж байна. Сурталчилгаа нь телевиз, сэтгүүл, эсвэл гудамжны самбараар хязгаарлагдахаа больж, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны талаар олон янзын санаа, мэдээллийг цахим хуудас, гар утас болон бусад хэрэгсэл, кино, телевизийн нэвтрүүлэгт бүтээгдэхүүн байршуулах арга, ивээн тэтгэлгийн гэрээ зэрэг илүү олон янзын арга хэрэгслээр хэрэглэгчдэд хүргэж байна. Засгийн газар болон төрийн бус байгууллагууд ч өөрийн бодлого, хөтөлбөрийг сурталчилж, дэмжлэг авах, олон нийтийн дунд эерэг сэтгэгдэл төрүүлэх зэрэг зорилгоор сурталчилааг ашиглаж байна. Олон оронд дотоодын зар сурталчилгааны зах зээл бага байдгийн улмаас тухайн оронд ажиллаж буй мэдээллийн хэрэгслийг бүгдийг хангалттай орлогоор хангаж чаддаггүй. Тийм учраас мэдээллийн байгууллагууд зарим үед гадаадын компани болон засгийн газрын сурталчилгаанаас хамаарч байдаг. Нөгөө талаар олон улсын зарим байгууллага тодорхой улс орны хэрэглэгчдэд хүрэх зорилгоор дотоодын мэдээллийн хэрэгслийн зай талбайг худалдаж авдаг. Сүүлийн жилүүдэд “супер брэнд” буюу дэлхий даяар танигдсан, сурталчилгаа нь хил хязгаарын зааг ялгаагүй түгээгддэг бүтээгдэхүүн, үйлчилгээ олширч байна.

1-р хэсэг:

СУРТАЛЧИЛГАА, ОРЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

- Зар сурталчилгааны зохицуулалтыг шинжихүй
- Одоогийн зар сурталчилгааны зохицуулалт хэрхэн хэрэгжиж байна вэ
- Зар сурталчилгаа орлогын эх үүсвэр болох нь

2-р хэсэг:

ОЛОН НИЙТЭД ҮЙЛЧЛЭХ ЗАР МЭДЭЭ

- Олон нийтийн ашигт үйлчлэх зар мэдээлэл
- Олон нийтийн ашигт үйлчлэх зар мэдээллийг төлөвлөх бүтээлч үйл явц

3-р хэсэг:

СУРТАЛЧИЛГАА: БҮТЭЭЛЧ ҮЙЛ ЯВЦ

- Сурталчилгаа ба ивээн тэтгэлэг – байршил, санаа, зорилтот хэрэглэгчид
- Сурталчилгааны уриа тунхагийг шинжих нь
- Сурталчилгааны бүтэц загвар, зохиол, бүтээх үйл явц
- Нэвтрүүлэгт бүтээгдэхүүн байршуулах

4-р хэсэг:

СУРТАЛЧИЛГАА БА УЛС ТӨРИЙН ТАЛБАР

- Улс төрийн болон сонгуулийн сурталчилгааг задлан шинжлэх
- Улс төрийн сурталчилгаанд мөрдөх удирдамжийг задлан шинжлэх
- Сонгуулийн сурталчилгааг зохицуулах байгууллагыг задлан шинжлэх
- Үндэсний хэмжээний сонгуулийн үед мэдээллийн хэрэгсэлд хамаарал бүхий зохицуулалт



СЭДЭВ 6: ШИНЭ БА УЛАМЖЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Энэхүү сэдвийн хүрээнд багш нар шинэ болон шинэчлэгдэж буй уламжлалт мэдээллийн технологи нь иргэдэд нийгэм, эдийн засаг, улс төрийн өөрчлөлтөд оролцох илүү өргөн боломжийг нээж өгч буйн талаар үзнэ. Түүнчлэн мэдээллийн хэрэгслийн цахим болон электрон хувилбар (онлайн мэдээ, блог, Википедиа, ЮуТьюб, нийгмийн сүлжээний хэрэгсэл, видео тоглоом гэх мэт) нь уламжлалт мэдээллийн хэрэгслээс хэрхэн урган гарч, мэдээлэл болон мэдлэг олжавах, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, сайн засаглал, ардчилсан үйл явцад оролцох боломжийг хэрхэн дээшлүүлж буйг тайлбарлана. Хэвлэмэл болон электрон мэдээллийн хэрэгсэл (радио, телевиз), Интернет, гар утас зэрэг нь мэдээллийг олон сувгаар нэгэн зэрэг цацах боломжийг нээснээр мэдээлэл хүртэх боломжийг дээшлүүлж, оролцооны соёлыг хөгжүүлж буй юм. Учир нь иргэд өмнө нь мэдээллийг хүлээн авагч байсан бол өнөө үед мэдээллийг бэлтгэх болон түгээх үйл явцад идэвхтэй оролцох боломжтой болоод байна. Мэдээлэл харилцааны шинэ технологи нь иргэдэд мэдээлэл, мэдлэгээ өөр хоорондоо хуваалцах боломжийг нээж өгсөн бөгөөд ардчилсан үйл явцад илүү идэвхтэй оролцох явдлыг дэмжиж, тухайн улс орныг илүү нээлттэй болгоход эерэгээр нөлөөлж болж байна.

Эцсийн дүнд шинэ болон шинэчлэгдэж буй уламжлалт мэдээллийн хэрэгсэл нь иргэдийн мэдээлэл солилцох, үзэл бодлоо илэрхийлэх ардчилсан үйл явцын шинэ орон зайг нээж буй юм. Улмаар иргэдийн ардчилсан үйл явцад ухамсартайгаар оролцох боломжийг сайжруулж, дэлхий дахины асуудлыг орон нутагт ойртуулж өгч байна.

1-Р ХЭСЭГ:

УЛАМЖЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭС ШИНЭ ТЕХНОЛОГИД

- Мэдээллийн хэрэгслийн товч түүх: өөрчлөлт шинэчлэл ба уламжлал
- Мэдээллийн хэрэгслийн өөр хоорондоо уусан нэгдэх үйл явц гэж юу вэ?
- Цахим мэдээллийн хэрэгсэл мэдээллийн шинэ хэрэгсэл болох нь
- Уламжлалт болон шинэ мэдээллийн хэрэгслийн үндсэн ялгаа

2-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ – ОЛОН ТҮМНИЙ БОЛОН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА

- Шинэ мэдээллийн хэрэгсэл ба нийгмийн харилцаа: нийгмийн сүлжээний болон бусад хэрэгсэл.
- Мэдээлэл харилцааны технологи ба хөгжил дэвшил
- Шинэчлэгдэж буй олон түмний мэдээллийн харилцаа болон ардчилсан үйл явцын өөрчлөлт шинэчлэлийн уялдаа холбоо

3-Р ХЭСЭГ:

СУРГАЛТЫН ТАНХИМД ЦАХИМ ТОГЛООМ ЗЭРЭГ ИНТЕРАКТИВ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОМЖИЙГ АШИГЛАХ НЬ

- Интерактив цахим мэдээллийн хэрэгсэл, нээлттэй боловсролын мэдээллийн нөөц, боловсрол олгох үйл явцыг компьютерийн тусламжтайгаар боловсронгуй болгох шийдлүүд
- Суралцагчид ээлтэй сургалтын орчныг бий болгоход интерактив цахим мэдээллийн хэрэгсэл болон цахим тоглоомыг ашиглах нь
- Дэлхий дахинд тулгарч буй асуудлуудын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахим тоглоомыг ашиглах нь
- Боловсролын тоглоом ба зугаа цэнгээний тоглоом



СЭДЭВ 7: ИНТЕРНЭТИЙН БОЛОМЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Бүхий л насны иргэдийн хувьд мэдээллийн нийгэмд оролцох боломжтой байх нь амин чухал юм. Интернет нь боловсрол, ажил мэргэжлийн ертөнц, эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, хэрэглэгчдэд амьдралаа сайжруулах илүү өргөн боломжийг нээж өгдөг. Мэдээлэл хадгалах арга хялбаршиж, олон төрлийн хэрэгслийн тусламжтайгаар Интернетэд нэвтрэх боломж нэмэгдсэнээр мэдээллийн хүртээмж, нөөц боломж эрс сайжирч байна. Хүүхэд залуучуудын ихэнх нь Интернетийг хэрхэн ашиглахаа сайн мэддэг тул тэдэнд асар их боломж нээлттэй байдаг. Гэвч тэд мөн Интернетийн эрсдэлд ч хамгийн өртөмтгий хүмүүс юм. Интернеттэй холбоотой эерэг хөгжлийг сөрөг нөлөө дагалдаж байдаг бөгөөд энэ нь бидний өдөр тутмын амьдралд угаасаа байсаар ирсэн аюул эрсдэл дээр нэмэлт эрсдэлийг авч ирж байгаа билээ.

Насанд хүрээгүй хүмүүсийг тэдгээр сөрөг нөлөөнөөс хамгаалах арга хэмжээ авснаар энэхүү асуудлыг тодорхой хэмжээгээ шийдвэрлэх боломжтой. Хэдийгээр эдгээр арга хэмжээ нь ямар нэг хэмжээгээр тустай байх боловч хүүхэд, өсвөр үеийнхнийг Интернетийг хариуцлагатайгаар ашигладаг болгох зуун хувийн найдвартай арга байж чадахгүй байна. Тэднийг Интернетийн аюул эрсдэлтэй зөв харьцаж, сөрөг нөлөөнөөс зайлсхийх талаар мэдлэгжүүлэн боловсруулах л тэдэнд туслах хамгийн сайн арга болоод байна. Үүнд мэдээллийн технологийг ашиглах нь тустай байх болно.

1-р хэсэг:

ЦАХИМ ЕРТӨНЦ ДЭХ ЗАЛУУ ҮЕ

- ВЕБ 2.0 ба цахим ертөнц
- Интернэтийн хэрэглээ ба хүүхэд залуучуудын цахим хэвшил
- Хүүхдийн эрхтэй холбоотой олон улсын конвенц болон бусад арга хэрэгсэл

2-р хэсэг:

ЦАХИМ ЕРТӨНЦӨД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ БА ЭРСДЭЛ

- Интернэтийг ашиглахтай холбоотой асуудал бэрхшээлийг ойлгож мэдэхүй
- Мэдлэгт суурилсан хүч ба Интернэтийн хариуцлагатай хэрэглээ
- Хувийн нууц ба аюулгүй байдал



СЭДЭВ 8: МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ БА НОМЫН САН АШИГЛАХ ЧАДВАР

Хөтөлбөрт багтсан нэгдүгээр сэдэв болон уг сэдэвтэй холбоотой хичээлүүдийн хүрээнд багш нар МХМСБ-ын тухай ойлголттой болсон байна. Харин энэхүү сэдэв нь МХМСБ-д мэдээлэл ашиглах өөр бусад амин чухал чадвар хамаардгийг таниулах зорилготой юм. Сэдэвт хамаарах багц хичээлээр мэдээллийн суурь боловсролын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар ойлголтыг илүү тодорхой болгож өгнө.

75

Боловсролын ихэнх үйл ажиллагаанд мэдлэг олгоход голлон анхаарч, харин сурах арга барилд сургахыг тэр бүр хичээдэггүй. Гэтэл МХМСБ-ын үнэ цэнэ нэмэгдэхийн хэрээр мэдээллийн хэрэглэгчид чадварлаг суралцагсад байхын ач холбогдол өндөрсөж байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн тодорхойлох, мэдээллийн байршлыг үр дүнтэйгээр олж тогтоон богино хугацаанд шаардлагатай мэдээллээ олж авах, тодорхой шийдвэр гаргах зорилгоор мэдээллийг задлан шинжлэх, зохион байгуулах, үнэлэн дүгнэх болон хэрэглэх, дахин бүтээх, бусадтай хуваалцах зэрэг чадварыг эзэмших шаардлага тулгараад байна. (ЮНЕСКО, 2008).

Багш нар асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах зорилгоор мэдээлэл олж авах, ойлгох, өөрийн хэрэгцээнд тохируулан ашиглах, шинэ мэдээлэл бүтээх, хадгалах, бусдад танилцуулах мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшиж, улмаар суралцагсдад дамжуулах чадвартай болох ёстой. Эдгээр мэдлэг, чадвар, хандлагыг заах болон сурах ямар ч орчинд хэрэглэж болох бөгөөд үүнд тухайлбал боловсролын салбар, ажил мэргэжлийн орчин болон хувиараа сурч мэдлэгээ баяжуулах орчин нөхцөл хамаарна. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол бүхий багш

хүн янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээлэл болон түүний утга санааг ойлгож, үнэлэн дүгнээд, асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглах чадвартай болох юм. Тэрээр мөн номын сан ашиглаж, баримт бичгийг сурах болон бусадтай хуваалцах зорилгоор хамгийн үр бүтээлтэйгээр ашиглах арга барилыг эзэмшсэн байна.

Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол бүхий багш нар мэдээллийн хэрэгсэл болон номын сан, архив, Интернет болон судалгааны байгууллага гэх мэт мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгийн нийгэмд гүйцэтгэх үүргийг мэдэж, үнэлдэг болно.

Мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч сувгууд нь иргэдэд мэдээлэл өгөх болон мэдээллийг хадгалахад чухал үйлчилгээ үзүүлдэг. Мөн иргэд мэдээллийн хэрэгслээс гадна өөр бусад эх сурвалжаас ч мэдээлэл авдаг (жишээлбэл эрүүл мэндийн зөвөлгөөн, засгийн газрын тайлан, албан болон албан бусаар бусдаас мэдээлэл авах гэх мэт). Олон түмний мэдээлэл солилцох үйл явц нь электрон аргаар (жишээлбэл телевизээр дамжуулдаг сонгуулийн мэтгэлцээн) эсвэл нүүр тулан ярилцах байдлаар (жишээлбэл хотын захиргаанаас зохион байгуулдаг уулзалтууд) болж болно. Эдгээр үйл явдлыг мэдээллийн хэрэгсэл, эсвэл хүмүүс өөрсдөө бусдад дамжуулна. Хамгийн гол нь МХМСБ-д номын сан ашиглах чадвар, мөн судалгаа хийх, сурах арга барил болон технологи ашиглах чадвар хамаардагийг эндээс олж харах боломжтой.

76

Сэдвийн хүрээнд багш нар мэдээллийн суурь боловсролд хамаарах мэдлэг чадварын тухай өргөн мэдлэгтэй болж, номын сан ашиглах болон сургалтын орчинд асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах зорилгоор цахим мэдээллийн хэрэгслийг ашиглах чадвараа хөгжүүлнэ. Түүнчлэн мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол болон цахим технологийн тухай болон тэдгээрийн уялдаа холбооны талаар онолын мэдлэгээ дээшлүүлж, өнөөгийн ертөнцөд буй асар их мэдээллийг үр дүнтэйгээр хүртэж ашиглах чадвартай болно. Эдгээр чадвар нь мэдээлэл авах, өөрөөр хэлбэл оюуны амьдралд идэвхтэй оролцох насан туршийн үйл явцыг баталгаажуулж өгөх юм.

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ОНОЛ, ХЭРЭГЛЭЭ

- Мэдээлэл ба мэдээллийн суурь боловсролын удиртгал
- Мэдээллийн суурь боловсролд хамаарал бүхий онолын үндсэн ойлголтууд
- Нийгэмд болон шинэ чадвар эзэмшихэд мэдээллийн үзүүлэх нөлөө
- Мэдээллийн суурь боловсролын хэм хэмжээ, хэрэглээ
- Мэдээллийн суурь боловсролын үе шат

2-Р ХЭСЭГ:

СУРАХ ОРЧИН БА МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ

- “Том 6” – мэдээлэлд суурилж асуудлыг шийдвэрлэх 6 алхамын удирдамж
- Номын сан ашиглах нь
- Сурах орчин ба мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч сувгууд

3-Р ХЭСЭГ :

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ

- Онлайн мэдээллийн мөн чанар
- Компьютерийн хард болон софт бүтцийн тухай ойлголттой болох
- Цахим мэдээллийн эрин үеийн оюуны өмчийн асуудал. Компьютерийн программ болон цахим мэдээллийг хамгаалах нь
- Цахим аргаар орчуулах, аман яриаг тэмдэглэх, аудио бичлэг хийх зэрэг цахим үйлчилгээ
- Интернетээр суралцах нь
- Цахим мэдээллийн хадгалалт, цахим хувилбарууд



СЭДЭВ 9: МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА, МХМСБ БА СУРАХ ҮЙЛ ЯВЦ

Агуулгын шинэчлэл заах үйл явцын шинэчлэлийг шаардана

78

МХМСБ-ын сургалтын хөтөлбөрийн энэхүү баримт бичгийг мэдээлэл харилцааны салбарын өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй.

Заах болон сурах үйл явц нь өөр хоорондоо нягт уялдаатай бөгөөд мэдээллийн харилцааны салшгүй хэсэг юм. Үнэндээ бол нэг нь нөгөөгүйгээрээ үр дүнтэй байж чадахгүй (НДонгко, 1985). Багш, суралцагсад ухамсартайгаар, эсвэл өөрөө ч анзааралгүйгээр мэдээллийн харилцааны суурь болон ахисан түвшний арга хэрэгслийг сургалтын танхимд ашигладаг. Олон түмний мэдээллийн хэрэгслийг (радио, телевиз, сонин гэх мэт) сургалтын танхимд ашиглах үед заах болон сурах үйл явц илүү ярвигтай болдог. Багш, сурагчид МХМСБ-ын чадваруудыг эзэмшсэнээр сургалтын орчныг баяжуулж, заах болон сурах үйл явцыг илүү амьд байдлаар хэрэгжүүлэх боломжтой болдог. Багш, сурагчид мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч сувгуудтай харьцаж эхэлснээр ардчилсан, олон ургальч, мэдлэг бүтээх үйл явцыг дэмжсэн сургалтын орчныг бий болгох юм.

Энэхүү сургалтын хөтөлбөрийн сүүлийн сэдэв нь өмнө үзсэн сэдвүүдийг батжуулан баяжуулж буй юм. Уг сэдвийн хүрээнд мэдээллийн харилцаа болон сурах үйл явцын уялдаа холбоог (мөн түүнчлэн сурах үйл явцын тухай онолуудыг) судалж, МХМСБ нь энэхүү уялдааг хэрхэн сайжруулж болохыг хөндөнө. Сэдвийн төгсгөлийн хэсэгт МХМСБ-ыг дэмжих сургалтын орчныг бүрдүүлж, өөрчлөлт шинэчлэлийг хэрхэн удирдах тухай хэлэлцэх юм.

1-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА, ЗААХ БОЛОН СУРАХ ҮЙЛ ЯВЦ

- Мэдээллийн харилцааг тодорхойлох нь
- Мэдээллийн харилцааны үндсэн онолууд
- Заах болон сурах үйл явц нь мэдээллийн харилцаа болохыг судлах. МХМСБ нь мэдээллийн харилцааг хэрхэн сайжруулдаг вэ
- МХМСБ-оор дамжуулж МХМСБ-ыг заах арга барил

2-Р ХЭСЭГ:

СУРАХ ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ ОНОЛ БА МХМСБ

- Заах арга ухаан ба МХМСБ
- Танин мэдэх мета чадвар буюу дээд чадвар гэж юу вэ?
- Танин мэдэх мета чадвар ба МХМСБ: уялдаа холбоог хөгжүүлэх нь

3-Р ХЭСЭГ:

СУРГУУЛИЙН ОРЧИНД МХМСБ-Д ЭЭЛТЭЙ ОРЧИН БИЙ БОЛГОХ ӨӨРЧЛӨЛТИЙГ УДИРДАХ НЬ

- Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг дэлхий дахинаа хөгжүүлэгч хүчин: олон улсын хэмжээнд хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаа, баримт бичиг, бодлогын тойм.
- МХМСБ-ыг боловсролын салбарт нэвтрүүлэхэд шаардлагатай орчин нөхцөл
- МХМСБ-ыг сургуулийн орчинд нэвтрүүлэхэд тулгамддаг бэрхшээл, тэдгээр бэрхшээлийг даван туулахад ашиглаж болох арга зам



ҮНДСЭН БУС
СЭДЭВ



СЭДЭВ 10: ХЭРЭГЛЭГЧИД

82

Бид бүгдээрээ хэвлэл мэдээллийн хэрэглэгч. Хүүхэд залуучууд болон томчууд бүгд өдөр бүр мэдээллийн хэрэгсэлд болон мэдээллийн харилцаанд нэлээд их цагийг зарцуулдаг. Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийг идэвхгүй, жигд нэгэн бүхэл цул бөгөөд илгээсэн мэдээллийг бүгд нэгэн ижлээр хүлээн авч, ойлгодог хэмээн үзэж байсан цаг үе бий. Тодорхой яривал, хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийг судлах хоёр үндсэн арга бий. Эхнийх нь хүмүүсийг мэдээллийн хэрэгслийн хэрэглэгч буюу “зорилтот бүлэг” хэмээн үзэж, судлах явдал. Нөгөө нь хүлээн авагчийн тухай онолд тулгуурладаг бөгөөд үзэгч, сонсогч, уншигчдыг мэдээллийн хэрэгслийн агуулгыг идэвхтэйгээр хэрэглэгч буюу мэдээллийн харилцааны оролцогч гэж үздэг.

Хэвлэл мэдээллийн зорилтот хэрэглэгч гэдэг бол нас, орлого, хүйс, сонирхол зэрэг тодорхой шинж чанараар нь нэгтгэсэн уншигч, үзэгч, сонсогчийн хэсэг бүлэг юм. Эдгээр бүлгүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагууд тодорхой агуулга, утга санааг зориудаар бэлтгэж нийлүүлдэг. Зар сурталчилгаа өгөгч байгууллага тодорхой газар нутгийн юм уу, эсвэл өөр шинж чанар бүхий хэсэг бүлэг хүнд сурталчилгааг нь хүргэж өгч чадах мэдээллийн хэрэгслийн эфирийн цаг, зай талбайг худалдаж авах сонирхолтой байдаг. Тухайлбал сурталчилгаагаа тодорхой хэсэг бүлэгт зориулан телевизээр цацах сонирхол бүхий байгууллага тухайн зорилтот бүлгийнх нь сонирхолыг татаж чадаж буй аль нэг телевизээс сурталчилгааны цаг худалдаж авна. Хэдийгээр биднийг зорилтот хэрэглэгч хэмээн тодорхойлж болох боловч бид мэдээллийн хэрэгслээр ямар нэг зүйл үзэх, сонсох бүртээ өөр өөрийн мэдлэг туршлагаас хамаарч тухайн агуулгыг өөрөөр ойлгож хүлээж авдаг. Өөрөөр хэлбэл бид тухайн мэдээллийг өөрийн хувийн үзэл бодол, үнэт зүйлсийн үүднээс тайлбарладаг. Ингэхдээ бид олонх тохиолдолд тухайн мэдээллийн зарим хэсгийг хүлээн зөвшөөрч, заримыг нь үгүйсгэдэг буюу *зөвшилцөл хийдэг* байх магадлалтай. Мөн тухайн мэдээллийн хэлбэр (жишээлбэл гэрэл зураг болон видео дүрсний хувьд зураг авалтын өнцөг, хэлбэр, засварласан байдал зэрэг) нь мэдээллийг хэрхэн ойлгож хүлээн авахад ихээхэн нөлөөлдөг.

Судалгаанаас үзэхэд, сэтгүүлийн уншигч нэг нүүрийг хоёр орчим секунд гүйлгэж хардаг аж. Телевизийн дундаж сурталчилгаа ихэнхндээ 15 – 30 секунд үргэлжилдэг боловч олон үзэгч сурталчилгаа гармагц сувгаа сольдог бол Интернэт хэрэглэгч өөр хуудас нээдэг бөгөөд нэг удаа нэг суваг дээр, эсвэл Интернэтийн нэг нүүрэнд хэдхэн секундийн туршид л анхаарлаа хандуулдаг. Тиймээс өнөө үеийн хэрэглэгчийн анхаарлыг богино хугацаанд татаж чадахын тулд мэдээллийн агуулгыг бэлтгэж буй хүмүүс зорилтот бүлгийнхээ хандлага, итгэл үнэмшил, үзэл бодол, шаардлага хэрэгцээнээс үүдэх онцлог шинжийг судалсны үндсэн дээр тэдний сэтгэлийг хөдөлгөх зүйлийг олж бүтээхийг зорьдог. Энэ ажлыг гүйцэтгэдэг хэвлэл мэдээллийн бүтээлч багийнхан тухайн агуулгад хүн бүр хэрхэн хандахыг урьдчилан хэлж чадахгүй хэдий ч судалгааны дүнгээс тэд зорилтот бүлгийн ихэнх нь буюу нийгмийн томоохон хэсэг бүлэг тодорхой агуулга, хэлбэрт хэрхэн хандахыг мэддэг.

Бид яагаад хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийг судалдаг вэ? Хэрэглэгчийн судалгаа нь янз бүрийн хэрэглэгч хүйс, нас, нийгэмд эзлэх байр суурь зэргээсээ хамаарч олон янзын чухал асуудлыг хэрхэн хүлээн авч буйг ойлгоход тус болдог. Түүнчлэн мэдээллийг бүтээгч болон түүний хэрэглэгчийн хоорондох харилцааг, мөн мэдээллийг бүтээгчид бэлтгэсэн материалаа хэрэглэгчдэд өөрийн хүссэнээрээ ойлгуулахын тулд тэдэнд хэрхэн нөлөөлдөг зэргийг ойлгож авахад хэрэглэгчийн судалгаа тус болно.

Судалгаа мөн хүүхэд залуучууд сургуулийн танхимаас гадуур хүлээн авсан мэдээллээ амьдралд хэрхэн ашиглаж буйг ойлгоход нэмэртэй. Мэдээллийн энэ эринд бид өөрсдөө мэдээллийг хэрхэн бэлтгэж, өөрийн зорилтот хэрэглэгчид хэрхэн илүү үр дүнтэйгээр хүргэх тухай мэдлэгийг хэрэглэгчийн судалгаанаас олж авч болно.

Энд санал болгож буй сэдвийн хүрээнд хэд хэдэн чухал асуудлыг хөндөх юм. Үүнд тухайлбал мэдээллийг бүтээгчийн хувийн мэдлэг туршлага нь мэдээллийн хэрэглэгчид илгээсэн материалыг ойлгож хүлээн авахад хэрхэн нөлөөлдөг вэ? Мэдээллийн бүтэц нь түүний агуулгыг ойлгох үйл явцад хэрхэн нөлөөлдөг вэ? Хувь хүн мэдээллийн хэрэгслээс хүлээн авсан зүйлийг хэрхэн “зөвшилцдөг” вэ? Хэрэглэгчид мэдээллийн хэрэгслийг өдөр тутмын амьдралдаа хэрхэн ашигладаг вэ? гэх зэрэг асуултууд орно.

- Мэдээллийн хэрэглэгч ба зах зээлийн судалгаа
- Зорилтот хэрэглэгчийг тодорхойлох нь
- Хэрэглэгчид мэдээллийн агуулгыг хэрхэн зөвшилцдөг вэ?



СЭДЭВ 11: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, ТЕХНОЛОГИ БА ДАЯАРШСАН ТОСГОН

84

Мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харъяалал, хяналтын асуудал нь мэдээллийн агуулга болон мэдээлэл бэлтгэх болон түгээх үйл явцад шийдвэрлэх ач холбогдолтой. Хэдийгээр сэтгүүлчид өдөр тутмын ажилдаа ардчилал, хэвлэлийн эрх чөлөө, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлж, сурталчилдаг боловч энэхүү эрх чөлөө, сэтгүүлчдийн хараат бус байдалд мэдээллийн хэрэгслийн эзэмшигч, ажил олгогчийн эдийн засгийн болон улс төрийн ашиг сонирхол тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг бөгөөд ийм нөлөөлөл зарим газар хүчтэй, зарим газар бага байдаг.

Энэхүү хяналтын мөн чанар нь үндсэндээ тухайн цаг үеийн улс төрийн (зарим үед геополитикийн) нөхцөл байдал болон мэдээллийн хэрэгслийн төвлөрлөөс хамаарна. Тийм ч учраас редакцийн хараат бус байдал болон мэдээллийн хэрэгслийн олон ургальч байдал нь орон нутгийн болон олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой юм. Мэдээллийн хэрэгсэл эдүгээ газар зүйн хувьд улам бүр өргөн хүрээг хамарсаар байгаа учир мэдээллийн урсгал нь хойноос өмнөд зүгт төдийгүй өмнө зүгээс хойд зүгт болон хойноос хойшоо чиглэж байна. Бүсийн хэмжээний зарим мэдээллийн хэрэгсэл нь олон улсын мэдээллийн хэрэгслийн тогтолцоонд улам бүр хүчтэй нөлөөлж байна.

Дэлхийн ихэнх оронд хэвлэл мэдээллийн байгууллага арилжааны хувийн компани хэлбэрээр хөгжиж буй билээ. Гэхдээ хувийн боловч арилжааны бус мэдээллийн хэрэгсэл, тухайлбал төрийн бус байгууллагуудаас ажиллуулдаг мэдээллийн хэрэгсэл, мөн төрөөс эзэмшиж, хянадаг хэвлэл мэдээллийн байгууллага байдаг. Өргөн нэвтрүүлгийн салбарт олон нийтийн радио телевиз нь арилжааны болон төрийн мэдээллийн хэрэгслээс ялгаатай альтернатив загвар юм. Түүнчлэн нэгдмэл сонирхол бүхий иргэдийн бүлэг эзэмшиж, өөрсдөө нэвтрүүлгээ бэлтгэдэг, нийгмийн цөөнхийн дуу хоолойг илэрхийлдэг мэдээллийн хэрэгсэл хөгжиж олширч байгаа

нь эерэг үзэгдэл мөн. Сүүлийн үед дэлхийн эдийн засагт технологийн хөгжил дэвшил нөлөөлж буйн улмаар олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг үндэстэн хоорондын мэдээллийн конгломерат бий болж байна. Тэдгээрийн эрх мэдэл, нөлөөлөл нь газар зүй, эдийн засаг, улс төрийн зааг хязгааргүйгээр үйлчилж байна. Олон улсын хэмжээний иймэрхүү мэдээллийн хэрэгсэл нь ихэвчлэн бүсийн хэмжээнд ажилладаг. Мэдээллийн хэрэгслийн өөр хоорондоо уусах үйл явц нь хэвлэл мэдээллийн компаниуд улсын болон олон улсын хэмжээнд нэгдэх, нэг нь нөгөөхөө худалдаж авах явдлыг түргэтгэж буй юм. Түүнчлэн хэвлэл мэдээллийн олон байгууллага харилцаа холбоо, веб хэрэгсэл болон зугаацуулан цэнгээх салбарын (кино болон видео тоглоом) бусад компанитай хүчээ нэгтгэж хамтран ажиллаж байна. Ийнхүү нэгдэх үйл явцын дунд үүсэж хөгжсөн компаниуд улам бүр хүчирхэгжих нь тодорхой. Учир нь тэдгээр компани мэдээлэл, дуу дүрсийг дэлхий дахинаа түгээх боломжтой бөгөөд хамгийн алслагдмал газар нутагт хүртэл хэвлэмэл, электрон болон цахим сувгаар хүрч байна.

Олон улсын мэдээллийн хэрэгсэл үүсч хөгжсөн явдал нь нэг талаар боломж, нөгөө талаар асуудал бэрхшээлийг дагуулж байна. Зарим судлаачид соёлын нэг хэвийн байдал үүсэхээс сэрэмжлүүлж буй боловч мэдээллийн хэрэгсэл мөн соёлын олон ургальч байдалд эерэгээр нөлөөлж буйг харгалзах нь зүйтэй (жишээлбэл орон нутгийн мэдээллийг өнөө үед бэлтгэж, бусадтай хуваалцах илүү хялбар болоод байгаа). Олон улсын мэдээллийн хэрэгсэл нь мөн мэргэжлийн илүү өндөр хэм хэмжээг дэвшүүлэн хөгжүүлэх чадалтай. Улмаар орон нутгийн шинжтэй мэдээллийн олон байгууллага агуулгын чанараа дээшлүүлэх замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэхээс өөр аргагүйд хүрч байгаа юм. Үүнээс гадна дэлхий дахинаа нөлөөлж буй зарим асуудал, тухайлбал цаг уурын өөрчлөлт, тахал, биологийн төрөл зүйлд учирч буй аюул эрсдэл зэргийн талаарх мэдээллийг олон улсын мэдээллийн хэрэгслээр илүү үр дүнтэйгээр түгээх боломжтой. Мөн түүнчлэн улс төр, эдийн засгийн саад хязгаарын улмаас тодорхой улсын болон бүсийн хэмжээнд нуугдмал байдалд буй асуудлыг олон улсын мэдээллийн хэрэгсэл илчилж, дэлхий дахинаа түгээж буйг хүлээн зөвшөөрөөд байна. Хэвлэл мэдээллийн салбар улс төрийн нөхцөл байдлыг хүртэл өөрчилж байна.

Мэдээллийн шинэ технологийн ачаар эдүгээ олон түмний хоёр урсгалт мэдээллийн солилцоо хөгжих боломж нэмэгдэж байгаа билээ. Энэ бүхэн нь харилцан ойлголцол, хүлээцтэй байдлыг хөхүүлэн дэмжиж буй юм. Одоогоор ноёрхож буй арилжааны мэдээллийн хэрэгслийн тогтолцоонд зар сурталчилгаа нь орлогын үндсэн эх үүсвэр болж буй учир онцгой анхаарал татаж байна. Мэдээллийн хэрэгсэл ашигтай ажиллаж, тогтвортой хөгжихийн сацуу хараат бус байдлаа хэрхэн хадгалж, олон түмний дунд итгэл үнэмшилтэй байх вэ? Энэхүү сэдвийг альтернатив мэдээллийн хэрэгслийн талаар, ялангуяа орон нутгийн түвшинд ажиллаж буй цомхон мэдээллийн хэрэгслийн ирээдүйн талаарх өөдрөг хэлэлцүүлгээр өндөрлөж буй юм. Ач холбогдлын хувьд улам бүр өсөн нэмэгдэж буй цаг үеийн мэдээллийн хэрэгслийн асуудлыг ч энд мөн хөндөх бөгөөд тухайлбал цахим мэдээний сайтуудын бий болгож буй шинэ сонголтын талаар ярилцах юм. Иргэдийн мэдээллийн хэрэгслийн

хувьд эдгээрийг сургууль, ажлын байр, жижиг суурин газар хөгжүүлж болох бөгөөд энэ нь мөн мэдээллийн томоохон байгууллагуудыг бодвол альтернатив сонголт болоод байна. Эдгээр “жижиг” мэдээллийн хэрэгсэл нь иргэдийн мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлж, тэдний дуу хоолойг сонгох боломжийг бүрдүүлж байгаа билээ.

1-Р ХЭСЭГ:

ӨНӨӨГИЙН ДАЯАРШСАН ТОСГОН ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ЭЗЭМШЛИЙН АСУУДАЛ

- Дэлхийн эдийн засаг, e-бизнес, хэвлэл мэдээллийн эзэмшлийн асуудал
- Мэдээллийн харилцааны хэв маяг, мэдээллийн хэрэгслийн эзэмшил, хяналтын асуудал
- Хувийн (арилжааны) мэдээллийн хэрэгсэл, төрийн эзэмшлийн, төрийн хяналтад байдаг мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, жишээлбэл олон нийтийн телевизийн тогтолцоо
- Иргэдийн мэдээллийн хэрэгсэл

Технологийн уусан нэгдэх үйл явц (мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбоо болон компьютер) болон хэвлэл мэдээллийн конгломерат бий болох үйл явц
- Олон ургальч байдал ба төвлөрөл (мэдээллийн хэрэгслийн сүлжээ, олон төрлийн мэдээллийн хэрэгслийг нэг байгууллага буюу хувь хүн эзэмших явдал)
- Мэдээллийн байгууллагыг худалдаж авах, нэгтгэх, хамтран эзэмших болон хэвлэл мэдээллийн консорциум байгуулах
- Олон улсын хэмжээний мэдээллийн хэрэгсэл буюу хэвлэл мэдээллийн корпораци
- Хэвлэл мэдээллийн эзэмшлийг зохицуулах олон улсын болон үндэсний хууль журам
- Шударга өрсөлдөөний тухай хууль журам
- Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах нь
- Зохицуулалтын бусад арга механизм болон бодлого
- Хэвлэл мэдээллийн эзэмшил харъяалал, агуулга, хөтөлбөр
- Гадаадын болон өөрийн нэвтрүүлэг / агуулга ign content vs. local content
- Ацаглаа (outsourcing), гадаад болон дотоод ацаглаа (offshoring, home sourcing)
- Редакцийн хараат бус байдал болон эзэмшигчийн ашиг сонирхлын зөрчил

2-Р ХЭСЭГ:

**ДАЯАРШСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН НИЙГЭМ,
СОЁЛ, УЛС ТӨРИЙН ОРЧИН**

- Даяаршсан мэдээллийн хэрэгслийн нийгэм соёлын орчин
 - Мэдээллийн хэрэгсэл ба нийтийн соёл
 - Соёлын хэвшмэл ойлголт, урьдчилсан дүгнэлт болон өрөөсгөл хандлага
 - Соёлын уусан нэгдэх аюулын тухай ойлголт
 - Соёлын олон янз ба олон ургальч байдлыг хөхүүлэн дэмжих амлалт
 - Мэдээллийн хэрэгсэл ба соёлын хүлээцтэй байдал, харилцан ойлголцол ба иргэншил
 - Мэдээллийн хэрэгслийн улс төрийн нөлөө
 - Хоёр чиглэл бүхий мэдээллийн ургсалыг хөгжүүлэх арга замыг бий болгох (жишээлбэл хойд зүгээс өмнө зүгт, өмнөдөөс өмнөд рүү)
 - Мэдээллийн хэрэгсэл олон нийтийн орон зайг өргөжүүлэх индэр болох нь
 - Мэдээллийн хэрэгсэл улс төр, нийгмийн хүчинг идэвхжүүлэх хэрэгсэл болох нь
 - Мэдээллийн хэрэгслийн олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх чадал ба улс төрийн бодлого
 - Ил тод, хариуцлагатай байдлаар сайн засаглалыг дэмжих нь
 - Мэдээллийн хэрэгсэл ба шилжин суурьшигчид
 - Даяаршсан мэдээллийн хэрэгсэл болон шинэ технологи шилжин суурьшсан иргэдийн шаардлага хэрэгцээг хангаж буй байдал
 - Шилжин суурьшсан иргэд, цагаачлагчдын мэдээллийн сувгийн талаарх кейс судалгаа

87

3-Р ХЭСЭГ:

МЭДЭЭЛЛИЙН АРИЛЖААНЫ ЧИГ ХАНДЛАГА

- Мэдээлэл нийгмийн бүтээгдэхүүн болон бараа болох нь;
- Сурталчилгаа арилжааны мэдээллийн хэрэгслийн амин судас болох нь;
- Рейтинг болон борлуулалтын тоо мэдээллийн хэрэгслийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэмжих хэмжүүр болох нь;

- Арилжааны болон хэрэглээний соёлын аюул (ашигтай болон хэрэгтэй агуулгын тэнцвэр);

Мэдээллийг бараа таваар болгох арга стратеги;

Олон нийтийн салбарын мэдээлэл ба оюуны өмчийн эрхийн асуудал

Хуулбарлан ашиглах эрх болон мэдээллийн өмчлөлтэй холбоотой бусад эрх

Олон нийтийн салбарын мэдээлэл

Нээлттэй эх сурвалжийн болон компьютерийн үнэ төлбөргүй программ хангамж (Криэтив Коммонс).

4-р хэсэг:

АЛЬТЕРНАТИВ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ӨСӨЛТ

Альтернатив мэдээллийн хэрэгсэл яагаад бий болсон бэ

Мэдээллийн үндсэн хэрэгсэлд итгэх олон түмний итгэл үнэмшил

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил

Хэрэглэгчийн өөрчлөгдөж буй хэвшил болон хэрэгцээ сонирхол

Альтернатив мэдээллийн хэрэгслийг тодорхойлох нь (мэдээллийн үндсэн хэрэгслээс ялгаатай зүйлс)

Альтернатив мэдээллийн хэрэгслийн өмчлөл ба хяналт (өмчлөл, хяналтыг ардчилахуй)

Альтернатив мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчид: төрөл бүрийн салбар (эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, ажилчид гэх мэт), нийгмийн цөөнх бүлгүүд (соёл уламжлалын хэсэг бүлэг, цагаачид) гэх зэрэг.

Альтернатив мэдээллийн хэрэгслийн агуулга (жишээлбэл нутгийн иргэдийн болон тодорхой салбарын хөгжлийн асуудлууд)

Альтернатив мэдээллийн хэрэгсэл дэх сэтгүүлзүйн үйл явц (нутгийн иргэдийн байр суурь, оролцооны болон интерактив арга барил)

Альтернатив мэдээллийн хэрэгслийн нийгэмд гүйцэтгэх үүрэг (ил тод байдал, олон ургальч байдал, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэх мэт)

Альтернатив мэдээллийн хэрэгслийн төлөвлөлт, зохион байгуулалт, тогтвортой үйл ажиллагаа

Сургуулийн орчин дахь альтернатив мэдээллийн хэрэгсэл

Нутгийн иргэд ба альтернатив мэдээллийн хэрэгсэл

Альтернатив мэдээллийн хэрэгслийн орлогын хэлбэр



СЭДЭВ 3,5 ДУГААР ХЭСЭГ: КОМПЬЮТЕРИЙН ТУСЛАМЖТАЙГААР ДҮРС ЗАСВАРЛАХ НЬ

90

- Видео болон хөдөлгөөнгүй дүрсийг засварлахад шаардлагатай техник хэрэгсэл болон компьютерийн програм хангамжийг олж ашиглах нь
- Загварын ертөнцөд болон сэтгүүлзүйд дээр дурдсан техник хэрэгслийг ашиглаж буйн жишээ
- Эдгээр техник хэрэгслийг ашиглахтай холбоотой давуу тал болон хариуцлага
- Эдгээр техник хэрэгсэл нь фото сэтгүүлзүй, хувь хүний үнэн бодит мэдээлэлд нэвтрэх чадвартай холбоо бүхий итгэл үнэмшилд нөлөөлж буй байдал



СЭДЭВ 4, 4 ДҮГЭЭР ХЭСЭГ:

УТГА АГУУЛГЫГ БҮТЭЭХ ЗОРИЛГООР ДҮРС, ЗУРАГ
АВАЛТЫН ӨНЦГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

- Зураг авалтын өнцөг, хэлбэрийг задлан шинжихүй
- Камертай харьцах ажлын товч жагсаалт



СЭДЭВ 5, 5 ДУГААР ХЭСЭГ: УЛС ҮНДЭСТЭН ХООРОНДЫН ЗАР СУРТАЛЧИЛГАА БА СУПЕР БРЭНД

92

- Супер брэндийн уриалга
- Супер брэндийг бий болгоход ашигладаг арга барил
- Бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор тодорхой санааг зорилтот хэрэглэгчид хүргэх арга техникийн үр дүн
- Дэлхий дахинаа түгээдэг сурталчилгааны үндсэн сэдэв ба санаа

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Ардчилал	Иргэд шууд болон шууд бусаар буюу чөлөөт сонгуулийн тогтолцоогоор сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан эрх мэдлийг хэрэгжүүлдэг засаглалын тогтолцоо. Үүнд мөн хувь хүн амьдралынхаа талаарх шийдвэрийг гаргахдаа сонголт хийх эрхтэй байх, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах явдал багтана.
Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах	Арьсны өнгийг бий болгодог удмын шинж чанар нь хүний мөн чанар, чадавхыг тодорхойлдог бөгөөд арьсны ялгавартай байдал нь зарим үндэстэнд төрөлхийн давуу чанарыг олгодог хэмээн үзэх үзэл суртал.
Блог	Ихэвчлэн нэг хүн ажиллуулж, үйл явдлын тойм, тайлбар, зураг, дүрс зэргийг байршуулдаг цахим хуудас. Тухайн хуудас дээр бусад хүн санал бодлоо бичиж үлдээх боломжтой боловч блогийг засварлах цорын ганц эрхтэй хүн нь блогийн эзэн байна. Блогийг цахим сэтгүүл хэмээн нэрлэх нь бий.
Веб 2.0	Хэрэглэгч идэвхтэйгээр ашиглаж, өөрийн програм хангамжийг өөрөө бүтээх боломжийг санал болгодог програм. Веб 2.0 нь хамтран ажиллах болон бусадтай хуваалцахын ач холбогдлыг тодотгож өгдөгөөрөө онцлог.
Веб хуудас	Нэг нэрийн дор буюу нэг хаягаар байрших цахим хуудас, дүрс, мэдээллийн цуглуулга.
Гэйткийпер (Gate-keeper) буюу Хаалгач	Нийтэд түгээхэд зориулсан утга санаа, мэдээллийг шүүн ялгах үүрэг бүхий этгээдийг нэрлэх ерөнхий томъёо. Үүнд жишээлбэл тодорхой мэдээллийг нийтэд түгээх эсэхийг шийдэх редакцийн үйл явц хамаарна. Мэдээллийг шүүх буюу “хаалга манах” үйл ажиллагаа нь сурвалжлагч мэдээллийн эх сурвалжийг сонгохоос эхлээд редактор аль мэдээг нийтлэх тухай шийдвэр гаргах хүртэл мэдээллийн байгууллагын бүхий л шатанд явагддаг.
Даяаршсан тосгон	Энэхүү ухагдахууныг Маршал МакЛукан “Гутенбергийн эрин” хэмээх номондоо анх ашигласан. Уг томъёолол нь электрон мэдээллийн технологийн ачаар мэдээллийг хоромын дотор дэлхийн аль ч өнцөг булангаас нэгэн зэрэг дурын газарт хүргэх боломжтой болсноор дэлхий нэгэн жижиг тосгон болж хувирч буйг илэрхийлдэг. Сүүлд Интернэт болон дэлхийн мэдээллийн сүлжээг хүчээ авахад (www) энэхүү үзэгдлийг мөн хамаатуулах болсон юм.

Дүрслэл	Бодитоор гадуур оршиж буй хүн, газар нутаг, үйл явдал, санааг тодорхой зохион байгуулалт бүхий тэмдгийн тусламжтайгаар бэлэгдэн харуулах, тодорхойлох, төлөөлж дүрслэх явдал. Энэ нь мөн бодит газар, хүн, үйл явдал, санаа бодол болон мэдээллийн агуулгын хоорондох хамаарлыг тусгана.
Дүрст буюу дэлгэцийн мэдээллийн хэрэгсэл Ёсзүйн зарчим / Мэргэжлийн зарчим/	Дүрсээр утга агуулгыг дамжуулдаг мэдээллийг хэрэгсэл (жишээлбэл телевиз, кино, Интернет гэх мэт).
Олон ургальч байдлын зарчим	Сэтгүүлчид мэргэжлийн өндөр түвшинд ажиллахын тулд дагаж мөрдөх багц зарчим. Ийм зарчмыг тухайлбал Олон улсын сэтгүүлчдийн холбооноос баталсан байдаг. Одоогоор үйлчилж буй янз бүрийн ёс зүйн дүрэм өөр хоорондоо ялгаатай байдаг хэдий ч ихэнх нь үнэн бодит мэдээллийг эрхэмлэх, нягт нямбай ажиллах, аль нэг талд үйлчлэхгүй байх, шударга байх, олон түмний өмнө хариуцлага хүлээх зэрэг нийтлэг зарчимд тулгуурладаг.
Жанр/ төрөл зүйл	Мэдээллийн хэрэгслийн агуулгын тодорхой төрөл (жишээлбэл цэнгээнт, мэдээллийн, цаг үеийн шуурхай мэдээллийн, сурталчилгааны төрөл болон кино гэх мэт). Төрөл болгон өөрийн гэсэн зорилго, хэлбэртэй байна.
Засаглал	Албан байгууллага болон иргэний нийгмийн харилцан уялдаа бүхий засаглалын үйл явц. Засаглалын тухай ойлголтод эрх мэдэл, албан тушаал, нөлөөг хэн атгаж, тэдгээрийг хэрхэн ашиглаж, нийгэм, олон түмний амьдралд хамаарал бүхий бодлого, шийдвэрийг хэрхэн гаргаж буй явдал хамаарна. Засаглалд төрийн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаа болон хандлага хамаарна.
Зорилтот хэрэглэгч	Нас, хүйс, мэргэжил, нийгмийн гарал зэрэг тодорхой шинж чанарынх нь үндсэн дээр бүлэглэж, мэдээллийн хэрэгслийн тодорхой агуулгыг зориулан бэлтгэсэн хэсэг бүлэг хүн.
Зураг авалтын төлөвлөлт	Зураг авалтын дэс дарааллыг зураасан зургаар гаргах.
Идэвхтэй хэрэглэгч:	Хүмүүс мэдээллийн агуулгыг хүлээн авч, ойлгох үйл явцад тухайн хүний хувийн туршлага, мэдлэг, хандлага шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг учир янз бүрийн хүн ижил агуулгыг янз бүрээр ойлгож тайлбарладаг хэмээн үздэг онол.
Иргэн хүн, иргэний эрх үүрэг (идэвхтэй)	Улс төр, нийгэм, үндэстний тодорхой хүрээллийн гишүүн. Иргэний эрх үүрэгт санал өгөх, нийгмийн баялгийг хүртэх эрх, оролцооны үүрэг зэрэг иргэн хүний багц эрх, үүргийг хамруулдаг. Идэвхтэй иргэн гэж эдийн засаг, олон нийтийн амьдрал, сайн дурын ажил гэх мэтэд иргэд идэвхтэй оролцож, өөрийнхөө болон бусдын амьдралыг дээшлүүлэх үүрэгтэй хэмээн үздэг философи.

Иргэний сэтгүүлзүй	Хүмүүс цахим мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар мэдээллийн харилцаанд оролцож, өөрийн мэдээлэл, үзэл бодол, тайлбарыг нийтлэх замаар бусад мэдээллийн агуулга, хэлбэрт нөлөөлөх үйл ажиллагаа.
Интернэт	Интернэт Протокол Сьют (TCP/IP)-ийн тусламжтайгаар дэлхий дахинаа тэрбум тэрбум хүнд үйлчилдэг, өөр хоорондоо холбоо бүхий компьютерийн сүлжээ. Энэ нь орон нутгийнхаас эхлээд олон улсын сая сая хувийн, олон нийтийн, эрдэм шинжилгээний, бизнесийн болон засгийн газрын сүлжээнээс бүрдсэн сүлжээний сүлжээ бөгөөд бүгд өөр хоорондоо цахилгаан болон шилэн кабелийн технологиор холбогдсон байдаг.
Иргэдийн мэдээллийн хэрэгсэл	Газар зүйн байршил, эсвэл сонирхлоороо нэгдмэл шинж чанар бүхий хэсэг бүлэг хүн үүсгэн байгуулж, өөрсдөө хянадаг мэдээллийн хэрэгсэл. Иргэдийн мэдээллийн хэрэгсэл нь хувийн (арилжааны), төрийн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээс ялгаатай бөгөөд ардчилсан хэвлэл мэдээллийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг нь мөн хэмээн хүлээн зөвшөөрөгдөөд байгаа билээ.
Кино	Дуу, дүрсний дэс дарааллаар үргэлжилсэн хөдөлгөөний төсөөллийг бий болгож, ингэснээр тодорхой түүхийг илэрхийлэх зугаацуулан цэнгүүлэх урлагийн нэг хэлбэр.
Компьютерийн програм хангамж	Төрөл бүрийн мэдээлэл, үйл ажиллагааг хэрхэх тухай үүргийг компьютерт өгдөг үйлдлийн хөтөлбөр буюу програм. Мэдээллийг бэлтгэж, өөрчлөн засварладаг офисын програмаас эхсүүлээд дүрсний хэлбэрийг хянаж, засварлан бүтээдэг бусад програм зэргийг жишээ болгон дурьдаж болно.
Маркетинг	Аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэрэглэгчийн сонирхлыг төрүүлэх үйл ажиллагаа. Маркетингийн үр дүнд борлуулалтын арга барил, бизнесийн мэдээллийн харилцаа болон бизнесийн хөгжлийн стратеги бий болдог.
Мультимедиа	Хэд хэдэн мэдээллийн хэрэгслийг ялангуяа боловсрол болон зугаа цэнгээний зориулалтаар нэгэн зэрэг ашиглах боломж. Үүгээр мөн текст, дуу, бүрэн болон хэсэгчилсэн дүрс зэргийг цахим хэлбэрээр нэгтгэхийг илэрхийлж болно.
Муу засаглал	Өрөөсгөл бөгөөд үндэслэлгүй бодлого, хариуцлагагүй хүнд суртал, хэрэгждэггүй хууль, шударга бус шүүх үйл ажиллагаа, гүйцэтгэх эрх мэдлийг хэтрүүлэн ашиглах, идэвхгүй иргэний нийгэм зэрэг нь муу засаглалд хамаарна.

МХМСБ	МХМСБ нь “мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсрол” хэмээх нэр томъёоны товчлол бөгөөд иргэд мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бусад сувгуудтай үр дүнтэйгээр харьцах, шүүмжлэлт сэтгэлгээ болон насан туршийн сурах чадварт суралцаж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцогч иргэн болж төлөвшихөд шаардлагатай үндсэн мэдлэг, чадвар, хандлагыг хэлнэ.
Мэдлэг	Мэдээлэл олж авсан буюу сурч мэдсэн нөхцөл байдал.
Мэдээ	Гуравдагч этгээдэд, эсвэл олон түмэнд хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл, Интернэт болон ам дамжсан яриагаар дамжуулсан цаг үеийн үйл явдлын мэдээлэл.
Мэдээллийн суурь боловсрол	Мэдээллийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хэрэгтэй мэдээллийг олж, үнэлэн дүгнэж, үр дүнтэйгээр ашиглах болон янз бүрийн хэлбэрээр бусдад дамжуулах чадвар.
Мэдээллийн хэрэглэгч	Мэдээллийн хэрэгслийн агуулгыг зориулан бүтээсэн, мөн тэрхүү агуулгыг хүртсэн хэн бүхэн.
Мэдээллийн үйлдвэрлэл	Мэдээллийг боловсруулж, мэдээллийн хэрэгслээр түгээх эцсийн бүтээгдэхүүнийг бэлтгэх үйл явц. Мэдээллийн бичвэр бэлтгэх болон мэдээллийг бүтээхэд оролцож буй хүмүүсийг аль алиныг нь хамруулж хэрэглэдэг.
Мэдээллийн үндсэн хэрэгсэл	Хамгийн түгээмэл сувгийг ашиглаж мэдээллийг олон түмэнд хүргэдэг, хэрэглэгчдийн дийлэнхийн хүлээлт болон сонирхолд үйлчилдэг хэрэгсэл. Эдгээр мэдээллийн хэрэгсэл нь тухайн зах зээлийн дийлэнх хэрэглэгчийн хэрэгцээ, төлөв байдлыг илэрхийлж байдаг хэмээн үздэг.
Мэдээллийн харилцаа / коммуникаци/	Мэдээллийг тодорхой хэлбэрт оруулж, хэрэглэгчид зориулан тодорхой суваг, хэрэгслийн тусламжтайгаар дамжуулах үйл явц. Мэдээллийн харилцааны бүхий л хэлбэрт мэдээллийг илгээгч, мэдээлэл болон зорилтот хүлээн авагч оролцдог. Гэхдээ хүлээн авагч нь мэдээллийн харилцааны оролцогч болохын тулд мэдээллийг илгээх мөчид тухайн газар биеэр байх албагүй бөгөөд мэдээлэл илгээгчийн зорилгыг заавал мэдэх албагүй.
Мэдээллийн хэрэгслийн зохицуулалт	Мэдээллийн байгууллага болон мэдээлэл бүтээж, түгээдэг этгээдийг хянах, тэдний үйл ажиллагаанд нөлөөлөх зорилгоор тодорхой дүрэм, мөрдвөл зохих зарчим зэргийг боловсруулж, хэрэгжүүлэх оролдлого.

Мэдээллийн хэрэгслийн суурь боловсрол

Олон түмний мэдээллийн хэрэгслийг ойлгож, өөрийгөө илэрхийлэх болон мэдээлэл хүлээн авах зорилгоор ашиглах явдал. Үүнд мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн ашигладаг арга техник болон үр дүнд мэдлэгтэй бөгөөд шүүмжлэлтэйгээр хандах, төрөл бүрийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээллийн харилцаанд оролцох, мэдээллийг унших, задлан шинжлэх, үнэлэн дүгнэх чадвар багтана.

Мэдээллийн хэрэгслийн хэл

Мэдээллийн хэрэгслээр дамжуулах утга санааг бүрэлдүүлж буй дүрэм, хэлбэр, бэлэгдлийн тэмдэг, бүтэц найруулга. Ерөнхийдөө электрон мэдээллийн хэрэгслийн ашиглаж буй бэлэгдлийн хэл нь хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн хэлэнд ашигладаг зөв бичих дүрэмтэй ижил төстэй байдаг.

Мэдээллийн хэрэгсэл

Радио, телевиз, компьютер, кино зэрэг мэдээллийг дамжуулах буюу солилцоход ашигладаг биет объект. Мэдээллийн хэрэгсэл гэж мөн итгэл үнэмшил бүхий мэдээллийн эх сурвалжийг хэлэх бөгөөд тэрхүү мэдээллийг сэтгүүлзүйн үнэт зүйлсэд тулгуурлах редакцийн үйл явцад бүтээдэг бөгөөд улмаар агуулгын төлөөх хариуцлагыг тухайн мэдээллийг бүтээсэн хуулийн этгээдэд хүлээлгэж болдог. Сүүлийн жилүүдэд мэдээллийн хэрэгсэлд шинээр хөгжиж буй цахим хэрэгслийг мөн багтааж байна.

Мэдээллийн шинэ хэрэгсэл

Цахим сувгаар бэлтгэгдэн түгээгдэж буй агуулга

Мэдээллийн эрх чөлөө

Төрийн этгээдээс мэдээлэл авах иргэний эрх

Мэдээллийн эх сурвалж

Мэдээллийн эх үүсвэр болсон хүн, хэсэг бүлэг, баримт бичиг зэргийг хэлнэ.

Мэдээлэл

Бүх төрлийн өгөгдөл, өөрийн болон бусдын туршлага, заах болон суралцах үйл явцад олж авсан мэдлэг, дохио, тэмдэг зэргийг нэгтгэсэн өргөн ойлголт. Хэвлэл мэдээллийн салбарт тодорхой үйл явдал, нөхцөл байдлын талаар бусдаас хүлээн авсан, эсвэл өөрөө цуглуулсан мэдлэгийг мэдээлэл хэмээн тодорхойлох нь бий.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи буюу ICT

Мэдээлэл, харилцаа холбооны технологид мэдээлэлтэй харьцаж, мэдээллийн харилцааг хэрэгжүүлэхэд ашигладаг бүх төрлийн техник хэрэгслийг хамруулах бөгөөд үүнд жишээлбэл компьютер, сүлжээний техник болон холбогдох програм хангамж орж болно. Өөрөөр хэлбэл ICT-д мэдээллийн технологи болон утас, өргөн нэвтрүүлгийн байгууллага, бүх төрлийн аудио болон видео бичлэг үйлдэх, боловсруулах болон түгээх хэрэгсэл багтана.

Мэдээний үнэ цэнэ	Зарим үед мэдээний шалгуур гэж ч нэрлэдэг бөгөөд тодорхой мэдээлэлд мэдээллийн хэрэгсэл ямар ач холбогдол өгч, хэрэглэгчийн анхаарлыг хэр их татах магадлалыг тодорхойлдог. Хамгийн өндөр ач холбогдол бүхий мэдээний шалгуурт гэнэтийн болон шинэлэг байдал, утга учир, зөрчил зэрэг багтдаг.
Насан туршийн сурах үйл явц	Шавь төвтэй боловсролын үзэл санаатай холбоотой. Тодорхой цаг хугацаа, орон зайд болж өнгөрсөн сургалт, хөтөлбөр дууссаны дараа амьдрал эхэлж, эсвэл дуусдаггүй. Хувь хүн бүр байнга суралцаж байдаг бөгөөд энэхүү сурах үйл явцыг тогтвортой үргэлжлүүлэхэд мэдээллийн болон мэдээлэл харилцааны технологи чухал үүрэг гүйцэтгэж байна. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролыг эзэмших үйл явц тодорхой сургалт хөтөлбөрөөс хальж, албан бус орчинд, тухайлбал ажлын байр, олон нийтийн үйл ажиллагаа, албан бус боловсролын тогтолцоо зэрэгт үргэлжилж байдаг гэсэн санааг “насан туршийн сурах үйл явц” хэмээн ухагдахуунаар илэрхийлж байна .
Нийгмийн сүлжээг ашиглах	Хамтын ашиг сонирхол эсвэл үйл ажиллагаагаараа ижил төстэй хүмүүсийн сүлжээнд цахим аргаар холбогдох. Нийгмийн сүлжээний үйл ажиллагаа гэдэг нь хүмүүс өөрийнхөө тухай буюу өөртэйгээ холбоотой мэдээллийг Интернэтэд байршуулахыг хэлнэ. Жишээлбэл Facebook бол маш түгээмэл нийгмийн сүлжээ юм.
Нийгмийн хэлэлцүүлэг Нийтийн орон зайн мэдээлэл	Амаар болон бичгээр илэрхийлсэн тодорхой сэдэв, асуудлыг дэлгэрэнгүй хэлэлцэх үйл явц. Яруу найраг, дуу хөгжим, урлаг, ном хэвлэл, кино, загвар зохион бүтээх болон оюуны өмчийн бусад хэлбэр, тухайлбал компьютерийн програм зэрэг бүтээлч ажлын үр дүн буюу уран бүтээлд хамаатуулан хэрэглэдэг нэр томъёо. Нийтийн орон зайд байна гэдэг нь тухайн хүний бүтээлч хөдөлмөрийн үр дүнг хэрэглэгч хүссэн зорилго, хэлбэрээрээ ашиглахыг хэлнэ. Нийтийн орон зайн бүтээгдэхүүнийг ерөнхийд нь хамтын соёлын өв гэж үзэх бөгөөд өөрөөр хэлбэл хувь хүний өмч байхаас ялгаатай.
Нийтийн соёл	Тодорхой нийгмийн олонхи нь албан бусаар хүлээн зөвшөөрч буй үзэл санаа, хандлага, сэдэв, асуудал, дүрс, дүрслэл болон бусад үзэгдэл. Анх ялангуяа 20 дугаар зууны эхэн болон дунд үед түгэж байсан Барууны соёл, мөн 20 дугаар зууны төгсгөл, 21 дүгээр зууны эхэн үеийн даяаршсан соёлын урсгалтай холбож энэ нэр томъёог ашигладаг.

Олон нийтийн ашиг сонирхол	Өрөөсгөл ашиг сонирхол буюу хувь хүн болон хэсэг бүлэг хүний сонирхолд бус, бүх нийтийн сайн сайханд ашиг тустай байх тухай ойлголт. Олон нийтийн ашиг сонирхол чухам юунаас бүрдэх тухай нэгдмэл ойлголт байдаггүй боловч зарим зүйл хэн нэгний нийгмийн гарал, байр сууриас үл хамаарч хүн бүрийн сонирхолд нийцэх тул тухайн зүйлийг зайлшгүй хамгаалах шаардлагатай байдаг гэсэн үзэл санааг илэрхийлнэ.
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	Олон нийтээс санхүүжиж, тэнцвэртэй, олон ургальч хөтөлбөрөөр олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх үүрэг бүхий мэдээллийн хэрэгсэл.
Олон нийтийн хүрээ (Public sphere)	Нийгмийн гишүүд мэдээ, мэдээлэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, нийтэд хамаарал бүхий асуудлаар байр сууриа эрх тэгш илэрхийлж, харилцан ярилцах буюу мэтгэлцэх боломж бүхий олон нийтийн орон зай. Олон нийтийн орон зай буюу хүрээний тухай онолын үндэслэгчдээс хамгийн нэр нөлөө бүхий нь Юрген Хаберма юм.
Олон нийтэд үйлчлэх зар сурталчилгаа	Тодорхой бараа бүтээгдэхүүнийг сурталчлах бус, олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх зорилго бүхий сурталчилгааны төрөл.
Олон түмний мэдээллийн хэрэгсэл	Технологийн тусламжтайгаар маш өргөн хүрээний хэрэглэгчид үйлчилдэг мэдээллийн хэрэгсэл. Олон түмний мэдээллийн хэрэгсэл нь утга санааг дамжуулдаг мэдээллийн харилцааны суваг мөн.
Олон ургальч байдал	Ялгаатай байдлыг хүндэтгэж, эерэгээр хүлээн авах үзэл санаа. Ардчилсан нийгэм болон тогтолцоонд олон ургальч байдлыг хүний эрхийн бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж хамгаалдаг.
Олон ургальч байдал (мэдээллийн хэрэгслийн олон ургальч байдал)	Өмчлөлийн хэлбэр (хувийн, олон нийтийн, иргэдийн гэх мэт) болон төрөл зүйлийн хувьд (хэвлэмэл, радио, телевиз, Интернэт гэх мэт) олон янзын мэдээллийн хэрэгслийн тогтолцоо. Өргөн утгаараа нийгэм дэх олон ургальч байдал нь гарал угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, нийгмийн гарал зэрэг нэгдмэл шинж чанар бүхий янз бүрийн хэсэг бүлгийн гишүүн бүр өөрийн сонирхол, соёл, уламжлалыг хэрэгжүүлж, хөгжүүлэхдээ ижил тэгш бөгөөд хараат бус байх тухай үзэл санаагаар илэрхийлэгддэг.
Оролцоо (иргэний оролцоо)	Иргэн хүн нийгмийн болон өөрийн амьдрал, ирээдүйтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад оролцох нь өөрийн гэсэн байр суурьтай байж, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах үндэс суурь нь учир ардчиллын амин сүнс мөн. Энэ нь ардчиллыг хэрэгжүүлэх чухал элемент бөгөөд шийдвэр гаргах үйл явцын хөдөлгөх хүчин, хүний эрхийн үндэс суурь юм.
Орчин нөхцлийн шинжилгээ	МХМСБ-ын хичээлийг заахад ашигладаг арга барил бөгөөд тухайн мэдээллийн техник орчин, нөхцөл байдлыг задлан шинжлэх үйл явцыг хэлнэ.

Орчин нөхцөл / контекст	Мэдээллийн хэрэгслийн агуулгыг тодорхойлж буй, тухайн мэдээллийн эргэн тойрон дахь бодит нөхцөл байдал.
Оюуны өмчийн эрх / хуулбарлан ашиглах эрх	Тодорхой бүтээлийг хуулбарлах, дахин түгээх, өөрчлөх зэрэг эрхийг хязгаарлах зорилгоор тухайн бүтээлийн эзэн буюу зохиогчид олгосон багц эрх. Энэхүү эрхийг тухайн бүтээлийн эзэн нь гэхээсээ илүү санхүүжүүлэгч нь эдлэх явдал түгээмэл байдаг бөгөөд худалдаж, худалдан авч болдог.
Өгүүлэл / зохиол	Ямар нэгэн түүхийг үйл явдлын дэс дарааллын тусламжтайгаар өгүүлэх. Мэдээллийн хэрэгслийн хувьд энэ нь тодорхой цаг хугацаа, орон зайд болж өнгөрөх үйл явдлын логик дэс дараалал байна.
Өөрийн зохицуулалт	Тухайн салбарт ажиллаж буй хүмүүсийн өөрсдийн боловсруулж шийдвэрлэсэн дүрэм журам. Хэвлэл мэдээллийн салбарын хувьд өөрийн зохицуулалт гэдэг нь ёс зүйн болон мэргэжлийн дүрмийг төрийн эрх барих болон бусад байгууллагын хөндлөнгийн нөлөөгүйгээр дагаж мөрдөхийг хэлнэ.
Подкаст	Тогтмол давтамжтайгаар нийтийн хүртээл болдог, компьютер, гар утас зэргээр хүлээн авах боломжтой дуу, дүрс бүхий файлууд.
Радио	Цахилгаан соронзон долгионоор шифрлэсэн, сонсох боломжтой дохиог олон түмэнд дамжуулдаг өргөн нэвтрүүлгийн байгууллага.
Редактор	Сонин, сэтгүүл зэрэг хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн редакцийн буюу сэтгүүлзүйн хэсгийг хариуцаж, бичвэрийн эцсийн агуулгыг шийдэх эрх мэдэлтэй хүн. Энэхүү нэр томъёог хэвлэл мэдээллийн эзний тухай ойлголтоос ялгаж салгах нь чухал. Мэдээллийн хэрэгслийн эзэн гэдэг бол тухайн хэрэгслийг өмчилж буй нэг болон хэсэг бүлэг хүн мөн.
Редакцийн хараат бус байдал	Редакцийн шийдвэрийг мэдээллийн хэрэгслийн эзэн, төрийн болон төрийн бус бусад этгээдийн хөндлөнгийн нөлөөллөөс ангид, бие даан хараат бусаар гаргах мэргэжлийн эрх, эрх чөлөө. Бодлого боловсруулах нээлттэй, урьдчилан харж болохуйц, дэвшилтэт үйл явц, хүнд суртлыг шахан зайлуулж олон нийтийн эрх ашигт үйлчлэх мэргэжлийн соёл, хуульт ёс, ил тод байдал болон олон нийтийн асуудалд оролцдог хүчтэй иргэний нийгэм зэргээр сайн засаглалыг томъёолно.
Сайн засаглал	Хэсэг бүлэг хүний хандлагыг тодорхой чиглэлд өөрчлөх зорилго бүхий мэдээллийн харилцаа.
Суртал ухуулга Сургалтын хөтөлбөр	Тодорхой дэс дараалалтайгаар мэдлэг олгох зорилго бүхий агуулгаас бүрдэх хичээлүүдийн багц

Сексизм	Хүйсээр ялгаварлан гадуурхах буюу урьдчилан дүгнэх. Ялангуяа эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргийг хүйсийнх нь үүднээс ялгавартайгаар тодорхойлох явдал, эмэгтэйчүүдийг ялгаварлах хувийн дүгнэлт, төсөөлөлд суурилсан хандлага, үйлдлийг хэлнэ.
Символизм	Бэлэгдлийн дүрс, дүрслэл, ойлголт ухагдахуун зэргийг ашиглаж бодит ертөнцийн зарим талыг төлөөлүүлэн харуулах (жишээлбэл муу ковбойг хар малгайтай, сайныг нь цагаан малгайтай дүрслэх гэх мэт).
Соёл	Уламжлан дамжиж, өвлөж болон суралцаж авсан, хамтаар бүтээж, хуваалцдаг үнэт зүйл, итгэл үнэмшил, хандлагыг бэлэгдэх тогтолцоо. Энэхүү тогтолцоо нь үзэл бодол, зан үйл, үйлдлийг бий болгож буй абстракт дүрэм буюу сэтгэлгээний код юм. Үүнд мөн хүмүүний мэдлэг, итгэл үнэмшил, зан үйлийн нэгдсэн тогтолцоо хамаарах бөгөөд энэ нь нийгмийн суралцах үйл явц, бэлэгдлээр сэтгэн бодох чадвараас хамаарна.
Сонин	Мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа бүхий, урьдчилан төлөвлөж тогтмол хэвлэгддэг хэвлэмэл бүтээгдэхүүн. Ихэвчлэн хямд төсөр нимгэн цаасан дээр хэвлэгддэг.
Сонсож сурах	Харж сурах, хийж буюу мэдэрч сурах, сонсож сурах гэсэн сурах гурван төрлийн нэг нь. Сонсож сурах үйл явцыг зарим үед харж сурах болон хийнгээ сурах арга техниктэй хослуулан ашигладаг.
Сурталчилгаа	Хэрэглэгчийн анхаарлыг татаж, тодорхой бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад нөлөөлөх зорилго бүхий цогц арга техник, үйл ажиллагааг хэлнэ.
Сэтгүүлзүй	Мэдээллийг мэргэжлийн шалгуур, зарчмын дагуу судалж, цуглуулж, бичиж, хянаж, сонин, сэтгүүл, радио, телевиз, Интернэт зэрэг мэдээллийн хэрэгслээр түгээх үйл явц.
Сэтгүүлч	Цаг үеийн үйл явдал, хүмүүс, чиг хандлага, нөхцөл байдлын талаарх мэдээллийг тодорхой шалгуурын дагуу судалж, цуглуулж, нягтлан шалгаж, бичиж, түгээдэг хүн. Түүний ажлыг сэтгүүлзүй хэмээн нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг.
Текст	Мэдээллийн хэрэгслийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болох бичмэл, видео, эсвэл аудио нэгж бүтээгдэхүүн (жишээлбэл Телевизийн нэвтрүүлэг, ном, сонин сэтгүүлийн дугаар гэх мэт).
Телевиз	Цахилгаан болон цахилгаан соронзон долгионоор хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй дүрс, дуу авиаг дамжуулах үйл явц; тэдгээр дуу авиа болон дүрсний агуулга; мөн дуу дүрсний тусламжтайгаар телевизийн нэвтрүүлэг бэлтгэж түгээдэг байгууллагууд.

Технологи (мэдээллийн)	Мэдээллийн хэрэгслийг ашиглах, бүтээхэд шаардлагатай техник хэрэгсэл, эд анги (радио, компьютер, утас, сателлитан антен, хэвлэх машин гэх мэт).
Үг хэлэх эрх чөлөө	Аливаа цензур, хязгаарлалтгүйгээр үг хэлэх эрх чөлөө. Зарим үед үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хэмээх нэр томъёог (freedom of expression) ижил утгаар ашиглахдаа мөн мэдээлэл хайх, хүлээн авах, аливаа арга хэрэгслээр бусдад дамжуулах эрхийг хамаатуулдаг.
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	Хүний үндсэн эрх. Энэхүү эрхэд зөвхөн үгээр буюу аман хэлээр өөрийгөө илэрхийлэх эрх төдийгүй мэдээлэл хайх, хүлээн авах болон бусдад дамжуулах эрх хамаардаг. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө бол энэхүү эрхээс урган гарах эрх чөлөө бөгөөд иргэний нийгэм, иргэдийн оролцоонд тулгуурласан нийгмийг бүтээхэд амин чухал ач холбогдолтой.
Үзэл суртал / Идеологи	Хувь хүн, хэсэг бүлэгт хамаарах үзэл бодол, бодлого, итгэл үнэмшил болон зарчмын цогцолбор. Ерөнхийд нь өргөн хүрээний алсын зорилго, юмсыг харах хандлага, эсвэл зонхилох ангиас буюу хэсэг бүлгээс нийгмийн бусад гишүүдэд санал болгож буй үзэл санаа хэмээн тодорхойлж болно.
Үзэн ядалтыг сурталчлах	Нийгэм дэх тодорхой шинж чанар бүхий (гарал үүсэл, хүйс, сексийн хандлага гэх мэт) хэсэг бүлгийг үзэн ядах утга санааг агуулсан аливаа мэдээллийн харилцааг хэлнэ.
Уики /Wiki	Нэгээс илүү тооны хүн ажиллуулдаг цахим хуудас. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид тухайн сайтын агуулгыг хамтран бүтээдэг. Ихэнх тохиолдолд энэ нь өөр хоорондоо холбоо бүхий агуулга болон хуудсаас бүрдэх бөгөөд санал бодол, үйл явдлын тухай мэдээлэл, баримт бичиг зэргийг агуулдаг. Уикигийн агуулгыг олон хэрэглэгч шинэчлэн засварлах боломжтойгоос гадна илүү олон төрлийн өргөн хүрээний материалыг байршуулах боломжтойгоороо блоогоос ялгаатай байдаг.
Уусан нэгдэх /convergence/	Дуу, дүрс, бичвэр, цахим код зэрэг төрөл бүрийн мэдээллийн хэлбэрийг өөрчилж компьютер, үүрэн телефон зэрэг олон төрлийн хэрэгслээр хүлээн авах боломжтой болгож, цахим мэдээллийн харилцааны орчинг бий болгохыг хэлнэ.
Хаах буюу блоклох	Тодорхой цахим мэдээллийн хаягийг (URL) техник аргаар хаах замаар тухайн мэдээлэлд нэвтрэх боломжгүй болгох.
Харж суралцах	Үзүүлбэр, жишээг харж суралцах үйл явцын төрөл.

Хийнгээ суралцах үйл явц /кинестэтик сургалт/	Лекц сонсох зэргээс илүү үйлдэл хийж, өөрөө гүйцэтгэх аргаар сурах үйл явц.
Худалдаалах	Бараа бүтээгдэхүүний боолт, шошго, жишиг бүтээгдэхүүн үнэгүй тараах, үзүүлэн худалдах, үнийн бодлого, тусгай үнэ санал болгох зэрэг борлуулалтын арга хэрэгслийг ашиглаж богино хугацаанд жижиглэн худалдаалах үйл ажиллагааг хэлнэ.
Хүний эрх	Хүний мөн чанар, нэр төрийг хамгаалахын тулд заавал хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн эрх ба хамгаалалт. Эдгээрийг улс үндэстний болон олон улсын баримт бичигт тодорхой тусгасан байдаг. (жишээлбэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Европын Хүний Эрхийн Конвенц, Хүүхдийн эрхийн конвенц гэх мэт). Үүнд мөн хэсэг бүлэг хүний эрхийг хамгаалах асуудал, тухайлбал ядуу болон нийгмийн цөөнхийн эрхийн асуудал яригдана.
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Олон түмний мэдээллийн хэрэгсэл дотроос цаг үеийн үйл явдлын мэдээллийг олон түмэнд хүргэдэг хэрэгслийн төрөл нь. Үүнд хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл (жишээлбэл сонин, сэтгүүл), өргөн нэвтрүүлгийн байгууллага (радио, телевиз) болон сүүлийн үед улам бүр өсөн нэмэгдэж буй Интернетэд суурилсан мэдээллийн хэрэгсэл (жишээлбэл www хуудас болон блог) орно.
Хэвлэлийн эрх чөлөө	Хэвлэмэл төдийгүй бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл аливаа цензур, төрийн хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулах эрх чөлөө. Үүнд төрийн зүгээс тухайлбал дангаарноёрхлыг хязгаарлах, эсвэл өргөн нэвтрүүлгийн эрх олгох зэргийн зохицуулалт хамаарахгүй.
Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэл	Цаг үеийн мэдээллийг цуглуулж, сонин, сэтгүүлд буюу цаас, бэхний оролцоотойгоор хэвлэн нийтэлдэг мэдээллийн хэрэгсэл.
Хэвшмэл ойлголт / стереотип	Нийгэм, соёлын тодорхой төлөөлөгчдийн хялбар танигдахуйц шинж чанарыг нь ашиглаж төлөөлүүлэн дүрслэх мэдээллийн хэрэгслийн түгээмэл арга. Эерэг болон сөрөг ач холбогдолтой байж болно.
Хэм хэмжээ	Энэ үгийг мэдээллийн хэрэгсэлтэй холбоотойгоор ашиглах тохиолдолд хувь хүний тодорхой зан үйлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг хэм хэмжээг хэлнэ.
Хэрэглэгчийн бэлтгэсэн агуулга (UGC)	Цахим мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчдийн бүтээсэн, олон нийтэд хүртээмжтэй төрөл бүрийн агуулга.

Цахим суурь
боловсрол

Цахим технологи, мэдээлэл харилцааны хэрэгсэл болон сүлжээг мэдээлэл олох, үнэлж цэгнэх, ашиглах, бүтээхэд хэрэглэх чадвар. Үүнд мөн олон төрлийн эх сурвалжаас авсан олон янзын хэлбэр бүхий мэдээллийг ойлгож, ашиглах, цахим орчинд шаардлагатай үйлдлийг үр дүнтэйгээр гүйцэтгэх чадвар багтана. Цахим суурь боловсролд мөн мэдээллийн хэрэгслийг уншиж, ойлгох, мэдээллийг цахим аргаар дахин бүтээх болон өөрчлөх, үнэлж дүгнэх, цахим эх сурвалжаас олж авсан шинэ мэдлэгийг ашиглах чадвар хамаарна.

Шавь төвтэй
боловсрол

Сурах үйл явцын төвд нь суралцагчийг байршуулдаг боловсролын хандлага. Энд хувь хүний хүсэл, хэрэгцээ шаардлага нь сурах үйл явц болон аливаа сургалтын хөтөлбөрт голлох үүрэг гүйцэтгэх бөгөөд сургалтын орчинд суралцагч ямар туршлагатайгаар ирж буйд маш чухал ач холбогдол өгнө. Энэхүү хандлага болон арга барилд суралцагчийн оролцоо, бусадтай хамтран ажиллаж, сурах үйл явцад хувь нэмэр оруулах явдал чухал хэмээн үздэг.

Шүүмжлэлт сэтгэлгээ

Мэдээлэл, утга санааг шууд хүлээн авах бус, харин түүний үнэ цэнэ, цаад утгыг ойлгож авахын тулд шинжлэн дүгнэх чадвартай байхыг хэлнэ.

Эрх тэгш байдал

Хүн бүр нас, хүйс, шашин шүтлэг, үндэс угсаагаасаа үл хамаарч ижил эрхийг эдлэх ёстой гэсэн үзэл санаа. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үндсэн зарчим болох энэхүү санааг “хүмүүний нийгмийн гишүүн бүрийн төрөлхийн нэр төр, эрх тэгш, маргашгүй бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхийн эрх чөлөө, шударга ёс, энх тайвны үндэс суурь мөн” хэмээн илэрхийлсэн байдаг.

World Wide Web

Интернэтийн тусламжтайгаар үзүүлдэг үйлчилгээ бөгөөд асар их хэмжээний агуулгыг гурван үндсэн хэрэглүүрийн тусламжтайгаар Интернэтэд байршуулах боломжийг олгодог. Үүнд: цахим аргаар нийтлэх формат буюу HTML; мэдээлэл тус бүрт хаяг олгох, (URL); мэдээллийг дамжуулах суваг буюу http ордог.

YouTube

Хэрэглэгчид өөрийн хүссэн бүхий л төрөл, сэдвийн хөдөлгөөнт дүрсийг байршуулах боломжтой цахим хуудас.

Бидний амьдарч буй өнөөгийн нийгэмд аливаа сонголт болон түүнээс үүдэх үйлдэл, тухайлбал хүний үндсэн эрхээ эдлэх, хувь хүний хөгжлийн замаа тодорхойлох боломж нь бидний хүлээн авч буй мэдээллийн чанараас ихээхэн хамаарч байна. Мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн суурь боловсролын багш нарт зориулсан энэхүү сургалтын хөтөлбөр нь гишүүн орнуудын хувьд чухал бөгөөд шинэлэг зүйл юм.

Нэгдүгээрт, уг баримт бичиг нь радио, телевиз, Интернет, сонин, ном, цахим архив болон номын сан өөр хоорондоо уусан нэгдэж буй өнөөгийн нөхцөлд тулгуурлан ирээдүйг харж, ингэснээр МХМСБ-д мэдээллийн хэрэгслийг цогцоор нь хамруулсан анхны оролдлого юм.

Хоёрдугаарт, энэхүү хөтөлбөрийг багш нарт тусгайлан зориулж, багш бэлтгэх албан ёсны боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх зорилготойгоор боловсруулсан бөгөөд ингэснээр олон сая залуу хүнийг чадавхжуулах үйл явцын эхлэлийг тавьж буй юм.

Енис Кэрклинс, Мэдээлэл, Харилцаа Холбоо хариуцсан дэд захирал,
ЮНЕСКО

www.unesco.org/webworld



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

Мэдээлэл Харилцаа
Холбооны хөтөлбөр

ISBN 978-92-3-001115-4



9 789230 001115 4